| Саванд бодис хийхийн өмнө аюултай бодисыг цэвэрлэж, идэвхгүй хийгээр сольсон уу? Агааржуулсан уу?<br>입조작업 전 위험물질방출 및 차단, 불활성가스 치환, 환기 등은 적절하게 이루어졌는가? | | |
| Саванд бодис хийхийн өмнө хүчилтөрөгч болон аюултай хийн нягтралыг хэмжсэн үү? 입조작업 전 산소 및 유해가스농도는 측정하는가? | | |

# Хадгалах сав ашиглах үед гардаг ослууд

저장탱크 작업 중 재해사례

## Жишээ 1 재해사례 1

## Хадгалах саванд залгах труба гагнуураар тайрч байгаад тэсрэх

저장탱크에 배관 설치 용단작업 중 폭발

3 ажилчин химийн бодис хадгалж байсан хуучин саванд труба залгахын тулд трубаг ганууураар тайрч байв. Гэтэл хадгалах саван дотор хуримтлагдсан хүхэрлэг түлшний шатамхай уур гагнуурын очинд асаж дэлбэрчээ(2 хүн нас барж, 1 хүн гэмтсэн.)

중고로 들어온 저장탱크 배관을 설치하기 위해 작업자 3명이 용단 작업을 하던 중 저장탱크 내 잔류하고 있던 벙커C유 인화성 증기에 용접. 불티가 점화되어 폭발(사망 2, 부상 1)



### Урьдчилан сэргийлэх арга хэмжээ 예방대책

- Хүхэрлэг түлш мэтийн шатамхай бодистой хадгалах сав нь дэлбэрэх, гал гарах магадлал өндөр байдаг тул оч болон нум үүсгэдэг багажаар ажил гүйцэтгэхийг хориглоно.
  벙커C유 등 인화성 물질이 있는 저장탱크는 폭발 또는 화재가 발생할 우려가 높으므로 불꽃 또는 아크를 발생하거나 화기작업을 금지
- Аюултай бодис, шатамхай бодистой байж болох цистерн, труба, цилиндр зэрэг саванд гал хүргэхээс өмнө шатамхай бодисыг асгасны дараа цэвэрлэх буюу идэвхгүй хийгээр солих зэрэг аюулгүйн арга хэмжээ авна.
  위험물 또는 인화성 유류 등이 존재할 위험이 있는 탱크, 배관, 드럼 등의 용기에 화기작업을 실시할 때에는 인화성 물질 제거 후 세정작업 또는 불활성 가스로 치환하는 등의 안전조치를 실시

## Жишээ 2 재해사례 2

## Шатамхай бодистой хадгалах савны орой дээрээс дэлбэрэлтэнд өртөж унах

인화성 물질 저장탱크 상부의 화재·폭발로 떨어짐

Ажилчин шатамхай бодис хийсэн 6 метр өндөр хадгалах саван дээр гарч, саван дахь бодис хэр хэмжээтэй байгааг мэдэхээр амсар луу нь тонгойж асаагуураа асаажээ. Гэтэл амсраар нь гарч ирсэн шатамхай ууранд асаагуурын гал авалцан дэлбэрч ажилчин газар унасан байна.

높이 6미터의 인화성 물질 저장탱크 상부에서 맨홀을 통해 내부 유량을 점검하기 위해 라이터를 켜는 순간, 맨홀을 통해 증발한 인화성 증기에 점화되면서 화재·폭발이 발생하여 그 충격에 의해 지면으로 떨어짐



### Урьдчилан сэргийлэх арга хэмжээ 예방대책

- Шатамхай уурнаас үүдэн гал гарах дэлбэрэх магадлалтай газар гал хэрэглэхийг хориглоно. Онцгой тохиолдолд тэсрэлтийн хамгаалалттай гар чийдэн хэрэглэнэ.
  인화성 증기로 인한 화재·폭발 위험이 있는 장소에서는 직접 점화원이 될 수 있는 화기의 사용을 금지하고 부득이한 경우 방폭형 손전등을 사용
- Автомат хэмжигчийн хэвийн ажиллагааг хангана. Ажилчдыг шаардлагагүй үед аюултай газар ойртохыг хориглоно.
  자동 계측장치는 항상 그 기능을 유지토록 하여 근로자가 불필요하게 위험 장소에 접근하는 것을 방지

OPEN 공공누리

Тоног төхөөрөмж 설비별

Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах
작업 전 안전점검

# Таазны кран
천장크레인

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다

2016 - 교육미디어 - 844

Mongolia

Пралель хоёр ханаы дагуу зам тавьж, тус замын дагуу шулуун хөдлөх дамнуурга суурилуулна. Дамнуурга нь өргөх болон буулгах төхөөрөмжтэй тэргэнцрээр тоноглогдсон байх бөгөөд тэргэнцрээс дэгээг буулган иржачааг өргөх буюу зөөдөг энэхүү механизмыг таазны кран гэдэг.
서로 마주보는 벽을 따라 레일을 부설하고, 이 레일에 직각으로 주행하는 빔(beam)을 걸친다. 이 빔에 권상 및 횡행장치를 갖는 트롤리(trolley)가 부설되어 트롤리로부터 훅(hook)를 내려서 중량물을 인양 운반하는 기계기구이다.

## Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд
주요 유해·위험 요인

- Тороос тасарснаас ачаа унах
  와이어로프의 파단으로 중량물이 떨어짐
- Дэгээнээс оосорлогч хэрэгсэл мултарч ачаа унах 훅에서 보조 달기구 이탈로 인하여 중량물 떨어짐
- Ачаа зөөх үеэр хөдөлж буй ачаа хүн мөргөх
  중량물 운반 시 작업자와의 중량물의 부딪힘
- Зам руу зөвшөөрөлгүй орох, замыг засах болон шалгах үеэр унах
  주행레일 상부에 임의 출입 또는 정비 · 보수작업 중 떨어짐



## Аюулгүй байдлыг шалгах хуудас 안전점검 체크리스트

| Шалгах зүйл<br>점검항목 | Шалгалтын үр дүн<br>점검결과 | Авсан арга хэмжээ<br>조치사항 |
|---|---|---|
| Тороос, гинж, оосорлогч төхөөрөмж элэгдэж гэмтсэн байна уу?<br>와이어로프 또는 체인, 줄걸이 용구의 마모 및 손상이 없는가? | | |
| Зам дээр засвар үйлчилгээ шалгалт хийхдээ хамгаалалтын бүс зүүх зэрэг унахаас сэргийлэх арга хэмжээ авсаны дараа ажлаа хийж байна уу?<br>주행레일 상부에서 수리·점검시 안전대 등 추락방지조치 후 작업을 하고 있는가? | | |
| Таазны краны даац хязгаарлагч хэвийн ажиллаж байна уу?<br>천장크레인에 과부하방지장치는 정상적으로 작동하는가? | | |
| Таазны краны хэт өргөхөөс хамгаалдаг төхөөрөмж хэвийн ажиллаж байна уу?<br>천장크레인에 권과방지장치는 정상적으로 작동하는가? | | |
| Удирдлагын дүүжин самбарын ослын зогсолтын товчлуур хэвийн ажиллаж байна уу? 펜던트스위치에 비상정지버튼은 정상적으로 작동하는가? | | |
| Удирдлагын дүүжин самбар гэмтэж эвдэрсэн байна уу?<br>펜던트스위치는 손상되거나 파손된 곳이 없는가? | | |
| Дэгээнд түгжээ байна уу?<br>훅 해지장치는 부착되어 있는가? | | |
| Өдөр бүр ажил эхлэхийн өмнө тоормос, авцуулагч, тороосны бүрэн бүтэн байдлыг шалгаж байна уу? 매일 작업 시작 전 브레이크, 클러치, 와이어로프의 이상여부를 점검하는가? | | |
| Таазны краныг газардуулсан байна уу?<br>천장크레인은 접지가 되어 있는가? | | |
| Таазны кранаар хүнд ачаа өргөхдөө краны даацын хязгаарыг мөрдөн ажиллаж байна уу? 천장크레인으로 중량물 인양 시 정격하중을 준수하는가? | | |
| Краныг зөвхөн оператор нь ажиллуулж байна уу?<br>크레인 운전은 지정된 근로자만 하는가? | | |
| Ажилчин хамгаалалтын гутал, хамгаалах дуулга өмсөж байна уу?<br>작업자는 안전화, 안전모를 착용하고 있는가? | | |

# Таазны краны аюулгүй ажиллагаа

## 천장 주행 크레인의 안전작업

## Дүүжин удирдлагын самбартай таазны кран ажиллуулах 지상조작식(펜던트 스위치 조작식) 천장주행크레인의 운전

- Таазны краныг зөвхөн томилсон оператор нь ажиллуулна. Операторт ажлын арга техник, аюулгүй ажиллагааны талаар зааж сургана.
  운전은 지정된 자만 수행하며, 근로자에게는 작업요령 등 안전조작에 관한 사항을 충분히 교육한다.
- Дүүжин хяналтын самбарын кабель, товчлуурын ажиллагааг шалгана.
  펜던트 스위치의 케이블, 누름버튼 스위치의 동작상태를 점검한다.
- Ажилчин, өргөсөн ачаатай хамт явах ёстой тул явах бүсийг тогтоож, аюулгүй байдлыг хангана.
  매단 물체와 함께 이동해야 하므로 보행지역을 정하고 이동범위의 여유 공간 등을 확보한다.
- Кран ажиллаж байх үед краныг түр зогсоож ачаа оосорлохдоо дүүжин хяналтын самбарыг унтраасны дараа ажиллана.
  운전 중에 크레인을 일시 정지하고 줄걸이작업 등을 할 때에는 펜던트 스위치의 조작전원을 끈 후 작업한다.
- Краны хөдлөх чиглэл болон дүүжин хяналтын самбарын чиглэлийг хянангаа товчлуурыг ажиллуулна.
  크레인의 운전방향과 펜던트 스위치의 방향을 확인하면서 스위치를 조작한다.

## Удирдлагатай таазны кран ажиллуулах 무선조작식 천장주행크레인의 운전

- Краныг зөвхөн томилсон оператор нь ажиллуулна. Операторт ажлын арга техник, аюулгүй ажиллагааны талаар зааж сургана.
  운전은 지정된 자만 수행하며, 근로자에게는 작업요령 등 안전조작에 관한 사항을 충분히 교육하여야 한다.
- Удирдлагын товчлуур, гар унтраалгын ажиллагааг шалгана. Шалгах үедээ удирдлагын түлхүүрийг унтраах дээр тохируулна.
  제어장치의 누름버튼 스위치, 핸들 스위치 등의 동작상태를 확인하며, 이때의 전원용 키스위치는 꺼짐 상태로 한다.
- Алхаж явахдаа удирдаж болохгүй. Хэрвээ зайлшгүй алхаж явах шаардлага гарвал аюулгүй замаар явна.
  원칙적으로 걸어가면서 운전하지 않으며, 부득이 운전하면서 걸어가는 경우에는 안전통로를 사용한다.
- Ганцаараа ажиллаж байхдаа ачаа оосорлох болвол удирдлагын унтраалгыг дарж унтраана.
  단독작업으로 운전자가 줄걸이작업을 할 때 제어장치의 스위치를 꺼짐 상태로 둔다.
- Кран ажиллуулж байхад дүүжлээстэй ачаа хөдлөх, өөр зүйлтэй мөргөлдөх зэргээр осол гарах үед зугтан зайлж очих боломжтой аюулгүй газартай болох.
  운전 중 매단 물체의 흔들림, 다른 물체의 접촉에 의한 재해 예방을 위해 안전한 피신거리를 확보한다.
- Удирдлагыг оператор өөртөө авч явах ёстой бөгөөд ажил дуусах, амрах үед тогтсон газар хадгална.
  제어장치는 항상 운전자가 소지해야 하며 작업종료, 휴식 시에 지정된 장소에 보관한다.






Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах
작업 전 안전점검

# Зөөврийн кран
이동식 크레인

Тоног төхөөрөмж 설비별

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 845

Mongolia

Зөөврийн краныг аж үйлдвэр, барилга үйлдвэрийн салбарт, хүнд жинтэй ачааг зөөх, ачих, буулгах зориулалтаар өргөнөөр хэрэглэдэг. Ажил олгогч болон ажилчид зөөврийн краны талаар мэдлэг дутмаг, мөн аюулгүй ажиллагааны журмыг мөрддөггүйгээс олон тооны осол гардаг.
제조·건설 등 여러 분야에서 중량물의 운반·적재·하역용으로 널리 사용되고 있으나, 사업주 및 근로자의 이동식 크레인에 대한 위험성 인식 부족, 안전수칙 미준수 등으로 재해 발생 빈도가 높다.

## Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд 주요 유해·위험 요인

- Тулаас хийсэн газрын гадаргуу цөмөрч кран онхолдох
  아웃트리거가 설치된 연약지반이 침하되면서 넘어짐
- Зөөврийн краны байрлал болон сумны уртад бусад ажлын радиус болон өргөх даацыг харгалзан үзэлгүйгээр ажиллаж байгаад унах
  위치 및 붐 길이에 따른 작업 반경 및 인양하중을 고려하지 않은 상태로 작업 중 무너짐
- Зөөврийн краны зарим гол бүтэц хэсгийг сайн шалгаагүйгээс осол гарах
  주요 구조부 점검 미흡에 따른 재해 위험
- Ачааг өргөх өндөр хүчдэлийн утсанд хүрэх, ачаа унах
  화물 인양 중 고압선 접촉, 화물 떨어짐



## Аюулгүй байдлыг шалгах хуудас 안전점검 체크리스트

| Шалгах зүйл 점검항목 | Шалгалтын үр дүн 점검결과 | Авсан арга хэмжээ 조치사항 |
|---|---|---|
| Хамгаалах дуулга, хамгаалалтын гутал зэрэг хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэж байна уу? 안전모, 안전화 등 개인보호구를 착용하였는가? | | |
| Газрын гадаргуу цөмрөх аюултай байна уу? Цөмрөх аюултай бол ивээс бэлдсэн үү? 지반은 침하우려가 없는가? 있다면 받침대는 준비되었는가? | | |
| Ажил эхлэхийн өмнө гол бүтэц хэсгийн залгаас, холбоос сайн чангалагдсан эсэхийг шалгасан уу? 작업시작 전 본체 주요부의 조임·연결 상태 등을 점검하였는가? | | |
| PTO-г асаагаагүй үед бүх жолоодлогын гар дунд хэсэгт байрлаж байна уу? PTO를 켜지 않은 상태에서 모든 작동 레버는 중립에 위치하고 있는가? | | |
| Тулаас газрын гадаргуутай тэгшхэн байна уу? 아웃트리거는 지면과 수평을 유지하고 있는가? | | |
| Бүх төрлийн хэмжигч, заагч, тохируулагч, аюулгүйн төхөөрөмжүүд хэвийн ажиллаж байна уу? 각종 계기, 지시계, 조정장치, 안전장치는 정상 작동하는가? | | |
| Ажлын бүсэд өөр хүн орохыг хориглосон байна уу? 작업반경내 근로자 출입을 통제하고 있는가? | | |
| Зөөврийн краны оператор даацын хүснэгтийн дагуу зөөх зайнаас хамаарч даацыг тохируулах чадвартай юу? 정격하중표의 거리별 하중능력을 숙지하고 있는가? | | |
| Ачаа өргөх оосорын тоо тохиромжтой юу? 중량물 체결 줄걸이 수는 적정한가? | | |
| Ажил дуусахад PTO зэрэг тохируулагч төхөөрөмжийг унтрааж байна уу? PTO 등 조정 장치는 OFF하였는가?(작업완료시) | | |

산업재해예방 안전보건공단

# Зөөврийн краны аюулгүй ажиллагаа

이동식 크레인 작업 시 안전

## Зөөврийн краныг суурилуулахдаа мөрдөх зүйл 이동식 크레인 설치 시 준수사항

- Ажлын байранд ямар нэг саадтай зүйл байгаа эсэхийг шалгаж, гадны хүн орохыг хориглоно.
  작업장 장애물을 확인하고 관계자 외의 출입을 통제한다.
- Тэсвэртэй эсэхийг шалгаж баталгаажуулсан гадаргуу дээр тулаасыг суурилуулна. Гулгахаас сэргийлэх болон нэмэлт бэхэлгээ шаардлагатай тохиолдолд ивээс болон дэвсгэр ашиглана.
  아웃트리거 설치 시 지지력을 확인한 견고한 바닥에 설치하고, 미끄럼 방지나 보강이 필요한 경우 받침이나 매트 등의 위에 설치한다.
- Зөөврийн краныг суурилуулахдаа тэгшхэн эсэхийг нь сайтар шалгана.
  이동식 크레인의 수평 균형을 확인하여 거치한다.




## Ажил эхлэхийн өмнө шалгах зүйл 작업 전 확인사항

- Сум, дэгээ зэрэг гол эд ангийг шалгаж, гэмтсэн бол засах буюу солино.
  지브, 훅 차체 등 주요부를 점검하고 이상 발견 시 수리, 교체 등의 조치를 한다.
- Ажлын байрны орчим өргөх ажилд саад болох зүйл байгаа эсэхийг шалгана.
  장소 주변의 인양작업에 간섭될 수 있는 장애물 여부를 점검한다.
- Краны даац болон өргөх ачааны жинг шалгаж, ажлын бүсэд гадны хүн орохыг хориглох арга хэмжээ авсан эсэхийг шалгана.
  정격하중과 인양물의 중량을 확인하고, 작업 반경 내에 관계자 외의 출입통제 조치를 확인한다.




## Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны журам 작업 전 안전수칙

- Ачаа дэгээнээс мултрахаас сэргийлж дэгээний түгжээ хэрэглэнэ.
  훅 해지장치를 사용하여 인양물이 훅에서 이탈하는 것을 방지한다.
- Зөөврийн кран ачаа өргөж байхдаа онхолдохоос сэргийлж тулаасыг зөв суурилуулсан эсэхийг шалгана.
  크레인의 인양작업 시 전도 방지를 위하여 아웃트리거 설치 상태를 점검한다.
- Зөөврийн кран үйлдвэрлэгчийн кран ашиглалтын стандартанд заасан, сумны өнцгөөс хамаарах даацын хэмжээг мөрдөнө. 이동식 크레인 제작사의 사용기준에서 제시하는 지브의 각도에 따른 정격하중을 준수한다.
- Татлага(тороос болон даавуун тууз), дэгээ, дэгээний түгжээ, хавчаарыг шалгана.
  슬링(와이어로프·섬유벨트 등), 훅 및 해지장치, 섀클 등의 상태를 수시 점검한다.
- Хэт дээшээ өргөхөөс хамгаалах төхөөрөмж, даац хязгаарлагч зэргийг тогтмол шалгана.
  권과방지장치, 과부하방지장치 등의 방호장치를 수시 점검한다.
- Ачааны хэлбэр, жин, онцлогоос хамаарч зохих аюулгүйн арга хэмжээг авах бөгөөд оосорлогч тороосны өнцөг нь 60 градусаас ихгүй байна.
  인양물 형상, 무게, 특성에 따른 안전조치와 줄걸이 와이어로프의 매단 각도는 60˚이내로 한다.
- Ачааг өргөх үед дохиологч томилж, оператор дохиологчийн дохионы дагуу өргөх ажлыг гүйцэтгэнэ.
  인양작업 시 신호수를 배치하며, 운전원은 신호수의 신호에 따라 인양작업을 수행한다.
- Өргөсөн ачаа ямар нэгэн зүйлийг мөргөхөөс сэргийлж чиглүүлэх дээс ашиглана.
  인양물의 충돌 등을 방지하기 위하여 인양물을 유도하기 위한 보조로프를 사용한다.
- Урт ачааг хэлбийлгэхгүй тэгш хэмийг нь хадгалж өргөнө.
  긴 자재는 경사지게 인양하지 않고 수평을 유지하여 인양토록 한다.

OPEN 공공누리

Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах
작업 전 안전점검

# Өндөрт байрлах ажлын тавцан(Өөрөө явагч)
고소작업대(차량 탑재형)

Тоног төхөөрөмж 설비별

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다

2016 - 교육미디어 - 846

Mongolia

Өндөрт байрлах ажлын тавцан гэж тавцан, сунадаг төхөөрөмж, өргөгч механизмаас бүрддэг, ажилчныг ажлын байранд зөөж хүргэдэг тоног төхөөрөмж юм. Өөрөө явагч өргөгч тавцан нь ажилчныг сагсанд суулгаад цахилгааны хүчээр, сумыг сунган дээшлүүлдэг бөгөөд байшингийн гадна ханаы ажил, шил суулгах, хаяг хадах, засах зэрэг өндөрт гүйцэтгэх ажилд, барилгын талбайд ихэвчлэн хэрэглэгддэг.
고소작업대란 작업대, 연장구조물(지브), 차대로 구성되며 사람을 작업 위치로 이동시켜주는 설비를 말한다. 차량 탑재형은 작업대에 작업자를 탑승시킨 상태에서 동력을 이용·붐대를 상승시켜 건물 외벽공사, 유리공사, 간판 설치·보수작업 등의 고소작업을 하는 장비로 주로 건설현장에서 사용된다.

## Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд 주요 유해·위험 요인

- Зөвшөөрөгдсөн радиуснаас хэтрэх буюу тулаасыг буруу хийснээс болж хөмрөх
  허용 작업반경 초과 또는 아웃트리거 설치불량 등으로 넘어짐
- 1 үет сумны холбоос хэсэг хугарах, сум сунгах тороос тасрах зэргээс болж тавцан унах
  1단 붐 용접부 파단, 붐 인출 와이어로프 파단 등으로 작업대 떨어짐
- Хамгаалалтын хашлага хийгээгүйгээс ажилчин унах
  안전난간 미설치 등으로 작업자 떨어짐
- Тавцанг хэт өндөр өргөснөөс болж ажилчин хавчуулагдах
  작업대 과상승으로 인한 끼임



## Өндөрт байрлах ажлын тавцанд хэрэглэдэг хамгаалах төхөөрөмж(Өөрөө явагч)
고소작업대에 사용되는 주요 방호장치(차량탑재형)



Нэгдсэн хяналт, монитор
통합 컨트롤러 및 모니터



Ачаа хязгаарлагч төхөөрөмж(ачаалалын датчик)
과부하방지장치(로드셀)



Сумны уртыг мэдрэгч төхөөрөмж
붐 길이센서



Сумны өнцгийг мэдрэгч төхөөрөмж
붐 각도센서



Сум болон тулаасны холбоос цоож
붐, 아웃트리거 인터록 장치



Тулаасны мэдрэгч төхөөрөмж
아웃트리거 감지 센서



Эргэлтийг мэдрэгч төхөөрөмж
선회 감지센서




Ослын зогсолтын товчлуур
비상정지장치

# Өндөрт байрлах ажлын тавцан дээр ажиллах үед аюулгүй байдлыг хангах

## 고소작업대 사용 작업 시 안전

## Ихэвчлэн гардаг ослуудаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ 주요 발생형태별 안전대책

### Хөмрөх
넘어짐 위험

1. Ачаа хязгаарлагч төхөөрөмж, момент мэдрэгч төхөөрөмж зэргийг суурилуулж, хэвийн ажиллагаар хангах.(Хамгаалах төхөөрөмжийг хамаагүй салгахыг хориглох)
   과부하방지장치, 모멘트 감지장치 등을 설치하고 기능을 정상적으로 유지 (방호장치 기능 임의해제금지)
2. Сумны сунах уртад харгалзах өнцөг, даацыг чанд мөрдөх.
   붐 인출 길이에 따른 각도, 적재하중 준수
3. Тулаасыг найдвартай зөв суурилуулж ашиглах(ивээсийн тэгш байлгах)
   아웃트리거의 확실한 설치·사용 (발판 수평유지)



### Тавцан доош унах
작업대 떨어짐 위험

1. 1 үет сумны холбоос хэсэгт ан цав гарсан эсэхийг шалгах(Гаднах байдлаар нь буюу рентгэн төхөөрөмжөөр)
   1단 붐 용접부 균열발생 여부 점검(육안 및 비파괴검사)
2. Эргэх тавцангийн холбоос хэсэгт ан цав гарсан эсэхийг, мөн холбох боолтыг сайн чангалсан эсэхийг шалгах.
   턴테이블 용접부 균열발생 여부 및 볼트 체결상태 점검
3. Сум сунгах тороосны диаметрын элэгдлийн хэмжээ болон тороосны сүлжээ, тогтоогч эд ангийн бүрэн бүтэн байдлыг шалгах.
   붐 인출 와이어로프 직경감소, 단선 및 고정금구 파손여부 점검

### Тавцангаас унах
떨어짐 위험

1. Тавцангийн хамгаалалтын хашлагыг авч болохгүй.
   작업방향 안전난간 해제 금지
2. Хамгаалах бүсийг бэхлэх төхөөрөмжийг суурилуулж хэрэглэх.
   안전대 부착설비 설치 및 사용 철저

### Хавчуулагдах
끼임 위험

1. Өндөр хязгаарлах төхөөрөмжийг ажлын нөхцөлд тохируулан тааруулах, тохируулгыг дураар цуцлахыг хориглох.
   작업환경에 맞게 과상승방지장치 작동높이 조정 및 임의해제 금지
2. Ажил гүйцэтгэх өндөрт гарсныхаа дараа ослын зогсолтын системийг ажиллуулах.
   작업위치(높이) 도달 후 비상정지장치 작동

Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах
작업 전 안전점검

# Өндөрт байрлах ажлын тавцан(Хайчин хэлбэртэй)
고소작업대(시저형)

Тоног төхөөрөмж 설비별

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 847

Mongolia

Өндөрт байрлах ажлын тавцан гэж тавцан, сунадаг төхөөрөмж, өргөгч механизмаас бүрддэг, ажилчныг ажлын байранд зөөж хүргэдэг тоног төхөөрөмж юм. Хайчин хэлбэртэй өргөгч тавцан нь ажилчныг тавцан дээр суулгаад моторын хүчээр хайчин хэлбэрт төхөөрөмжийг сунган дээшлүүлдэг бөгөөд таазны сантехник шугам засвар, гэрэл солих зэрэг ажилд ихэвчлэн хэрэглэгддэг.
고소작업대란 작업대, 연장구조물(지브), 차대로 구성되며 사람을 작업 위치로 이동시켜주는 설비를 말한다. 시저형은 작업대에 작업자를 탑승시킨 상태에서 동력을 이용·가위형 구조물을 상승시켜 천장배관 보수, 전등교체 등의 고소작업을 하는 곳에 주로 사용된다.

## Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд
주요 유해·위험 요인

- Тулаасыг буруу хийснээс болж өргөгч тавцан хөмрөх
  아웃트리거 설치불량 등으로 넘어짐
- Хамгаалалтын хашлага суурилуулаагүйгээс ажилчин унах
  안전난간 미설치 등으로 작업자 떨어짐
- Тавцанг хэт өргөсний улмаас ажилчин тааз, тавцан хоёрын хооронд хавчуулагдах
  작업대 과상승으로 인한 끼임



## Өндөрт байрлах ажлын тавцанд хэрэглэдэг хамгаалах төхөөрөмж(хайчин хэлбэртэй)
고소작업대에 사용되는 주요 방호장치(시저형)



Ачаа хязгаарлагч төхөөрөмж(Даралтат шилжүүлэгч)
과부하방지장치(압력스위치)



Доош унахаас хамгаалах хавхлага(Хамгаалалтын хавхлага)
낙하방지밸브(안전밸브)



Хурд хязгаарлагч
주행속도 제한장치



Налуут заагч төхөөрөмж (Тэгш усны мэдрэгч)
경사표시장치(수평감지센서)



Ослын зогсолтын товчлуур болон удирдлагын хөшүүргэ цоожлох төхөөрөмж
비상정지장치 및 조작레버 잠금장치



Ослоос хамгаалах төхөөрөмж(Буулгагч хавхлага)
비상안전장치(하강밸브)



Аюулгүйн блок
안전블록



Өндөр хязгаарлах төхөөрөмж
과상승방지장치

# Өндөрт байрлах ажлын тавцан дээр ажиллах үед аюулгүй байдлыг хангах

고소작업대 사용 작업 시 안전

## Голчлон гардаг ослуудаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ 주요 발생형태별 안전대책

### Хөмрөх
넘어짐 위험

1. Ачаа хязгаарлагч төхөөрөмж, өндөр хязгаарлагч төхөөрөмж зэргийг суурилуулж, хэвийн ажиллагаар хангах.(Хамгаалах төхөөрөмжийг дураар салгахыг хориглох)
   과부하방지장치, 과상승 방지장치 등을 설치하고 기능을 정상적으로 유지
   (방호장치 기능 임의해제금지)
2. Өндөрт байрлах ажлын тавцанг байрлуулах гадаргууны налуу болон тэгш байдлыг шалгах.
   고소작업대를 설치할 바닥 경사 및 평탄상태 확인
3. Тулаасыг найдвартай зөв суурилуулж ашиглах(ивээсийн тэгш байлгах)
   아웃트리거의 확실한 설치·사용(발판 수평유지)

### Тавцан доош унах
작업대 떨어짐 위험

1. Тавцанг доош унахаас хамгаалах хамгаалалтын хавхлага суурилуулж хэвийн ажиллагаар хангах.
   작업대의 떨어짐을 방지하기 위한 낙하방지밸브를 설치하고 정상적으로 유지
2. Гагнасан хэсэгт ан цав гарсан эсэхийг шалгах, эрэг боолтыг найдвартай эрэгдсэн эсэхийг шалгах.
   용접부 균열발생 여부 및 볼트 체결상태 점검

### Тавцангаас унах
떨어짐 위험

1. Тавцангийн хамгаалалтын хашлагыг авч болохгүй.
   작업방향 안전난간 해제 금지
2. Хамгаалах бүсийг бэхлэх төхөөрөмжийг суурилуулалт болон ашиглалт
   안전대 부착설비 설치 및 사용 철저



### Хавчуулагдах
끼임 위험

1. Өндөр хязгаарлах төхөөрөмжийг ажлын нөхцөлд тохируулан тааруулах, тохируулгыг дураар цуцлахыг хориглох.
   작업환경에 맞게 과상승방지장치 작동높이 조정 및 임의해제 금지
2. Ажил гүйцэтгэх өндөрт гарсныхаа дараа ослын зогсолтын системийг ажиллуулах.
   작업위치(높이) 도달 후 비상정지장치 작동

OPEN 공공누리

Тоног төхөөрөмж 설비별

Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах
작업 전 안전점검

# Ажлын лифт
일반 작업용 리프트

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 848

Mongolia

Моторын хүчээр хамгаалалтын хашлагын дагуу хөдөлдөг өргөгч тавцантай, ачаа зөөх зориулалттай зөөврлөх төхөөрөмжийг ажлын лифт гэдэг. Ажлын лифт нь барилгын талбараас бусад газар ашиглагдаж байна.
일반 작업용 리프트란 동력에 의하여 가이드레일을 따라 움직이는 운반구를 사용하여 사람이 탑승하지 않고 화물을 운반하기 위한 설비 또는 이와 유사한 구조 및 성능을 가진 것으로 건설현장 외의 장소에서 사용하는 것을 말한다.

## Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд 주요 유해·위험 요인

- Өргөгч тавцан, лифтны үүд, шалны завсар хавчуулагдах
  운반구와 승강로 구조물 및 바닥면 사이에 깔림
- Шалгах, засвар үйлчилгээ хийх үеэр нээлхий болон өргөгч тавцангаас унах
  점검·보수시 개구부 또는 운반구에서 떨어짐
- Өргөгч тавцанд суусан үед гинж, дэгээ, тороос тасарч доош унах
  운반구 탑승 중 체인, 훅, 와이어로프 파단으로 떨어짐
- Хамгаалалтын хашлаганд зогсож байсан өргөгч тавцанг буруу удирдсанаас болж доош унах
  운반구가 레일 등에 끼여 있는 상태에서 오조작시 운반구 떨어짐





Лифт ашиглах
리프트의 예

## Аюулгүй ажиллагааны журам 안전수칙

- Лифтэнд хүн суухыг хориглоно.
  운반구에 작업자 탑승을 금지한다.
- Даацын хязгаар хэтрүүлж болохгүй.
  정격하중을 초과하여 적재하지 않는다.
- Хаалганы холбоос цоож(хаалганы хязгаарлагч унтраалга)-ыг зөвшөөрөлгүйгээр салгах, ажиллагаагүй болгохыг хориглоно. 출입문 연동장치(입·출입구 리미트 스위치) 임의 제거, 기능 무효화 등 금지한다.
- Лифтээр явахдаа эвгүй дуугарах юм уу доргиж байгаа эсэхийг анхаарч явна.
  운행 중 이상음, 이상진동 등의 발생여부를 확인하면서 운행한다.
- Хаалгыг хөдөлгөх юм уу налах, хүчээр онгойлгож болохгүй.
  출입문을 흔들거나 기대거나 강제로 열지 않는다.
- Хэт дээшлэхээс хамгаалах төхөөрөмж(дээд, доод автомат зогсоох төхөөрөмж) суурилуулж хэвийн ажиллагааг хангана.
  권과방지장치(상, 하한 자동정지장치)를 설치하고 기능을 정상으로 유지한다.
- Өргөгч тавцан болон лифтны үүдний завсар гадны биет орсон эсэхийг тогтмол шалгана.
  운반구와 승강로 사이에 이물질 삽입여부 수시로 확인한다.
- Ажил дууссаны дараа өргөгч тавцанг хамгийн доод давхарт зогсоож, тухайн өдрийн ажил дууссаны дараа тэжээлээс салгана.
  작업 종료 후 운반구는 최하층에 위치하고, 일일 작업종료 후에는 주전원을 차단한다.
- Тэнцвэртэй байдлыг хадгалахын тулд ачааг өргөгч тавцангийн голд ачина.
  화물은 운반구의 중앙부분에 적재하여 편심을 방지한다.
- Засвар үйлчилгээ хийх, шалгах үед гол тэжээлийг салгаж, “Шалгаж байх үед ажиллуулж болохгүй” гэсэн тэмдэг хадна.
  정비, 점검, 보수 등의 작업 시에는 주 전원을 차단하고, “점검 중 조작금지”표지(꼬리표)를 게시한다.
- Лифт болон өргөгч тавцан хаалга хийж, хаалга онгойход өргөгч тавцан зогсохоор холбоос цоож хийнэ.
  승강장과 운반구에 출입문을 설치하고, 문을 열 경우 운반구가 정지되도록 연동을 시킨다.

# Ажлын лифтны аюулгүй ажиллагаа

일반 작업용 리프트 사용 안전

## Хамгаалах төхөөрөмжийн үүрэг 안전장치의 역할

- **Хаалганы холбоос цоож** 출입문 연동장치
  Өргөгч тавцангийн хаалга онгорхой үед тавцан дээш доош явахгүй байхаар хийсэн төхөөрөмж.
  운반구의 출입문이 열려 있는 상태에서 운반구 상승·하강이 되지 않도록 하는 장치
- **Хэт дээшлэхээс хамгаалах төхөөрөмж** 권과방지장치
  Өргөгч тавцан лифтны хамгийн дээд хэсэгт хүрэхийн өмнө хязгаарлах унтраалгыг ажиллуулж хөдөлгөөнийг зогсоодог төхөөрөмж.
  운반구가 승강기 최상부 도착 전 리미트 스위치가 작동하여 운전을 정지시키는 장치
- **Ослын зогсолтын төхөөрөмж** 비상멈춤장치
  Пүрш болон углуургын тусламжтайгаар тороос, гинж тасарсан үед өргөгч тавцанг доош унахаас сэргийлдэг төхөөрөмж.
  압축스프링과 멈춤핀을 이용한 안전장치로서 로프(또는 체인) 파단 시 멈춤장치가 작동하여 운반구의 추락을 방지하는 장치
- **Даац хязгаарлах төхөөрөмж** 과부하 방지장치
  Өргөгч тавцанд ачаар даац хэтрүүлэн ачих үед дуут дохио дуугарган, хөдөлгөөнийг автоматаар зогсоодог төхөөрөмж.
  운반구에 적재하중 초과적재 시 경보음을 내면서 작동을 자동으로 정지시키는 장치
- **Цохилт сааруулах төхөөрөмж** 완충장치
  Өргөгч тавцан унах юм уу доошоо хүчтэй буух үед цохилтыг сааруулахын тулд лифтны ёроолд суурилуулдаг пүрш(тосон вопер).
  운반구의 추락 또는 과하강 시 충격을 완화시키기 위하여 승강로 바닥면에 완충 스프링(또는 오일버퍼)을 설치
- **Дохионы гэрэл** 경광등
  Өргөгч тавцан ирснийг мэдэгддэг, ачих тавцан бүрт суурилуулан хэрэглэдэг улаан өнгийн гэрэл.
  운반구의 도착여부를 알리기 위하여 적색 경광등을 탑승장마다 부착 사용
- **Ачих тавцангийн холбоос цоожтой хаалга** 탑승구 연동문
  Ачих тавцангийн хаалга онгорхой үед өргөгч тавцан дээш доош явахгүй байхаар хийсэн төхөөрөмж
  탑승장의 출입문이 열려 있는 상태에서는 운반구의 상승·하강이 되지 않도록 하는 장치
- **Хамгаалалтын торон хаалт** 방호울
  Хүмүүсийг дотогш ойртохоос сэргийлэх, эд зүйл унах, ямар нэг зүйл саад хийхээс хамгаалахын тулд өргөгч тавцангийн явах замын гадна хэсгээр хийсэн төмөр утсан хаалт.
  운반구의 이동통로 외측면에 철망 또는 철판 등을 부착하여 신체의 내부접근, 부품의 낙하, 장해물 접근 등을 방지



Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах
작업 전 안전점검

# Шахах ажил
프레스

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 849
Mongolia

Материалыг богино хугацаанд маш их их хүчээр шахаж боловсруулалт хийдэг тул тус ажлыг гүйцэтгэх явцад анхаарал болгоомжоо алдвал амархан осолдож гэмтэнэ. Аюултай хэсэгт ойрхон зогсож ажилладаг болохоор бусад ажлыг бодвол эрсдэл ихтэй. Шахах боловсруулалтыг голдуу жижиг хэмжээний үйлдвэрүүдэд олон төрлийн, цөөн тооны бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэдэг. Тиймээс аюулгүй байдлын арга хэмжээг тийм ч сайн авдаггүй.
프레스작업은 단시간에 많은 힘을 가해 가공하므로 자칫하면 신체 장해를 입기 쉽다. 또한 위험 부위에 근접해 작업하는 경우가 많아 다른 작업에 비해 위험성이 크다. 프레스작업은 대부분 소규모 기업에서 이뤄지며 다품종 소량생산 위주여서 대체로 안전대책이 미흡하다.

## Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд 주요 유해·위험 요인

- Хамгаалах төхөөрөмжөөр тоноглоогүй шахагч машины хэвэнд хавчуулах 프레스 안전장치를 부착하지 않고 작업 중 금형 사이에 끼임
- Педал ашиглан хоёр гараараа бэлдэцээ оруулж, гаргах үед хэвэнд хавчуулах
  풋스위치를 사용해 양손으로 소재를 투입하고 꺼내는 작업 중 금형 사이에 끼임
- Бэлдэцийг хэвэнд нь сайн оруулалгүй шахаснаас болж бутарсан хэлтэрхийнд оногдох
  소재가 금형에 제대로 투입되지 않은 상태에서 프레스 가공 중 파손된 금형 파편에 맞음
- Хоёулаа ажиллаж байхдаа дохиогоо сайн ойлголцоогүйгээс бууж байгаа слайданд цохиулах
  2인이 공동작업 중 신호불일치로 하강하는 슬라이드에 부딪힘



## Аюулгүй байдлыг шалгах хуудас 안전점검 체크리스트

| Шалгах зүйл 점검항목 | Шалгалтын үр дүн 점검결과 | Авсан арга хэмжээ 조치사항 |
|---|---|---|
| Хэвийг засах, шалгах, солих үед аюулгүйн блок хэрэглэж байна уу? 금형 등의 수리·점검·교체작업 시 안전블럭이 사용되고 있는가? | | |
| Шахагчийн аюулгүйн төхөөрөмж(гар цохидог дарцаг, хаалт, хоёр гараар ажиллуулдаг хамгаалах төхөөрөмж) хэвийн ажиллаж байна уу? 프레스 안전장치(손쳐내기식, 가드식, 양수조작식 방호장치 등)는 정상적으로 작동하는가? | | |
| Ажил эхлэхийн өмнө ажлын хувцас өмсөж, ажлын байраа цэгцэлж, тоног төхөөрөмжөө шалгасан уу? 작업시작 전 복장, 작업장 정리정돈, 기계점검을 실시하였는가? | | |
| Дээд доод боолт, эргийг сайтар эргэдэж чангалсан байна уу? 상·하형 볼트 및 너트의 체결상태는 양호한가? | | |
| Тогтсон гар багажыг хэрэглэж байна уу? 정해진 수공구를 사용하는가? | | |
| Педалын дээд хэсэгт таглаа хийсэн байна уу? 풋스위치 상부에 덮개가 설치되어 있는가? | | |
| Ремень болон ээрцэг дугуйнд хаалт хийсэн байна уу? 벨트, 플라이 휠 등의 덮개는 부착되어있는가? | | |
| Залгуурын кабелийн цахилгаан тусгаарлагч гэмтэлгүй байна уу? 전원케이블 절연상태는 양호한가? | | |
| Ажилчин, чихний бөглөө, хамгаалалтын гутал өмссөн байна уу? 작업자는 귀마개, 안전화를 착용하고 있는가? | | |

산업재해예방 안전보건공단

# Шахагч машин ашиглах үеийн аюулгүй ажиллагаа

프레스 작업 안전

## Гол аюулгүй арга хэмжээ 주요 안전대책

Ажилчин, шахах ажлын үеэр хэв хооронд гараа хийх эрсдэл өндөр тул үүнээс хамгаалах арга хэмжээ авах хэрэгтэй.

프레스는 작업 중에 작업자가 금형 사이에 손을 집어넣는 등 위험성이 높기 때문에 위험 방지를 위한 조치가 필요하다.



- Бэлдэцийг гараар биш автомат төхөөрөмжөөр оруулах, эсвэл хаалт хийх зэргээр аюултай хэсэгт ойртохгүй байх арга хэмжээ авна.
  가공재 송급을 자동화하거나 가드를 설치해 위험한계 내에 신체의 일부 가 들어가지 않도록 한다.
- Аюултай хэсэгт гараа ойртуулах юм бол слайд автоматаар зогсох бүтэцтэй байх ёстой.
  손이 위험한계에 들어갔을 때는 슬라이드가 급정지하는 구조여야 한다.
- Гадны биетийг цэвэрлэх, засвар үйлчилгээ хийх үед шахагч машиныг унтрааж, тэжээлээс салгана.
  이물질 제거, 정비·수리 시 프레스 운전을 정지하고 전원을 차단한다.
- Шахагч машин асаах түлхүүр болон хамгаалах төхөөрөмжийн түлхүүрийг оператор нь өөрөө хадгалж хамгаална.
  프레스 행정 전환스위치 및 안전장치의 열쇠는 프레스작업 책임자가 보관 및 관리하도록 한다.
- Машин руу бэлдэцийг гараараа оруулж гаргадагыг болиулж анкойлор, левелер, фийдер зэрэг төхөөрөмжийг суурилуулж хэрэглэнэ.
  근로자가 직접 소재를 공급하거나 꺼내지 않도록 언코일러, 레벨러, 피더 등을 설치한다.
- Хэвийг солихдоо слайд доошоо унахаас хамгаалж аюулгүйн блок хийсний дараа ажлаа гүйцэтгэнэ.
  금형 교체 시 슬라이드의 하강을 방지하기 위해 안전블록을 설치한 후 작업을 실시한다.
- Педалын дээд хэсэгт таглаа хийж, өөр ажилчин мэдэлгүй дарах юм уу педал дээр юм унаж ажиллуулахаас хамгаална.
  풋스위치 상부에 덮개를 부착하여 작업자 실수에 의한 작동 또는 물건의 떨어짐으로 인한 오작동을 예방한다.
- Хавчуулах ослоос урьдчилан сэргийлэхийн тулд гар болон биеийн бусад хэсгийг хэв хооронд оруулж болохгүй. Үүний тулд бэлдэцийг машин руу оруулж гаргах үйлдлийг автоматжуулах нь хамгийн сайн арга боловч ингэх боломжгүй тохиолдолд гар багаж ашиглаж болно.
  끼임 재해를 예방하기 위해서는 작업자의 손 등 신체의 일부가 금형 사이로 들어가지 않도록 하는 것이 최선의 방법이다. 이를 위해 소재의 공급 및 배출을 자동화하는 것이 최선의 방법이나 이것이 불가능할 경우 수공구를 적절히 사용하는 것도 하나의 방법이다.




OPEN 공공누리

# Тайрагч
전단기



조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 850
Mongolia

Дээд болон доод талын ирний дундуур метал болон метал бус материал хийж тайрдаг машиныг тайрагч гэдэг. Тайрагч дээр ажиллаж байхдаа гар хуруугаа таслах эрсдэл их тул боловсруулах материалыг автоматаар оруулах болон гаргах төхөөрөмж суурилуулах, эсвэл тайрах шугам харагдаж, материал дотогш орсон байх үед хуруу тайрагчийн ирэнд хүргэхгүй байх хаалт татах хэрэгтэй. Хамгаалах төхөөрөмжийн хувьд фотоэлектрик болон хоёр гараар ажиллах гэсэн төхөөрөмжүүд бий.
전단기는 상·하의 칼날 사이에 금속 또는 비금속 물질을 넣고 전단하는 기계를 말한다. 전단기에 있어서는 작동중 날에 의한 수지(手指)를 절단할 위험이 많기 때문에 가공물의 자동송급 배출장치를 설치하거나, 절단선은 보이고 가공물은 들어가지만, 손가락은 날 부위에 닿지 않도록 울을 설치하는 것이 필요하다. 안전장치에는 광전자식, 양수조작식 등이 사용된다.

## Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд
주요 유해·위험 요인

- Ажилчин машины ир болон суурины дундуур(аюултай хэсэгт) гараа оруулснаас гар хуруугаа таслах
  작업 중 전단 날과 베드 사이(위험한계)에서 작업자 손 절단
- Хоёулаа ажиллах үеэр дохиогоо буруу авалцсанаас слайд унаж ажилчны гарыг таслах
  2인 1조 공동 작업 시 신호 불일치로 인한 슬라이드 불시 하강 등 작업자 손 절단




## Аюулгүй байдлыг шалгах хуудас 안전점검 체크리스트

| Шалгах зүйл 점검항목 | Шалгалтын үр дүн 점검결과 | Авсан арга хэмжээ 조치사항 |
|---|---|---|
| Ирний хамгаалалт байна уу? Фотоэлектрик хамгаалгаалалтын төхөөрөмж суурилуулсан байна уу? 전단 날 전면 방호가드, 광전자식 방호장치 등이 부착되어 있는가? | | |
| Ажилчин зогсож ажиллах ажлын тавцан хальтаргаатай байна уу? 작업용 발판의 보도면이 쉽게 미끄러지거나 넘어지지 아니한 상태인가? | | |
| Машиныг газардуулах зэрэг тогонд цохиулахаас сэргийлэх арга хэмжээ нь тохиромжтой байна уу? 기기 외함 접지 등 전기 감전 예방조치는 적절한가? | | |
| Ослын зогсолтын товчлуурыг хяналтын самбар болон бусад ослын зогсолт хийх шаардлагатай цэгүүдэд суурилуулсан байна уу? Хялбархан хүрэх газар байрлуулсан байна уу? 비상정지장치는 각 제어반 및 그 밖의 비상정지를 필요로 하는 개소에 설하되, 접근이 용이한 곳에 배치되어 있는가? | | |
| Жижиг, өргөн биш материалыг гар багажаар тайрч байна уу? 작고 폭이 좁은 소재는 수공구를 사용하는가? | | |
| Тайрагчийн педал дээр бүрхүүл хийсэн байна уу? 전단기의 발 조작용 페달에는 덮개는 부착되어있는가? | | |
| Хоёулаа ажиллахдаа аюулгүй ажиллахад хэрэг болох дохионы системтэй болсон уу? 2인1조 공동 작업 시 안전한 작업을 위한 신호는 확립되어있는가? | | |
| Ажлын байрны эргэн тойронд байх материал бусад зүйл эмх цэгцтэй байна уу? 작업장 주변은 자재, 이물질 등 정리정돈이 되어있는가? | | |
| Ажилчин, хамгаалалтын гутал, хамгаалалтын бээлий өмссөн байна уу? 작업자는 안전화, 보호장갑 등을 착용하고 있는가? | | |
| Засвар үйлчилгээ, цэвэрлэгээ хийхдээ тэжээлийг салгаж, “Ажиллуулахыг хориглоно” тэмдэг наадаг уу? 정비, 수리, 청소 등의 작업 시 전원차단 및 조작금지 표지를 부착하는가? | | |

산업재해예방 안전보건공단

Safety Point

Mongolia

# Тайрагч ашиглах үеийн аюулгүй ажиллагаа

전단기 안전작업

## Аюулгүй ажиллагааны журам 작업 안전수칙




- Фотоэлектрик болон хоёр гараар ажиллуулах хамгаалах хэрэгсэлээр тоноглогдсон эсэх, тоноглогдсон бол хэвийн ажиллаж байгаа эсэхийг ажил эхлэхээс өмнө шалгах хэрэгтэй.
  미동조작/양수조작식 안전장치가 부착되어 있으며, 정상 작동되는지 작업 전 확인해야 한다.
- Гэнэтийн ослын товчлуур хэвийн ажиллаж байгаа эсэхийг ажил эхлэхээс өмнө шалгах хэрэгтэй.
  비상정지스위치가 정상 작동되는지 작업 전 확인해야 한다.
- Тайрагчийн их биеийг газардуулсан эсэхийг шалгах хэрэгтэй. 전단기 외함에 접지가 되어 있는지 확인해야 한다.
- Педалын дээд хэсэгт аюулгүйн бүрхүүл хийсэн эсэхийг шалгах хэрэгтэй.
  페달 스위치 상부에 안전덮개가 부착된 것을 사용하는지 확인해야 한다.
- Хоёулаа ажиллах үед хоорондоо харилцах дохиог тодорхой ярилцаж тохирсны дараа ажиллаж байгаа эсэхийг шалгах хэрэгтэй.
  2인 1조 공동 작업 시 연락신호를 정확하게 한 다음 작업하는지 확인해야 한다.
- Жижиг, өргөн биш материалыг заавал гар багажаар тайрах хэрэгтэй.
  작고 폭이 좁은 소재는 반드시 수공구를 사용해야 한다.
- Төмөр хавтан буюу тайрсан төмөр хавтанг сэрээт ачигчаар зөөхдөө унахаас сэргийлэх арга хэмжээ авна. Орчин тойронд ажиллаж буй ажилчинг мөргөж, цохихгүйн тулд анхааралтай ажилла.
  철판이나 절단된 철판을 지게차로 운반할 때는 철판의 낙하를 방지하고 주위 작업 근로자와 충돌 하지 않도록 유의한다.
- Тайрагчинд засвар үйлчилгээ, шалгалт хийх, цэвэрлэхийн өмнө тэжээлээс нь салгана.
  전단기의 보수점검이나 청소작업 시에는 기계의 전원을 차단 후 실시한다.
- Хамгаалалтын гутал, чихний бөглөө, хамгаалалтын хувцас хэрэглэнэ.
  안전화, 귀마개, 지정작업복 등 보호 장구를 착용한다.
- Ажлын байрны орчин тойронд буй материал болон эд ангиудыг аюулгүй хурааж тавьсан эсэхийг шалгана. Ажлын дараа бүгдийг цэгцэлж, цэвэрлэнэ.
  작업장 주변의 재료, 부품 등이 안전한 상태로 있는지 점검하여 작업 후 정리 정돈 및 청소를 깨끗이 한다.
- Ажлын өмнө сул ажиллуулж, машины аль нэг хэсэг хэт их халж байгаа эсэх, хэт их дуу чимээ гаргаж байгаа эсэхийг шалгана.(Өвлийн улиралд 10 минут, зун 5 минут орчим)
  작업 전에 공회전을 시키면서 각부의 이상발열·소음 등 이상 유무를 파악한다. (동절기 : 약 10분, 하절기 : 약 5분 정도)
- Гулсагч хэсгийг тослох хэрэгтэй. (Өдөрт нэг 10 – 15 удаа тослоно.)
  슬라이드 부분의 급유는 적당히 공급해야 한다. (1일 1회에 10~15번 정도 기어오일 작동)
- Хариуцсан ажилтнаас өөр хүн машиныг ажиллуулж болохгүй.
  담당자외에는 설비를 가동하거나 조작하지 않는다.



Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах
작업 전 안전점검

# Сэрээч ачигч
지게차

Тоног төхөөрөмж 설비별

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다

2016 - 교육미디어 - 851

Mongolia

Сэрээт ачигч нь мотороор ажилладаг, хүнд жинтэй ачааг ачиж буулгах, зөөх зориулалтын машин юм. Ихэнх үйлдвэрлэлийн талбарт ачаа зөөх, буулгах зориулалтаар ашигладаг бөгөөд сэрээт ачигчинд мөргүүлэх, даруулах зэрэг осол их гардаг.
지게차는 내연기관을 동력으로 하는 기계로써, 중량물을 싣거나 내리는 하역 전용의 특수 자동차이다.
대부분의 산업 현장에서 운반 및 하역 기계로 사용되고, 부딪힘, 깔림 등에 의한 사망사고가 많이 발생하는 기계이다.

## » Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд 주요 유해·위험 요인

- Суудлын бүс зүүгээгүйгээс болж осолдох
  안전벨트 미착용으로 인한 재해
- Жолоочийн үзэгдэх орчин хязгаарлагдсанаас, жолоодох чадвар дутмагаас, хурд хэтрүүлсэн зэргээс болж хүн мөргөх
  운전자 시야불량, 운전미숙, 과속으로 작업자와 부딪힘 재해
- Хэт налуу газраар явах буюу хүндийн төв нэмэгдсэн үед гэнэт эргэснээс болж онхолдох
  경사면 또는 무게중심 상승상태에서 급선회로 넘어짐 재해
- Сэрээт ачигч ажиллаж байгаа бүсэд хүн орохыг хориглоогүйгээс хүн мөргөх
  지게차 작업위험 구역에 근로자 출입으로 부딪힘



## Ажил эхлэхийн өмнө шалгах зүйл 작업을 시작할 때의 점검항목



Safety Point

Mongolia

# Сэрээт ачигч ашиглах үеийн аюулгүй ажиллагаа

지게차 안전작업 방법

## Ажил эхлэхийн өмнө сэрээт ачигчийн аюулгүй байдлыг хангах 작업전 지게차 안전작업




- Сэрээт ачигчаар ажиллах ажлын төлөвлөгөө боловсруулан гаргаж, ажлыг удирдан явуулах хүн томилно
  지게차 작업계획서 작성 및 작업지휘자 지정·배치
  - Ажлын байрны талбай, газрын хэлбэр
    당해 작업장소의 넓이 및 지형
  - Сэрээт ачигчийн төрөл ба чадамж
    지게차의 종류 및 능력
  - Ачааны төрөл ба хэлбэр
    화물의 종류 및 형상
  - Сэрээт ачигчийн ажиллах зам болон ажиллах арга
    지게차의 운행 경로 및 작업방법 등
- Сэрээт ачигчаар ажиллахын өмнө шалгаж, зохих арга хэмжээг авах
  지게차의 작업 시작 전 점검 및 조치 실시
  - Тоормос болон жолоодлогын төхөөрөмж
    제동장치 및 조종장치 기능
  - Ачиж буулгах төхөөрөмж болон гидравлик төхөөрөмж
    하역장치 및 유압장치 기능
  - Урд болон арын гэрэл, дохионы гэрэл, ухрах дуут дохио хэвийн ажиллаж байгаа эсэх
    전조등 후 미등 방향 지시기 및 경보장치 등의 이상유무
- Сэрээт ачигчийг зөвхөн мэргэжлийн оператор жолоодно.
  유자격자에 의한 지게차 운전
- Сэрээт ачигч явах зам болон явган хүний замыг ялгах тэмдэг.
  지게차 운행 통로 및 근로자 안전통로 구분 표시
- Хүн ачааны даацын хязгаарлалтыг мөрдөнө. Гэнэт эргэхийг хориглоно.
  중량물 적재 하중 준수 및 급선회 운행 금지
- Хамгаалалтын дуулга зэрэг хамгаалалтын хэрэгсэл өмсөнө.
  안전모 등의 보호구 착용 철저
- Сэрээт ачигчийг зориулалтаас гадуур хэрэглэхийг хориглоно. Хажуудаа хүн суулгахыг хориглоно.
  지게차 목적 외 사용 및 승차석 외 탑승금지
- Сэрээт ачигчийг аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох, шалгах: Кабины дээд хамгаалалт, сэрээний арын хашлага, урд болон арын гэрэл, суудлын бүс.
  지게차 안전장치 설치 및 점검 : 헤드가드, 백레스트, 전조등, 후미등, 안전벨트
- Хурд хэтрүүлэхийг хориглоно: 10 км цаг гэх мэтээр тухайн ажлын байранд тохируулан хязгаар тогтоож журмыг мөрдөнө.
  지게차 과속 주행금지 : 제한속도 10㎞/h 등 사업장에 맞는 규정을 제정하여 준수하여 운행할 수 있도록 조치
- Кабины дээд хамгаалалт: Сэрээт ачигчийн даацын дээд хязгаараас 2 дахин их хүчийг тэсвэрлэх, нээлхий хэсгүүд нь хоорондоо 16 см-ээс доош зайтай байх хамгаалалтыг суурилуулна.
  지게차 헤드가드 설치 : 지게차의 최대하중의 2배 이상의 강도에 견디며 개구부의 간격이 16㎝ 미만의 헤드가드를 설치

OPEN 공공누리

Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах

작업 전 안전점검

# Зөөврийн шат

이동식 사다리

Тоног төхөөрөмж 설비별

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 852

Mongolia

Дээвэр болон хана зэрэгт түшүүлэн тавьж хэрэглэдэг шатыг зөөврийн түшүүлдэг шат(шулуун шат) гэдэг. А хэлбэртэй, нугасаар холбогдсон баганы өнцгийг ижил зайд тохируулан тавьж хэрэглэдэг шатыг гишгүүртэй зөөврийн шат гэдэг.

기대는 사다리(일자형 사다리)는 형상이 일자 형태로 되어있고 지붕, 벽 등 구조물에 기대어 사용하는 사다리를 말한다. 계단식 사다리는 형상이 A자 형태로 되어있고 힌지(Hinge)에 의하여 사다리 기둥의 각도를 일정한 범위에서 조절하면서 사용하는 사다리를 말한다.

## » Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд

주요 유해·위험 요인

- Эд юм барьж шатаар өгсөх юм уу доош дээш явах үедээ 3 цэгт хүрэлцээгүйгээс унах
  물건을 들고 사다리 상승 이동 등 3점지지 미확보로 떨어짐
- Эвдэрсэн, элэгдэж муудсан шат хэрэглэж байгаад унах юм уу онхолдох
  손상, 마모된 사다리 사용 중 떨어지거나 넘어짐
- Шатны хөлөнд хийсэн хальтрахаас хамгаалсан углуурга гэмтсэнээс шат онхолдох
  사다리 하부 미끄럼방지장치 손상으로 사다리 넘어짐




Шулуун шат
일자형사다리



Гишгүүртэй шат
계단식사다리

## Аюулгүй байдлын нийтлэг арга хэмжээ 일반적 안전조치

- Гишгүүр хоорондоо хөндлөнгөөрөө 25-35 см зайтай, 30 см-ээс дээш өргөнтэй шат хэрэглэнэ.
  이동식 사다리 발판의 수직간격은 25~35㎝ 사이, 폭은 30㎝ 이상으로 제작된 사다리를 사용한다.
- Шат далийх буюу онхолдсоноос болж ажилчин унаж осолддог. Үүнээс хамгаалахын тулд шатыг тэгш, хатуу гадаргуу дээр босгоно.
  이동식 사다리는 평탄하고 견고한 지반, 바닥에 설치하여 사다리의 기울어짐 또는 전도(넘어짐)에 의한 떨어짐 재해를 방지한다.
- Баганын доод хэсэгт үрэлтийн хүч сайтай материалаар хийсэн хальтрахаас хамгаалах хэрэгсэл хийсэн шат хэрэглэнэ.
  사다리 기둥 하부에 마찰력이 큰 재질의 미끄러짐 방지조치가 된 사다리를 사용한다.
- Ажлын байрны өндөрт тохирсон шат хэрэглэх бөгөөд илүү өндөр болгохын тулд тоосго болон хайрцаг ашиглахыг хориглоно.
  작업장소의 높이에 적정한 사다리를 사용하고, 추가적인 높이를 확보하기 위한 벽돌, 박스 등의 사용을 금지한다.
- Зөөврийн шатыг хөндлөн хэвтүүлж тавих буюу гишгүүртэй шатыг дэлгэн хэрэглэж болохгүй
  이동식 사다리를 수평으로 눕히거나 계단식 사다리를 펼쳐 사용하는 것을 제한한다.
- Зөөврийн шат онхолдож унах, хальтарч унах эрсдэлтэй үед туслах ажилчин шатнаас нь барьж өгнө.
  이동식 사다리의 넘어짐, 미끄러짐에 의한 근로자의 떨어짐 위험이 있을 때에는 보조자로 하여금 사다리를 잡게 해 균형을 유지한 상태에서 작업한다.



# Зөөврийн шатыг аюулгүй ашиглах

이동식 사다리 이용 작업안전

## Түшүүлдэг зөөврийн шат(Шулуун шат) 기대는 사다리(일자형 사다리)

- Түшүүлдэг шатыг гадаргуутай 75 градусаас доош өнцөг үүсгэж байхаар тавина. Шатны хөл, түшүүлсэн хананаас шатны уртын дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээний зайтай байна.
  기대는 사다리의 설치각도는 수평면에 대하여 75도 이하를 유지하고, 사다리 높이의 1/4 길이의 수평거리를 유지하도록 설치한다.
- Шатны доод хэсэгт суурилуулдаг хэвтээ тохируулагч хэрэгслийг ажлын үеэр шатны дээд хэсгийн ачааллыг хангалттай дааж байхаар төмөр болон модоор хийж, хөдөлгөөнгүй суурилуулсан байна.
  기대는 사다리 하부에 설치하는 수평조절장치는 작업 중 상부의 하중을 충분히 지지할 수 있도록 철재, 목재 등으로 견고하게 설치한다.
- Ажлын байрны дээд болон доод хэсгийн хооронд явахын тулд түшүүлдэг шат хэрэглэж байгаа тохиолдолд шатны дээд тал, шатны түшүүлсэн цэгээс хамгийн багадаа 60 см илүү гарсан байх, мөн 3 гишгүүр илүү гарсан байхаар тавина.
  작업장소의 상하부 간 이동을 위하여 기대는 사다리를 사용할 경우 사다리의 상단은 걸쳐놓은 지점으로부터 60㎝ 이상 또는 사다리 발판 3개 이상을 연장하여 설치한다.
- Түшүүлдэг шат хальтрах, онхолдож унах эрсдэлтэй үед шатны дээд болон доод хэсгийг бэхэлнэ.
  기대는 사다리의 미끄러짐, 전도 등으로 떨어짐 위험이 있는 경우에는 사다리의 상부 또는 하부를 고정한다.

## Гишгүүртэй зөөврийн шат 계단식(A형) 사다리

- Гишгүүртэй шатаар явах, мөн шатан дээр ажиллах үедээ гар, хөл, өвдөг зэргийн тусламжтайгаар 3 цэгт хүрэлцэн тулна.
  계단식 사다리에서 이동하거나 작업할 경우에는 손, 발, 무릎 등 신체의 일부를 사용하여 3점 접촉 상태를 유지한다.
- Гишгүүртэй шатны дээд талын 3 шат болон хамгийн дээд талын тавцан дээр зогсож ажиллахыг хориглоно.
  계단식 사다리는 상부 3개 발판으로부터 최상부 발판에서는 작업을 금지한다.
- Гишгүүртэй шатан дээр ажиллахдаа шатны баганыг ангайхаас хамгаалсан түгжих төхөөрөмж хэрэглэнэ.
  계단식 사다리를 사용할 경우 사다리 기둥의 벌어짐에 의한 추락재해를 예방하기 위하여 잠금장치를 설치한 상태에서 작업한다.
- Ажлын байрнаас дээвэр лүү гарах үед гишгүүртэй шат хэрэглэхийг хориглоно.
  작업장에서 지붕으로 이동할 경우 계단식 사다리는 사용을 금지한다.
- Гишгүүртэй шатан дээр ажиллахдаа гишгүүрийн гол дунд гишгэнэ. Гишгүүрийн захад гишгэвэл шат онхолдон унах аюултай.
  계단식 사다리 측면에서의 작업은 사다리 전도에 의한 떨어짐 위험이 있으므로 사다리 정면에서 작업한다.

OPEN 공공누리

Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах
작업 전 안전점검

# Туузан дамжуурга
컨베이어

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 892

Mongolia

Материал болон бараа бүтээгдэхүүнийг тодорхой зайд, автоматаар, тасралтгүй зөөх механик төхөөрөмжийг туузан дамжуурга гэдэг. Туузан дамжуургын туузыг резин, даавуу, төмөр тор, ган хавтангаар хийдэг бөгөөд эргэлдэж буй туузан дээр эд зүйлсийг тавьж зөөвөрлөдөг. Резинэн туузыг өргөнөөр хэрэглэдэг.
일정거리 사이를 자동·연속적으로 재료나 물건을 운반하는 기계장치로, 컨베이어 상부는 고무, 직물, 철망, 강판 등으로 만들어진 벨트를 순환시켜서 그 위에 물건을 올려놓고 연속으로 운반하는 장치이다. 컨베이어 벨트로 고무 벨트가 가장 많이 사용된다.

## Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд
주요 유해·위험 요인

- Ажиллаж буй дамжуургын доод хэсэгт орсон гадны биетийг цэвэрлэж буюу шалгаж байгаад хавчуулагдах
  가동 중인 컨베이어 하부 퇴적물 청소, 점검 작업 중 끼임
- Ажиллаж буй туузан дамжуургыг шалгаж, засаж, цэвэрлэж байгаад хавчуулагдах
  가동 중인 컨베이어 점검, 수리, 청소 작업 중 끼임
- Хамгаалах таглаа, хаалт суурилуулаагүй эргэлдэх хэсэг, хөдөлгөөн дамжуулах хэсэгт хавчуулагдах
  회전부, 동력전달부 등 방호울, 방호덮개 미설치된 장소에서 끼임



## Аюулгүй байдлыг шалгах хуудас 안전점검 체크리스트

| Шалгах зүйл 점검항목 | Шалгалтын үр дүн 점검결과 | Авсан арга хэмжээ 조치사항 |
|---|---|---|
| Туузан дамжуургын шугаманд ослын зогсолтын товчлуур хийсэн байна уу? Товчлуур хэвийн ажиллаж байна уу?<br>컨베이어 라인에 비상정지장치가 설치되고 정상적으로 작동하고 있는가? | | |
| Туузан дамжуурга дээгүүр гарах гүүр, шалгалт хийх замын эргэн тойронд хамгаалалтын хашлага хийсэн байна уу?<br>컨베이어 건널다리나 점검통로 주변에 안전난간이 설치되어 있는가? | | |
| Туузан дамжуургын хөдөлгөөн дамжуулах хэсэгт таглаа, хаалт хийсэн байна уу?<br>컨베이어의 동력전달 부분에 덮개 또는 울이 설치되어 있는가? | | |
| Туузан дамжуургын эргэн тойрны зам гарц эмх цэгцтэй байна уу?<br>컨베이어 주변 통로는 정리정돈 되어 있는가? | | |
| Туузан дамжуурга дээр бараа бүтээгдэхүүнийг тавихдаа хэт нэг талд нь ачаалал өгөхгүйгээр тавьж байна уу?<br>컨베이어에 물건 적재 시 편하중이 발생하지 않도록 적재하는가? | | |
| Засвар үйлчилгээ хийх үед тэжээлээс салгаж, “Ажиллаж байна” гэсэн тэмдэг хадсан уу? 보수·정비 작업시 전원을 차단하고, “작업중” 표지판을 부착하는가? | | |
| Туузан дамжуургын роликт хавчуулагдсан гадны биетийг авахын өмнө төхөөрөмжийг унтрааж байна уу?<br>컨베이어 롤러 퇴적물 제거 작업 시 설비 가동 중지 후 청소 작업을 하고 있는가? | | |
| Ажилчины биеийн аль нэг хэсэг орооцолдон татагдах магадлал бүхий туузан дамжуургын ремен, дамар, ролик, гинж, одон араа, шураг бүхий аюултай хэсэгт таглаа болон хаалт хийсэн байна уу?<br>컨베이어 벨트, 풀리, 롤러, 체인, 체인스프로킷, 스크루 등에 근로자 신체의 일부가 말려드는 등 위험발생부분에 덮개 또는 울이 설치되어 있는가? | | |
| Туузан дамжуургын мотор зэрэг цахилгаан эд ангийг газардуулах зэргээр тогонд цохиулахаас сэргийлэх арга хэмжээ авсан байна уу?<br>컨베이어 구동모터 등 전기기계에 대한 접지 등 감전보호조치가 되어 있는가? | | |

산업재해예방 안전보건공단

# Туузан дамжуургын аюулгүй ажиллагааны журам

벨트 컨베이어 작업 안전 수칙

## Аюулгүй байдлын нийтлэг арга хэмжээ 일반적 안전조치







- Туузан дамжуурга ажиллаж байх үед засвар үйлчилгээ хийх, шалгах, цэвэрлэхийг хориглоно.
  벨트 컨베이어 가동 중 정비, 보수, 점검, 청소 등의 작업을 금지한다.
- Цэвэрлэгээ хийх болон ролик солих үед 2 хүн хамт ажиллана. Осол гарсан үед холбоо барих боломжтой нөхцөлд ажлыг гүйцэтгэнэ.
  청소 및 롤러 교체 등 작업 시에는 2인 1조로 하고, 비상시 연락조치가 가능한 상태에서 작업을 한다.
- Ажил гүйцэтгэх үеэр туузан дамжуурга гэнэт ажиллахаас хамгаалахын тулд төв хяналтын бүхээгтэй байнга холбоотой байж, ажлын байран дахь дамжуургын унтраалгыг ажилчин өөрөө хариуцна.
  작업 중 벨트 컨베이어의 불시 가동을 막기 위하여 중앙운전실과 연락체계를 유지하고 현장 스위치를 작업자가 관리한다.
- Засвар үйлчилгээ хийх, шалгах, цэвэрлэхдээ тохирох гэрэлтүүлгийг хийсний дараа заасан багаж хэрэгслийг ашиглан ажлыг гүйцэтгэнэ.
  정비, 보수, 점검, 청소작업 시는 적정조도를 확보한 후 지정된 공구 및 도구 등을 사용한다.
- Туузан дамжуурга дээгүүр гарахдаа зориулалтын гүүр болон аюулгүй замаар явна.
  벨트 컨베이어를 횡단 할 경우 건널다리 등 안전한 통로를 이용한다.
- Ажиллахдаа хамгаалалтын гутал, хамгаалах дуулга, тоосноос хамгаалах маск зэрэг хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ. Өндөрт ажиллах үед хамгаалах бүс зүүнэ.
  작업 시는 안전화, 안전모, 방진마스크 등의 개인보호구를 철저히 착용하고 높은 장소에서의 작업 시 안전대(벨트)를 착용한다.
- Туузан дамжуурганы даацыг хэтрүүлэн ачиж болохгүй. Дамжуурган дээр гарч зогсох юм уу аюултай үйлдэл хийж болохгүй. 벨트 컨베이어의 적재물은 적정하게 적재하며, 벨트 컨베이어 위에 올라서거나 불안전 행동을 해서는 안 된다.
- Ажиллаж буй туузан дамжуургын орчин тойронг шалгахдаа биеийн аль нэг хэсгээр ороогдон татагдахаас сэргийлж хувцасаа цэвэр, цэгцтэй өмсөнө.
  가동 중인 벨트 컨베이어 주위에는 점검할 때 신체 일부가 접촉되어 말리지 않도록 복장 등을 단정히 한다.
- Ажиллаж буй туузан дамжуургын хүрд, зөөгч, буцах роликт гар хүрч болохгүй.
  가동 중인 벨트 컨베이어 드럼이나 캐리어, 리턴롤러 등에 손을 대지 않는다.
- Туузан дамжуурганд ачаа хавчуулагдах юм уу асуудал гарсан бол төв хяналтын бүхээгийн машинчтай холбогдож туузыг зогсооно. 벨트 컨베이어에 운반물이 끼었거나 이상 발견 시 중앙운전실 운전원에 연락하고 벨트를 정지시킨다.
- Шалгалт хийх зам гарцыг цэгцтэй байлгаж, тээглэж унах, хавчуулагдаж болох аюулыг зайлуулна.
  점검 통로는 정리정돈을 유지하고 통행자가 통행 시 넘어짐, 끼임 및 돌출부 등에 의한 불안전 상태를 사전 제거해야 한다.

## Дамжуурганд засвар үйлчилгээ, цэвэрлэгээ хийх үеийн аюулгүй ажиллагаа 퇴적 및 침적물 청소작업 시 안전작업

- Засвар үйлчилгээ хийх, цэвэрлэхдээ туузан дамжуургыг зогсооно.
  퇴적 및 침적물 청소 시는 벨트 컨베이어를 정지
- Төв хяналтын бүхээгтэй холбогдож, ажлын байрны түлхүүрийг ажилчин өөрөө хариуцах бөгөөд “Засвар үйлчилгээ хийж байна”, “Цэвэрлэгээ хийж байна” гэсэн тэмдэг хадна. 중앙운전실과 연락하고, 현장 스위치 키는 작업자가 휴대하며‘작업 중’, ‘청소 중’의 꼬리표를 부착
- Гадны биет орохыг багасгахын тулд скреперыг шалгаж, хоорондох зайг нь тохируулна.
  퇴적 및 침적물이 최소화 되도록 스크레이퍼의 상태를 점검하고 간격 조정
- Цэвэрлэж дуусаад туузан дамжуургыг шалгаж, дохиог дуугаргасны дараа ажиллуулна.
  청소 완료 후 벨트 컨베이어 가동 시는 사전점검 및 경보 후 가동
- Туузан ремен гэмтсэн, элэгдсэн, ролик эвдэрсэн эсэхийг шалгана. Ачаа буулгах хэсгийн ажиллагаа, ослын зогсолтын товчлуурын ажиллагаа, ачааны даацын тохиргоог шалгаж хэвийн ажиллагааг хангана.
  벨트의 손상, 마모, 롤러의 파손, 테이크 업의 작동상태, 비상정지 장치 운반물의 적재 적정성 등을 점검하고 항상 정상상태로 유지 관리

OPEN 공공누리
산업재해예방 안전보건공단

Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах
작업 전 안전점검

# Сууръ машин
선반

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 891
Mongolia

Тэнхлэгт бэхэлсэн эргэлдэж буй бэлдэцийг зорох, тайрах, өрөмдөх, суваг татах, эрээс татах зэргээр боловсруулдаг машиныг сууръ машин гэдэг.
선반이란 공작물을 주축에 고정하여 회전하고 있는 동안, 바이트에 이송을 주어 외경, 절삭, 보링, 절단, 단면 절삭, 나사 절삭 등의 가공을 하는 공작기계이다.

## Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд
주요 유해·위험 요인

- Ажил гүйцэтгэж байх үед эргэлдэгч хэсэгт ажилчны биеийн аль нэг хэсэг, хувцас зэрэг ороолдон татагдах
  작업 중 회전부에 작업자 신체 및 옷자락 말림
- Боловсруулалтнаас үүссэн хэлтэрхий үсэрч ажилтныг цохих
  작업 중 발생하는 칩이 비산되어 작업자가 맞음
- Их биеийн цахилгаан тусгаарлагч эвдэрснээс цахилгаан алдагдаж, ажилчин тогонд цохиулах
  본체 절연파괴 등으로 누전발생시 작업자 신체 접촉으로 감전
- Зорох үед үүсдэг тосон мананцраас болж мэргэжлээс шалтгаалсан өвчинтэй болох
  절삭유 미스트에 의한 직업성 질환
- Байнга нэг хөдөлгөөнийг давтан хийх буюу удаан хугацаагаар зогсоо ажилласнаас болж булчингийн эмгэгтэй болох
  반복동작과 장시간 서서 작업함에 따른 근골격계질환 발생



## Сууръ машины аюулгүй ажиллагааны дүрэм 선반작업 안전수칙

- Хувцасны хормойг дотогш хийнэ. Ханцуйгаа татаж боохдоо уяа хэрэглэхгүй.
  상의의 옷자락은 안으로 넣는다. 소매 자락을 묶을 때는 끈을 사용하지 않는다.
- Үртсийг багсаар цэвэрлэнэ. Бээлийгүй эсвэл даавуун бээлийтэй гараар үртсийг цэвэрлэж болохгүй. Ялангуяа тэнхлэгийн дотор талыг цэвэрлэхдээ машиныг зогсоогоод багс болон даавуу ороосон саваа ашиглана.
  칩을 떨어낼 경우에는 브러시로 하며 맨손 또는 면장갑을 착용한 채로 털지 않는다. 특히 스핀들 내면 청소 시 기계를 세우고 브러시, 천을 씌운 막대를 사용한다.
- Үртэс үсрэх тохиолдолд хамгаалалтын шил зүүж, машинд хамгаалалтын бүрхүүл суурилуулна.
  칩 비산 시에는 보안경을 쓰고 방호판을 설치하여 사용한다.
- Бэлдэцийг эргэлдэж байхад нь гараа хүргэж болохгүй.
  회전 중에 가공품을 직접 만지지 않는다.
- Машиныг унтраан бүрэн зогсоож хавчаарыг нэг мөсөн салгасны дараа бэлдцийг тэнхлэгт бэхлэнэ.
  가공물의 설치는 반드시 스위치를 차단하여 운전정지 후 바이트를 충분히 뗀 다음에 한다.
- Ажилд тохирсон хэмжээтэй голыг сонгох бөгөөд хойд тулгуурын тэнхлэгийг хэт их гаргахгүй.
  선반 돌리개는 적당한 크기를 선택하고 심압대 스핀들이 지나치게 나오지 않도록 한다.
- Бэлдэцийг бэхэлсний дараа тэр дарүй хавчаар, чангалагч зэргийг салгаж авна.
  공작물의 설치가 끝나면 척, 렌치류는 곧 떼어 놓는다.
- Далий бэлдэц бэхлэх үед тэнцвэржүүлэгч тоноглоно.
  편심된 가공물의 설치 시에는 균형추를 부착시킨다.

산업재해예방 안전보건공단

# Суурь машины аюулгүй ажиллагаа

선반 작업 시 안전조치

## Гол аюултай хүчин зүйл 핵심 위험요인

- Бэлдэцийг эргэлдэж байхад үртсийг нь цэвэрлэх
  가공물이 회전하는 상태에서 칩 제거
- Эргэлдэж байсан бэлдэц мултарч үсрээд ажилчныг цохих
  회전하던 가공물이 튕겨 나가 작업자가 맞음
- Хурдны хайрцган дээр тавьсан багаж доргилтноос болж эргэлдэх тэнхлэг рүү унан, ажилчныг цохих
  기어 박스 위에 올려놓은 작업공구가 진동 등에 의해 회전축(척)에 떨어져 작업자 맞음
- Боловсруулах ажлын үеэр үртэс үсэрч нүд гэмтээх
  가공작업 중 칩 날림에 의한 눈 등의 부상
- Бээлий эргэлдэгч тэнхлэгт ороогдон татагдах
  선반 작업 시 장갑 착용에 의한 회전부 말림



## Аюулгүй ажиллагааг хангах гол арга хэмжээ 핵심 안전조치 사항

- Бэлдэц эргэлдэхээ больж бүрэн зогссоны дараа бэлдэцийн үртсийг цэвэрлэнэ.
  가공물의 칩은 가공물의 회전이 완전히 멈춘 후에 제거
  - Үртсийг цэвэрлэхдээ үртэс бутлагч суурилуулж, суурь машиныг унтраасны дараа багс зэрэг багаж хэрэглэнэ.
    칩 제거 시 칩 브레이커를 설치, 선반을 정지시킨 후 브러시 등 수공구 사용
- Бэлдэцийг бэхлэхдээ машины тэнхлэгийн патроныг хөдөлгөөнгүй болтол нь чангална.
  가공물의 고정 작업 시 선반 척의 조(JAW)를 완전히 고정
- Машины хурдны хайрцаг дээрх багажийг хурааж цэгцэлсний дараа ажлаа эхлэнэ.
  선반의 기어박스 위에 작업공구 등이 없도록 정리정돈 후에 선반 작업 실시
- Үртэс үсрэхээс сэргийлэх төхөөрөмж суурилуулж, ажиллах үедээ хамгаалалтын шил зүүнэ.
  칩 비산방지장치 설치, 가공 작업 시 보안경 착용
- Аль болох даавуун бээлий өмсөхгүй байх, хувцасны ханцуйг татаж чангалан өмсөж байх.
  면장갑 착용 제한, 옷소매를 단정히 하는 등 적절한 작업복 착용





# Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах
작업 전 안전점검

# Тээрэм
분쇄기

조심조심 코리아
작업전 안전점검 당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 890
Mongolia

Таслагч багаж бүхий нэгээс дээш эргэлдэгч тэнхлэг болон бүлүүрийн нааш цааш хөдлөх хөдөлгөөний тусламжтайгаар чулуу, төмөр, хуванцар зэргийг шаардлагатай хэмжээтэй болтол буталдаг машиныг тээрэм гэдэг.
분쇄기란 절단 도구가 달린 한 개 이상의 회전축 또는 플런저의 왕복운동에 의한 충격력을 이용하여 암석이나 금속 또는 플라스틱 등의 물질을 필요한 크기의 작은 덩어리 또는 분체로 부수는 기계를 말한다.

## Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд 주요 유해·위험 요인

- Боловсруулах түүхий эд машин руу хийж байхдаа эргэлдэгч ирэнд хавчуулагдах
  투입부에 원료 투입 중 회전날에 끼임
- Тээрмийн дотор талыг засах, шалгах, гадны биетийг авах гэж байгаад эргэлдэгч ирэнд хавчуулагдах
  분쇄기 내부 보수·점검·이물질 제거작업 중 회전날에 끼임

  ※ Ялангуяа цахилгаанаас салгаагүй үед машиныг засах, мөн цахилгаанаас салгасаны дараа засвар үйлчилгээ хийж байхад өөр ажилчин ирж машиныг асааснаас болж ихэнх осол гардаг.
  특히, 전원 미차단 또는 전원 차단 후 작업시 다른 근로자의 전원투입으로 빈번하게 사고 발생
- Боловсруулах түүхий эдийг машин руу хийх, шалгах үед амсар болон шалгах тавцнаас унах
  원료 투입, 점검작업 시 투입부 및 점검구 발판에서 떨어짐
- Мотор болон хяналтын самбар зэрэг цахилгаан төхөөрөмжийн цэнэгтэй хэсэгт хүрэх, цахилгаан алдагдсанаас тогонд цохиулах
  모터, 제어반 등 전기기계기구의 충전부 접촉 또는 누전에 의한 감전





## Аюулгүй байдлыг шалгах хуудас 안전점검 체크리스트

| Шалгах зүйл 점검항목 | Шалгалтын үр дүн 점검결과 | Авсан арга хэмжээ 조치사항 |
|---|---|---|
| Түүхий эд хийх амсарт таглаа байна уу? Холбоос түгжээ хэвийн ажиллаж байна уу? 원료 투입구에 덮개가 설치되어 있고, 연동장치가 정상적으로 작동하는가? | | |
| Тээрмийн өндөр хэсэгт тохиромжтой ажлын тавцан болон хамгаалалтын тавцан суурилуулсан байна уу? 분쇄기의 고소부위에 적절한 작업발판과 안전난간이 설치되어 있는가? | | |
| Машиныг бүрэн унтраасны дараа гадны биетийг зайлуулах болон цэвэрлэх ажлыг хийлгэж байна уу? Аюулгүй ажиллагааны арга хэмжээг бүрэн авч байна уу?(цоожлох төхөөрөмж, тэмдэг гэх мэт) 이물질제거 또는 청소 시 전원차단 후 작업토록 하고 있는가?(잠금장치, 꼬리표 등) | | |
| Ослын зогсолтын товчлуур нь улаан өнгөтэй, товгор товчлуур байна уу? Тохиромжтой газар суурилуулж, хэвийн ажиллаж байна уу? 비상정지스위치는 돌출형(적색) 구조로 적합한 위치에 설치되고 정상기능을 유지하고 있는가? | | |
| Тээрмийн их биеийг газардуулсан уу? 분쇄기 외함은 접지되어 있는가? | | |
| Ажилчин ажлын онцлогт тохирсон хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэж байна уу? 작업근로자가 작업특성에 적합한 개인보호구를 착용하고 있는가? | | |

# Тээрмийн аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээ

분쇄기 사용작업 시 안전대책

## Төрөл тус бүрээр авах арга хэмжээ 항목별 세부조치내역

### Тээрмийн аюулгүй ажиллагаар хангах
분쇄기 안전조치

1. Тээрмийн амсар хэсэгт таглаа хийнэ.
   분쇄기 투입부에 덮개 설치
2. Таглаа онгойх үед цахилгаан тасалдаг байхаар холбоос цоожтой байх.
   덮개는 개방 시 전원이 차단되도록 연동장치 구성
3. Тавцан өндөр газар байх тохиолдолд унахаас сэргийлсэн хамгаалалтын хашлага хийнэ 고소에 위치한 발판이 있을 경우 추락방지조치(안전난간 등) 설치
4. Цахилгаан тоног төхөөрөмжний их биеийг газардуулна. 전기기계기구 외함 접지 실시
5. Түүхий эдийг дамжуургаар оруулах гаргах үед моторын эргэн тойрныг хаалтаар хааж, ослын зогсолтын төхөөрөмж суурилуулах зэргээр хамгаалах арга хэмжээ авна.
   컨베이어로 자재 투입·배출 시 동력전달부 덮개, 비상정지장치 등 방호조치 실시

### Тээрмийг засах, шалгах үед аюулгүй ажиллагаар хангах
분쇄기 보수·점검 안전조치

1. Тээрмийн дотор талд засвар, шалгалт хийх үед цахилгааныг тасална.
   분쇄기 내부에서 보수·점검 등의 작업 시 전원 차단
   - Тээрмийн таглаар нээхэд цахилгаан тасалж байхаар холбоос цоожин төхөөрөмж суурилуулна.
     분쇄기 덮개를 열면 전원이 차단되도록 연동(Interlock)장치 설치
2. Ажиллуулах төхөөрөмжинд цоожлох төхөөрөмж суурилуулна. 기동장치에 잠금장치 설치
   - Өөр ажилчин машиныг ажиллуулахаас хамгаалж түлхүүрийг нь тусад нь хадгална.
     다른 사람이 운전하는 것을 방지하기 위해 열쇠를 별도 관리
3. Шалгах буюу засаж байх үед ажиллуулах төхөөрөмжин дээр “Шалгаж/засаж байна” гэсэн тэмдэг наана.
   기동장치에 “점검/수리 중” 표지판 부착
4. Аюулгүй байдлын байцаагчийн удирдлагын дор ажиллах бөгөөд хянагч ажилчин байршуулна. 관리감독자로 하여금 작업을 지휘토록 하고 감시인 배치
5. Засах буюу шалгах үеийн аюулгүй ажиллагааны дэс дарааг бичиж, аюулгүй ажиллагааны сургалт явуулна.
   보수·점검 시의 안전작업절차 작성 및 안전교육 실시

### Бусад аюулгүй ажиллагааны арга хэмжээ
기타 위험 방지 조치

1. Зөвхөн сайн дураар аюулгүй байдлыг баталгаажуулсан тэмдэг(KCs) бүхий бүтээгдэхүүн хэрэглэнэ.
- Этилийн исэл, ацетилальдегид, пропилен ислийг химийн төхөөрөмж, цистерн, цилиндр саванд хийх, хадгалах тохиолдолд 산화에틸렌, 아세트알데히드 또는 산화프로필렌을 화학설비, 탱크로리, 드럼 등에 주입 작업과 저장하는 경우
  - Үргэлж тухайн төхөөрөмж савны доторхыг идэвхгүй хийгээр солих зэрэг арга хэмжээ авч аюулгүй болсныг шалгасны дараа ажлыг гүйцэтгэх буюу хадгалах.
    미리(항상) 그 내부를 불활성가스로 바꾸는 등 안전한 상태로 되어 있는 지 확인 및 상태에서 해당 작업을 실시하거나 저장

### » Химийн шинж чанар 물성특징

- Этилийн исэл(тэсрэх хүрээ 3.0% - 100%), ацетилальдегид (молекул жин нь 44.05, хайлах цэг -121 ℃, тэсрэх хүрээ 4.0% - 60,0%), пропилен исэл (тэсрэх хүрээ 1.9% - 36,3%) бодисын тэсрэх хүрээ нь өргөн тул тэсрэх аюул илүү их.
  산화에틸렌(폭발범위 3.0~100%), 아세트알데히드(분자량 44.05, 녹는점 -121℃, 폭발범위 4.0~60.0%), 산화프로필렌(폭발범위 1.9~36.3%)은 폭발범위가 넓어 폭발위험성이 높다.
- АНУ-ын Галаас хамгаалах үндэсний нийгэмлэгийн ангилалаар 4-р шаталтын зэрэгт хамаардаг, тэсрэх хүрээ нь өргөн, дөл авалцах хэм нь нам, онцгой хортой, хорт хавдар үүсгэх бодис юм. Молекулынхаа бүтцэд хүчилтөрөгчийг агуулдаг тул 400℃ болон түүнээс дээш хэмд задрал явагдаж даралт хурдтай нэмэгдсэнээр тэсрэдэг.
  독성물질, 발암성 추정물질로 미국NFPA에서 화재등급이 4로 폭발범위가 넓고 인화점이 낮고 분자구조상 산소를 함유하고 있어 400℃ 이상 온도가 상승하면 분해반응이 일어나 급격한 압력상승으로 폭발위험이 매우 높다.

※ KOSHA GUIDE D-141-2014(Этилийн исэлтэй ажилладаг тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны техник удирдамж)-ыг үзнэ үү.
KOSHA GUIDE D-141-2014(산화에틸렌 취급설비의 안전에 관한 기술지침) 참조

## Тэсрэх аюултай газрыг тэмдэглэх, хяналт тавих
폭발위험이 있는 장소의 설정 및 관리

- Үйлдвэрлэлийн стандартчилалын тухай хуулийн дагуу шатамхай шингэн бодисын уур болон шатамхай хийг үйлдвэрлэдэг, ажилладаг, ашигладаг газар, шатамхай хатуу бодис үйлдвэрлэдэг, ашигладаг газрыг хий тэсрэх аюултай газар, тоос тэсрэх аюултай газар болохыг заан бүдүүвч зурагт тэмдэглэн, зохих аюулгүйн арга хэмжээг авна.
  인화성 액체의 증기나 인화성 가스 등을 제조·취급 또는 사용하는 장소, 인화성 고체를 제조·사용하는 장소에 폭발위험장소의 구분도(區分圖)를 작성하는 경우 「산업표준화법」에 따라 가스 폭발 위험장소 또는 분진 폭발 위험장소로 설정하여 관리

※ Тэсрэх аюултай газрыг заасан бүдүүвч зургийг гаргах, хадах арга арга хэмжээг авах
폭발위험장소의 구분도를 작성·관리하도록 조치



위험장소로 설정하여 관리

## Шатамхай шингэн бодис байнга хэрэглэдэг газар
인화성 액체 등을 수시로 취급하는 장소

- Шатамхай шингэн бодис болон шатамхай хий байнга хэрэглэдэг газар сайн агааржуулаагүй байхад цахилгаан техник, багаж хэрэгсэл ашиглахыг хориглоно.
  인화성 액체, 인화성 가스 등을 수시로 취급하는 장소에서 환기가 충분하지 않은 상태에서 전기기계·기구 작동 금지
- Битүү орчинд шатамхай шингэнээр шүршигч буу ашиглан угаах, будах зэрэг ажлыг байнга хийдэг бол дараах арга хэмжээг авсны дараа цахилгаан техник, багаж хэрэгслийг ашиглана.
  수시로 밀폐된 공간에서 스프레이 건을 사용하여 인화성 액체로 세척·도장 등의 작업을 하는 경우 다음 조치 후 전기기계·기구를 작동
  - Шатамхай шингэн болон хийн шингэнээс болж тэсрэх аюултай орчин бүрдэхээс хамгаалахын тулд тухайн бодисын агаар дахь нягтрал, шатах хязгаарын үзүүлэлтийн 25%-иас давахгүй байхаар хангалттай агааржуулна. 인화성 액체, 인화성 가스 등으로 폭발위험 분위기가 조성되지 않도록 해당 물질의 공기 중 농도가 인화하한계값의 25%를 넘지 않도록 충분한 환기를 유지
  - Гэрлийг резин болон селикон сав болон баглаа боолтоор ороож битүүлнэ.
    조명 등은 고무, 실리콘 등의 패킹이나 실링재료를 사용하여 완전히 밀봉

- Халдаг цахилгаан техник, тоног төхөөрөмж ашигладаг бол угаах болон будах шүршигч буу ажиллаж байх үед асахгүй байхаар холбоос цоожлох төхөөрөмжөөр тоноглоно.
  가열성 전기기계·기구를 사용하는 경우에는 세척 또는 도장용 스프레이 건과 동시에 작동되지 않도록 연동장치 등의 조치 실시
- Галд тэсвэртэй унтраалга болон залгуураас бусад цахилгаан хэрэгслийг битүүмжилсэн орчны гадна талд суурилуулна.
  방폭구조 외의 스위치와 콘센트 등의 전기기기는 밀폐 공간 외부에 설치

※ Хэрэв дээр дурдсан цахилгаан техник, тоног төхөөрөмж галд тэсвэртэй бол ажиллуулах боломжтой.
상기에도 불구하고 방폭성능을 갖는 전기기계·기구에 대해서는 작동가능




## Тэсрэлт болон гал түймрээс урьдчилан сэргийлэх 폭발 또는 화재 등의 예방

- Шатамхай бодисын уур, шатамхай хий, шатамхай хатуу биет байгаа, тэсрэх, гал гарах магадлалтай газар, тэсрэлт болон гал түймрээс урьдчилан сэргийлэхийн тулд салхи оруулж, агааржуулж, тоосыг нь арчиж цэвэрлэнэ.
  인화성 액체의 증기, 인화성 가스, 인화성 고체가 존재하여 폭발, 화재가 발생할 우려가 있는 장소에서 폭발, 화재를 예방하기 위하여 통풍·환기 및 분진 제거 등의 조치 실시
- Уур, хийнээс үүдэлтэй, тэсрэлт, гал түймрийг эрт илрүүлэхийн тулд хий мэдрэгч болон дохиоллын төхөөрөмжөөр тоноглоно. Харин Үйлдвэрлэлийн стандартчилалын тухай хуулийн дагуу 0 болон 1 төрлийн тэсрэх аюултай бүсэд галд тэсвэртэй цахилгаан техник, тоног төхөөрөмж суурилуулсан бол хамаарахгүй.
  증기나 가스에 의한 폭발, 화재를 미리 감지하기 위하여 가스 검지 및 경보 장치를 설치.
  단, 「산업표준화법」에 따른 0종 또는 1종 폭발위험장소에 해당하는 경우 방폭구조 전기기계·기구를 설치한 경우에는 예외

## Хийн гагнуур 가스용접 등의 작업

- Шатамхай хий, идэвхгүй хий, хүчилтөрөгч(цаашид “хий” гэх) ашиглан металыг гагнах, тайрах, халаах тохиолдолд хий алдагдсанаас болж тэсрэлт, гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах зааврыг мөрдөнө.
  인화성 가스, 불활성 가스 및 산소(이하 “가스 등”)를 사용하여 금속의 용접·용단, 가열작업을 하는 경우, 가스등의 누출, 방출로 인한 폭발·화재, 화상을 예방하기 위하여 다음 사항을 준수
  - Хий алдагдах магадлалтай, гэмтэх буюу элэгдсэн хоолой болон гагнуурын алх бүү хэрэглэ.
    호스와 취관(吹管)은 손상·마모 등에 의하여 가스등의 누출 우려가 없는 것을 사용
  - Гагнуурын алх болон хоолойн залгаас хэсгийг хоолойн боолт, хавчаар зэрэг чангалагч хэрэгслээр чангалан боож хий алдагдахаас сэргийлнэ. 취관 및 호스의 상호 접촉부분은 호스밴드, 호스클립 등 조임기구를 사용하여 가스등이 누출되지 않도록 조치
  - Ашиглаж буй хий шахагч төхөөрөмжийг буруу ажиллуулахаас хамгаалах зорилгоор хавхлага болон гохон дээр нь тухайн төхөөрөмжийг ажиллуулж байгаа хүний нэрийг бичсэн зүүлт хадна.
    사용 중인 가스등을 공급하는 공급구의 밸브나 콕에는 사용하는 사람의 명찰을 붙이는 등 공급에 대한 오조작을 방지하기 위한 표시 실시
  - Метал тайрах үед гагнуурын алхнаас хэт их хэмжээний хүчилтөрөгч гарах тохиолдолд ажилчин түлэгдэх магадлалтай. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд тохируулагч хавхлагыг удаан нээхийг ажилчинд зааварлана. 용단작업 시 취관으로부터 산소의 과잉방출로 인한 화상을 예방하기 위하여 근로자가 조절밸브를 서서히 조작하도록 주지
  - Ажлаа дуусган ажлын байрнаас явах үед хийн төхөөрөмжний хавхлага болон гохыг хаана.
    작업 중단, 종료 시 장소를 떠날 경우 가스등의 공급구의 밸브나 콕을 잠글 것
  - Хий хуваарилах хоолойг залгахдаа зориулалтын хэрэгсэл ашиглана. Тус тусдаа, өөр өөр өнгийн, ялгах тэмдэгтэй хоолойг ашигласнаар буруу холбох аюулаас сэргийлж чадна. 가스등의 분기관은 전용 접속기구를 사용하여 불량 체결을 방지하며, 서로 이어지지 않는 구조의 접속기구 사용, 서로 다른 색상의 배관·호스의 사용 및 꼬리표 부착 등을 통하여 서로 다른 가스배관과의 불량체결을 방지







## Хийн баллон 가스 등의 용기





- Метал гагнах, тайрах, халаахад хэрэглэдэг хийн баллонтой ажиллах үед дараах заавper мөрдөнө.
  금속 용접·용단, 가열에 사용되는 가스등의 용기를 취급하는 경우 다음 사항을 준수

  - Дор дурдсан газрын аль нэгэнд хийн баллон хэрэглэх, тавих, хадгалах, орхихыг хориглоно. 다음의 어느 하나에 해당하는 장소에서 사용, 설치·저장, 방치금지
    - Агааржуулалт хангалтгүй газар
      통풍이나 환기가 불충분한 장소
    - Ил гал хэрэглэдэг газар болон тухайн газрын орчин тойронд
      화기를 사용하는 장소 및 그 부근
    - Аюултай бодис, хуулийн 236-р зүйлд заасан шатамхай шингэн бодистой ажилладаг газар болон тухайн газрын орчин тойронд
      위험물 또는 제236조에 따른 인화성 액체를 취급하는 장소 및 그 부근
  - Хийн баллоныг 40℃-аас доош хэмд байлгах
    용기의 온도를 섭씨 40도 이하로 유지할 것
  - Хажуу тийш унагаж болохгүй. Өөр зүйлд цохигдохоос хамгаалж, тээвэрлэх үед зориулалтын таг хийнэ.
    전도의 위험이 없도록 하고, 충격을 가하지 않도록 하며, 운반 시 캡을 씌울 것
  - Хэрэглэхдээ хийн баллоны таганд наалдсан тос болон тоосыг арчиж цэвэрлэнэ.
    사용하는 경우에는 용기의 마개에 부착되어 있는 유류 및 먼지를 제거할 것
  - Хавхлагыг аажуухан онгойлгоно. 밸브의 개폐는 서서히 할 것
  - Хэрэглээгүй болон хэрэглэж байгаа баллоныг тодорхой ялган хадгална.
    사용 전 또는 사용 중인 용기와 그 밖의 용기를 명확히 구별하여 보관할 것
  - Уусcан ацетилины баллоныг босгож тавина. 용해아세틸렌의 용기는 세워 둘 것
  - Баллон зэвэрсэн, элэгдсэн, хэлбэр нь өөрчлөгдсөн эсэхийг шалгасны дараа хэрэглэнэ.
    용기의 부식·마모 또는 변형상태를 점검한 후 사용할 것

### Өндөр даралттай хийн баллонны гадна талыг өнгөөр будах, хийн нэрийг тэмдэглэх 고압가스 용기외면 도색 및 가스명칭 표시방법

| Хийн төрөл 가스 종류 | | Энгийн зориулалттай 일반용 | | Эмчилгээний зориулалттай 의료용 | |
|---|---|---|---|---|---|
| | | Өнгө 도색 | Үг 문자 | Өнгө 도색 | Үг 문자 |
| Шатамхай/ онцгой хортой хий 가연성·독성가스 | Шингэрүүлсэн нефтийн хий 액화석유가스 | Саарал 회색 | Улаан 적색 | - | - |
| | Ус төрөгч 수소 | Улбар шар 주황색 | Цагаан 백색 | - | - |
| | Ацетелин 아세틸렌 | Шар 황색 | Хар 흑색 | - | - |
| | Шингэрүүлсэн аммиак 액화암모니아 | Цагаан 백색 | Хар 흑색 | - | - |
| | Шингэрүүлсэн хлор 액화염소 | Бор 갈색 | Цагаан 백색 | - | - |
| | Бусад хий 그 밖의 가스 | Саарал 회색 | Цагаан 백색 | Саарал 회색 | - |
| Бусад хий 그 밖의 가스 | Хүчил төрөгч 산소 | Ногоон 녹색 | Цагаан 백색 | Цагаан 백색 | Ногоон 녹색 |
| | Шингэрүүлсэн нүүрс төрөгчийн давхар исэл 액화탄산가스 | Хөх 청색 | Цагаан 백색 | Саарал 회색 | Цагаан 백색 |
| | Азот 질소 | Саарал 회색 | Цагаан 백색 | Хар 흑색 | Цагаан 백색 |
| | Гал унтраагч баллон 소방용 용기 | Аюултай бодисын аюулгүй ажиллагааны хууль 위험물안전관리법 | Цагаан 백색 | - | - |
| | Азотын давхар исэл 이산화질소 | Саарал 회색 | Цагаан 백색 | Хөх 청색 | Цагаан 백색 |
| | Гели 헬륨 | Саарал 회색 | Цагаан 백색 | Бор 갈색 | Цагаан 백색 |
| | Этилин 에틸렌 | Саарал 회색 | Цагаан 백색 | Чернилэн ягаан 자색 | Цагаан 백색 |
| | Циклопропан 싸이크로프로판 | Саарал 회색 | Цагаан 백색 | Улбар шар 주황색 | Цагаан 백색 |
| | Бусад хий 그 밖의 가스 | Саарал 회색 | Цагаан 백색 | Саарал 회색 | Цагаан 백색 |

※ Баллон дээрх бичигийг GHS MSDS журмын дагуу дөрвөн өнцөгт ширфтээр бичих бөгөөд, зориулалтаар нь усан онгоц, автомашин гэж тэмдэглэнэ.
용기에 표시하는 그림문자는 GHS MSDS규정에 따라 마름모꼴에 표시하고, 용도에 따라 선박용, 자동차용 등을 표시한다.

## Хоёр өөр бодис нийлж гал гарахаас урьдчилан сэргийлэх
서로 다른 물질의 접촉에 의한 발화 등의 방지

- Хоёр өөр бодис нийлснээс гал гарах, тэсрэх аюултай тохиолдолд тухайн бодиснуудыг хол хадгалах ёстой бөгөөд нэг тээврийн хэрэгсэл дээр ачиж явж болохгүй. Харин, хоорондоо нийлэхээс хамгаалсан хамгаалах арга хэмжээ авсан тохиолдолд энэ журам хамаарахгүй.
  서로 다른 물질끼리 접촉함으로 인하여 해당 물질이 발화하거나 폭발할 위험이 있는 경우 해당 물질을 가까이 저장하거나 동일한 운반기에 적재해서는 아니 됨.
  단, 접촉방지를 위한 조치를 한 경우에는 예외 적용

## Гал түймэр гарах аюултай ажлын байр 화재 위험이 있는 작업의 장소 등

- Их хэмжээний нийлэг эдлэл, хөвөн, ноос, даавууны өөдөс, модны үртэс, сүрэл, цаас болон бусад шатамхай шингэнтэй ажилладаг ажлын байр, байгууламжид гал гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд тоног төхөөрөмж болон багаж хэрэгслийг зохих ёсоор зохион байгуулж, байршуулан суурилуулсан байх ёстой.
  합성섬유·면·양모·천조각·톱밥·짚·종이류 또는 그 밖에 인화성 액체를 다량으로 취급하는 작업을 하는 장소·설비 등은 화재예방을 위하여 적절한 구조로 배치
  - Зохих ёсоор байршуулах: Гал гарах магадлалтай бодисыг хангалттай хол зайтай байлгах, мөн гал гарах магадлалтай газрыг тусгаарлах арга.
    적절한 배치 : 방화상 필요한 거리 유지 방법과 이런 장소로부터 격리시키는 방법
  - Зохимжтой зохион байгуулалт: Гал гарахаас урьдчилан сэргийлэх, гал унтраахад хялбар байхаар зохион байгуулах арга. 적절한 구조 : 화재발생 방지와 소화에 편리하도록 하는 방법 등

## Бодис өөрөө шатахаас урьдчилан сэргийлэх 자연발화의 방지

- Пироксилин, алкил хөнгөн цагаан зэрэг өөрөө шатах аюултай бодисыг хурааж тавьсан бол шатах аюултай хэм хүртэл халахаас хамгаалах арга хэмжээ авна.
  질화면, 알킬알루미늄 등 자연발화의 위험이 있는 물질을 쌓아 두는 경우 위험한 온도로 상승하지 못하도록 화재예방을 위한 조치 실시

### » Химийн шинж чанар 물성특징

- Алкил хөнгөн цагаан, алкил хөнгөн цагаан лити зэрэг бодис ил байхдаа агаар дахь чийгтэй урвалд орж шатамхай хий үүсгэн дулааны үйлчлэлээр өөрөө шатдаг тул агааржуулалт, нарны гэрлээс хол газар битүүмжилсэн саванд хадгална.
  알킬알루미늄, 알킬리튬 등과 같은 물질은 누출하면 공기 중의 수분과 반응하여 인화성가스가 발생하고, 반응열에 의하여 자동으로 점화되므로, 통풍이 잘되고 직사광선을 피하여 밀봉상태로 저장한다.
- Аж үйлдвэрийн зориулалттай пироксилиныг дарь, будаг, тусгай бэх хийхэд ашигладаг. Азотын агуулагдах хэмжээнээс нь хамаарч үйлдвэрлэлийн болон дарины зориулалтынх гэж ангилдаг. Хадгалж буй сав нь задарснаас пироксилин хатаж хуурайшсан байхад нь цохих юм уу үрж, халаах юм бол асах магадлалтай. Тиймээс пироксилиныг байнга чийгтэй байлгах хэрэгтэй.
  산업용 질화면(나이트로셀룰로스, 면약, 면화약)은 화약, 도료, 특수 잉크 등에 사용하며, 질소의 함유량에 따라 공업용과 화약용으로 구분한다. 저장용기 파손 등으로 질화면이 건조한 상태에서 충격, 마찰, 열에 노출되면 점화될 수 있으므로 항상 습한 상태로 유지한다.

## Тос болон бусад зүйлсэд бохирдсон алчуур болон даавууг хаях
유류 등이 묻어 있는 걸레 등의 처리

- Тос болон хэвлэлийн бэх наалдсан даавууны өөдөс, цаасыг таглаатай, шатдаггүй саванд хийх зэргээр гал гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
  기름 또는 인쇄용 잉크류 등이 묻은 천조각이나 휴지 등은 뚜껑이 있는 불연성 용기에 담아 두는 등 화재예방을 위한 조치 실시

※ Тос болон бэхийг нэг газар удаан хугацаагаар хураавал агаарт байгаа хүчилтөрөгчтэй исэлдэж үүссэн дулаан улам хуримтлагдсаар өөрөө шатах аюултай. Тиймээс аль болох хурдан хэрэглэж дуусгах, эсвэл дулаан хуримтлагдахгүй байх арга хэмжээ авах хэрэгтэй.
한곳에 장시간 쌓아두면 기름이나 잉크류 등이 공기 중 산소와 산화반응을 발생된 열이 계속 축적될 경우 자연발화에 의한 화재위험이 있으므로 즉시 소각 등으로 가능한 빨리 처리하거나 열이 축적되지 않도록 한다.



# Тэсрэлт, гал түймэр, аюултай бодисонд өртөх зэрэг эрсдлээс урьдчилан сэргийлэх Галанд тавих хяналт

폭발·화재 및 위험물누출에 의한 위험방지 | 화기 등의 관리 |

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 879
Mongolia

## Аюултай бодис байгаа газар гал ашиглахыг хориглох
위험물 등이 있는 장소에서 화기 등의 사용금지

- Тэсрэх, гал гарах магадлалтай, аюултай бодис бүхий газар, оч болон нум үүсгэдэг, мөн өндөр температурт халах магадлалтай ил гал, машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглаж болохгүй.
  위험물이 있어 폭발, 화재가 발생할 우려가 있는 장소, 그 상부에서 불꽃이나 아크를 발생하거나 고온으로 될 우려가 있는 화기·기계 ·기구 및 공구 등을 사용해서는 안 됨




### Тэсрэлтийн хамгаалалттай цахилгаан машин механизм, тоног төхөөрөмж хэрэглэх жишээ
방폭형 전기기계기구 등 사용 예


Тэсрэлтийн хамгаалалттай чиглүүлэгч гэрэл
방폭형 유도등


Тэсрэлтийн хамгаалалттай гар багаж
방폭형 수공구


Тэсрэлтийн хамгаалалттай түр гэрэл
방폭형 임시 조명등


Тэсрэлтийн хамгаалалттай галын дохиолол
방폭형 화재발신기

## Тостой труба болон сав гагнах
유류 등이 있는 배관이나 용기의 용접 등

- Аюултай бодис, шатамхай тос, шатамхай хатуу биет агуулсан байх магадлалтай труба, цистерн, цилиндр зэрэг сав
  위험물, 위험물 외의 인화성 유류 또는 인화성 고체가 있을 우려가 있는 배관·탱크 또는 드럼 등의 용기에 대하여
  - Аюултай бодис, шатамхай тос, шатамхай хатуу биетийг цэвэрлэх зэргээр тэсрэх болон гал гарах аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй тохиолдолд гагнах, гагнуураар таслах зэрэг гал ашигладаг ажлыг гүйцэтгэж болохгүй.
    미리 위험물 외의 인화성 유류, 인화성 고체, 위험물을 제거하는 등 폭발이나 화재의 예방을 위한 조치를 한 후가 아니면 용접·용단 그 밖에 화기를 사용하는 작업이나 불꽃을 발생시킬 위험한 작업을 하면 안됨



## Агаарын солилцоо, агааржуулалт хангалтгүй газар гагнуур хийх 통풍 등이 충분하지 않는 장소에서의 용접 등

- Агаарын солилцоо, агааржуулалт хангалтгүй газар гагнах, таслах, метал халаах зэрэг гал ашигладаг ажил, билүүгээр өнгөлөх ажил зэрэг гал асах магадлалтай ажлыг гүйцэтгэх тохиолдолд
  – Агааржуулахын тулд хүчилтөрөгч ашиглаж болохгүй.
  통풍, 환기가 충분하지 않은 장소에서 용접·용단 및 금속의 가열 등 화기를 사용하는 작업, 연삭숫돌에 의한 건식 연마작업 등 그 밖에 불꽃이 될 우려가 있는 작업 등을 하는 경우
  – 통풍, 환기를 위하여 산소를 사용해서는 아니 됨
- Агаарын солилцоо, агааржуулалт хангалтгүй, асамхай бодис агуулсан байшин болон байгууламжин дотор гагнах, гагнуураар таслах зэрэг гал ашигладаг ажил гүйцэтгэх тохиолдолд гал гарахаас урьдчилан сэргийлж дараах журмыг мөрдөнө.
  통풍이나 환기가 충분하지 않고 가연물이 있는 건축물 내부, 설비 내부에서 용접·용단 등과 같은 화기 작업을 하는 경우 화재예방에 필요한 다음의 사항을 준수함

❶ Ажилд бэлтгэх болон ажлын дэс дараа тогтоосон төлөвлөгөө гаргана. 작업 준비 및 작업 절차 수립

❷ Ажлын байрны дотор аюултай бодисыг хэрхэн хэрэглэж, хадгалж байгааг олж мэднэ.
작업장 내 위험물의 사용·보관 현황 파악

❸ Шатамхай шингэн бодис байгаа газрын ойролцоо гал ашиглах гэж байгаа бол галын аюулаас сэргийлэх арга хэмжээ авч гал унтраагч байрлуулна. 화기작업에 따른 인근 인화성 액체에 대한 방호조치 및 소화기구 비치

❹ Гагнуурын оч үсрэхээс хамгаалах хаалт, халхавч зэрэг хамгаалах хэрэгслийг байрлуулна.
용접불티 비산방지덮개, 용접방화포 등 불꽃, 불티 등 비산방지조치

❺ Шатамхай шингэн бодисны уур үлдэхээс сэргийлж хангалттай агааржуулна.
인화성 액체의 증기가 남아 있지 않도록 환기 등의 조치

❻ Ажилчныг гал түймрээс урьдчилан сэргийлэх, галаас зугтах сургалтанд хамруулна.
작업근로자에 대한 화재예방 및 피난교육 등 비상조치



통풍, 환기용 산소를 사용하면 위험


Очны халхавч
비산방지용 불받이포



사용 전 절차 수립해야



위험물 사용현황 파악



비산 방지 조치



화재에 대비해서 소화기 항상 비치



화재나면 여기로 대피

## Гал унтраах хэрэгсэл 소화설비

- Барилга, мөн химийн тоног төхөөрөмж болон аюултай бодис хатаадаг төхөөрөмж бүхий газар, шатамхай тос болон тэсрэлт, гал түймрийн эх үүсвэр болох магадлалтай бодис ашигладаг газар(цаашид “барилга байгууламж” гэх ) гал унтраах хэрэгсэл байрлуулах
  건축물, 화학설비 또는 위험물 건조설비가 있는 장소, 그 밖에 위험물이 아닌 인화성 유류 등 폭발이나 화재의 원인이 될 우려가 있는 물질을 취급하는 장소(이하 ‘건축물 등’)에는 소화설비를 설치

### Галын төрөлд тохируулан гал унтраагчийг хэрэглэх
화재분류에 따른 적응 소화기

| | Төрөл 종류 | Өнгөний код 소화기표시 | Гал унтраах арга 소화방법 | Хэрэглэх гал унтраагч 적응 소화기 | Тайлбар 비고 |
|---|---|---|---|---|---|
| 보통화재용 A<br>Энгийн гал<br>일반 화재 | A ангилал<br>A급 | Цагаан<br>백색 | Хөргөх<br>냉각소화 | Хүчил, шүлт, хөөс, усан унтраагч<br>산·알카리, 포(泡), 물(주수) 소화기 | Мод, даавуу, цаасны гал<br>목재, 섬유, 종이류 화재 |
| 유류화재용 B<br>Тос болон хийн гал<br>유류 및 가스화재 | B ангилал<br>B급 | Шар<br>황색 | Хүчилтөрөгчөөс тусгаарлах<br>질식소화 | Нүүрстөрөгчийн давхар исэл, ууршигч шингэн бодис, нунтаг, хөөсөн унтраагч<br>$CO_2$, 증발성 액체, 분말, 포 소화기 | Шатамхай шингэн бодис, хийн гал<br>가연성 액체 및 가스 화재 |
| 전기화재용 C<br>Цахилгааны гал<br>전기 화재 | C ангилал<br>C급 | Цэнхэр<br>청색 | Хүчилтөрөгчөөс тусгаарлах<br>질식소화 | Нүүрстөрөгчийн давхар исэл, ууршигч шингэн<br>$CO_2$, 증발성 액체 | Цахилгаан тоног төхөөрөмжийн гал<br>전기 통전 전기기구 화재 |
| Металын гал<br>금속 화재 | D ангилал<br>D급 | - | Бүрхүүл тогтоож хүчилтөрөгчөөс тусгаарлах<br>피복에 의한 질식 | Хуурай элс, тэлдэг вермикулит<br>마른모래, 팽창질석 | Магни, натри, кали зэрэг шатамхай метал<br>가연성 금속(Mg, Na, K 등) |

※ Галын төрөлд тохирсон гал унтраагчийн ангилал
화재의 종류에 따른 소화기 적용성 분류




화재의 종류에 따라
적합한 소화기를 사용해야 한다.



## Гал хэрэглэхийг хориглох 화기 사용금지

- Гал түймэр гарах, тэсрэх аюултай газар гал хэрэглэхийг хориглоно.
  화재 또는 폭발의 위험이 있는 장소에 화기 사용 금지

  - Гал түймэр гарах, тэсрэх аюултай газар машин механизм тоноглох, ажиллуулахын тулд зайлшгүй гал ашиглах шаардлагатай бол асамхай, шатамхай бодисыг холдуулж, гал унтраагч байрлуулах зэрэг аюулгүйн арга хэмжээ авна. Гал ашиглан ажил гүйцэтгэхдээ боловсруулсан төлөвлөгөөний дагуу, зохих зөвшөөрлийг авч гүйцэтгэнэ.
  - 화재, 폭발위험 장소에서 부득이 하게 정비, 운전을 위하여 화기사용을 해야하는 경우 사전에 가연성이나 인화성물질을 제거하고, 소화기 비치 등 사전 안전조치를 철저히 한다. 화기작업 절차에 따라 화기작업 허가를 받아서 가능할 수 있다.






Аюултай бодис хадгалах байр
Гал гаргахыг хориглоно

## Галаас хамгаалах арга хэмжээ 방화조치

- Зуух, халаах зуух, халаах тоног төхөөрөмж, хог шатаах газар, метал яндан болон бусад галын аюултай тоног төхөөрөмж, барилга байгууламж, шатамхай шингэн бодисыг хоорондоо хангалттай хол байхаар зайд байрлуулах юм уу шатдаггүй материалаар хамгаалалт хийнэ.
  화로, 가열로, 가열장치, 소각로, 철제굴뚝, 그 밖에 화재를 일으킬 위험이 있는 설비 및 건축물과 그 밖에 인화성 액체와의 사이에는 방화에 필요한 안전거리를 유지하거나 불연성 물체를 차열(遮熱)재료로 하여 방호




## Гал хэрэглэдэг газар гал түймрээс урьдчилан сэргийлэх 화기사용 장소의 화재 방지

- Тамхи татдаг цэг, зуух зэрэг гал ашигладаг газар галаас урьдчилан сэргийлэх төхөөрөмж суурилуулна.
  흡연장소 및 난로 등 화기를 사용하는 장소에 화재예방에 필요한 설비 설치
- Гал ашигласан хүн, галын цог үлдээлгүй бүрэн унтраана.
  화기를 사용한 사람은 불티가 남지 않도록 뒤처리를 확실하게 처리

## Хог шатаах газар 소각장

- Хог шатаах газрыг гал тархах эрсдэлгүй байрлалд байгуулах бөгөөд шатдаггүй материалаар барина.
  소각장 설치 시 화재가 번질 위험이 없는 위치에 설치하거나 불연성 재료로 설치

Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгах
작업 전 안전점검

# Хүнд ачаатай харьцах ажил
중량물 취급 작업

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 878

Mongolia

Хүнд ачаатай харьцдаг болохоор кранаар ажиллах нь маш өндөр эрсдэлтэй байдаг. Тиймээс ажлын стандарт, төлөвлөгөөг боловсруулан гаргаж, ажлын орчинг аюулгүй байлгахад анхаарч, ачаа зүүх найдвартай арга болон багаж хэрэгслийг сонгож, тодорхой дохионы системийг хэрэглэснээр аюулгүй ажиллагаар хангаж чадна.
줄걸이 작업은 중량물을 취급하기 때문에 위험이 크므로 작업 기준이나 작업 계획을 정해서 작업 환경의 안전에 충분히 주의를 기울이고 정확한 줄걸이 방법, 줄걸이 용구의 선정, 명확한 신호 등을 통해 안전한 작업을 하는 것이 무엇보다 중요하다.

## » Гол хортой болон аюултай хүчин зүйлүүд 주요 유해·위험 요인

- Хүнд ачааг өргөх буюу буулгах үед гар хөлөө хавчуулах. Ачиж буулгах механизм болон байгууламжийн завсар хавчуулагдах. 무거운 화물을 들거나 내려놓을 때 손·발 끼임, 하역운반기계와 작업장 바닥 등 건축 구조물 사이 끼임
- Сэрээт ачигч, кран зэрэг зөөвөрлөгч механизм ажилчинг мөргөх. Ачааны тавцан, зөөвөрлөгч механизмын дээрээс ачаа ачиж буулгаж байгаад унах.
  지게차, 크레인 등의 운반기계와 작업자와의 부딪힘, 적재대/운반기계의 상부에서 화물을 싣고 내리던 중 떨어짐
- Чанаргүй ачаа оосорлогч ашиглах, гэмтэж элэгдсэн тороос хэрэглэснээс болж осолдох
  불량한 줄걸이 작업, 손상, 마모 된 로프 사용 등에 따른 재해 위험
- Ачааг зөөвөрлөхдөө хэт их хүч гаргаснаас нуруугаа гэмтээх. Халуун, хүйтэн, арзгар, хурц үзүүртэй ачаанаас болж гэмтэх, ачаанд бүдэрч унах.
  화물운반 중 무리한 동작으로 인한 요통, 화물 자체의 특성(뜨거움, 차가움, 거침, 날카로움)에 의한 노출, 화물에 걸려 넘어짐





## ☑ Аюулгүй байдлыг шалгах хуудас 안전점검 체크리스트

| Шалгах зүйл 점검항목 | Шалгалтын үр дүн 점검결과 | Авсан арга хэмжээ 조치사항 |
|---|---|---|
| Зөөвөрлөх машин механизмын даац хязгаарлах төхөөрөмж зэрэг хамгаалалтын төхөөрөмж хэвийн ажиллаж байна уу? 과부하방지장치 등 중량물 운반설비의 방호장치는 정상작동하고 있는가? | | |
| Тороос ямар нэгэн гэмтэлгүй, тасрах аюулгүй байна уу? Оосорлох арга тохиромжтой байна уу? 로프(섬유, 와이어 등)는 손상, 균열 등 끊어질 위험이 없으며 줄걸이 방법이 적정한가? | | |
| Хүнд ачаатай харьцаж байгаа газар өөр хүн байлгахгүй байх арга хэмжээ авсан уу? Ажлын талбарт өөр хүн ойртохоос сэргийлэх арга хэмжээ авсан уу? 중량물 취급 장소에 다른 근로자가 위치하지 않으며 접근통제 조치가 되고 있는가? | | |
| Харьцаж байгаа хүнд ачаа эрсдэлтэй(халуун, хүйтэн, арзгар, хурц үзүүртэй) ачаа байна уу? 중량물 자체 위험(뜨거움, 차가움, 거침, 날카로움 등)이 없는가? | | |
| Хүнд ачаа ажилчны үзэгдэх орчинг хязгаарлаж байна уу? 중량물이 작업자의 시야를 가리지 않는가? | | |
| Хүнд ачаа зөөх замд саад байна уу? 중량물 운반 이동 경로에 방해물(정리정돈)은 없는가? | | |
| Ажил эхлэхийн өмнө хүнд ачаа зөөхтэй холбоотой сургалтанд хамрагдсан уу? 작업 전 중량물 취급 운반 작업에 관한 교육을 이수 하였는가? | | |
| 100 кг-аас илүү жинтэй хүнд ачаатай харьцах үед тухайн ажлыг удирдах хүн томилдог уу? 무게가 100KG 이상인 중량물 취급 작업 시 작업지휘자가 배치되어 있는가? | | |
| Хүнд ачаа зөөх үедээ ачигч, тэргэнцэр зэрэг туслах төхөөрөмж, хэрэгсэл идэвхтэй хэрэглэж байна уу? 중량물 운반 시 이동대차 등 운반 보조기계 · 기구를 적극 사용하고 있는가? | | |
| Хүнд ачаа зөөх замыг хэмжээг аль болох багасгасан уу? 중량물 이동 시 운반거리를 최소화 하였는가? | | |

산업재해예방 안전보건공단

# Хүнд ачаатай харьцах үеийн аюулгүй ажиллагаа

중량물 취급 작업 안전

## Гол ослын шалтгаан 주요 재해발생 원인



- Ачааг буруу өргөх, хэт хүнд ачаа өргөх
  불안전한 작업 자세, 무리한 중량물 취급
- Зөөврийн буруу хэрэгсэл хэрэглэх
  잘못된 운반기구의 사용
- Үзэгдэх орчин хангалтгүй байхад хүнд ачаа өргөх, зөөх
  전방시야가 확보되지 않은 상태에서 중량물 취급
- Баглаа боодол муутай ачаа унах
  결속상태가 불량한 물건의 떨어짐
- Ажиллаж байгаа ачааныхаа хортой, аюултай шинж чанарын талаар мэдлэг дутмаг
  취급물의 유해·위험성에 대한 지식 부족
- Эмх цэгц муутай, давчуу зай багатай газар ачаа өргөх, зөөх
  정리정돈이 불량하고 좁은 장소에서의 중량물 취급
- Хүнд ачаа өргөх, зөөхтэй холбоотой сургалт хангалтгүй
  중량물 취급 운반 작업에 관한 교육 불충분 등

## Хүнд ачаатай харьцах үеийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ
중량물 취급 작업 재해예방 대책

| | |
|---|---|
| Унах<br>넘어짐 재해 예방 | ① Ачаа зөөх тогтсон аргыг мөрдөж ажиллах<br>지정된 화물 운반·취급방법 준수<br>② Ачааг гараар зөөх аргад суралцах<br>올바른 인력운반방법 숙지<br>③ Зорчих замыг цэвэрлэж цэгцлэх<br>통행로 정리정돈<br>④ Ачааны даац хэтрүүлэн ачихгүй байх, ачааг унахаас сэргийлж хооронд нь бэхлэх<br>이동대차 과적금지 및 화물이탈 방지를 위한 결속 |
| Ачаа унах<br>떨어짐 재해 예방 | ① Ачааг ачих, буулгах, хураах үед өргөх төхөөрөмж ашиглах<br>상·하차, 적재작업 시 승강설비 사용<br>② Ачааны төрлөөс хамаарч хураах аргыг тогтоох<br>적재물 종류별 적재방법 규정<br>③ Хамгаалах дуулга, хамгаалалтын гутал зэрэг хувийн хамгаалах хэрэгсэл олгох<br>안전모, 안전화 등 개인보호구 지급 |
| Хавчуулагдах<br>끼임 재해 예방 | ① Ачаа зөөх механизмын хамгаалах төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, хэрэглэх<br>화물운반기계 각종 방호장치 정상 기능 유지·사용<br>② Засвар үйлчилгээ, шалгалт хийх үед тэжээлээс салгаж, “Ажиллуулахыг хориглоно” тэмдэг хадах 수리·점검 중 전원 차단 및 “조작금지” 표지판 부착<br>③ Сэрээт ачигчийн суудлын бүсийг зүүх, мэргэжлийн бус хүн жолоодохыг хориглох<br>지게차 안전벨트 착용 및 무자격자 운전 금지 |
| Мөргөх<br>부딪힘 재해 예방 | ① Сэрээт ачигчийн хурдны хязгарлалтыг мөрдөх<br>지게차 제한 속도 준수<br>② Краны дохиоллын системийг мөрдөх<br>크레인 일정한 신호방법 준수<br>③ Краны ажлын бүсэд хүн орохыг хориглох, краныг гэнэт хөдөлгөхийг хориглох<br>크레인 작업반경내 출입금지 및 급격한 조작금지<br>④ Сэрээт ачигч болон явган хүн явах замыг тусгаарлаж тэмдэглэх<br>지게차와 보행자 운행통로 구획 관리 |

OPEN 공공누리

# Мод боловсруулагч ажилчны Хувийн хамгаалах хэрэгсэл

목제품 제조(목재가공) 관련 종사자를 위한 개인보호구

조심조심 코리아
작업전 안전점검 당신의 생명을 지킵니다

2016 - 교육미디어 - 877

Mongolia

## Хамгаалах арга 보호 방법

### Хамгаалах хувцас
보호복

- Биенд яг таг таарсан ажлын хувцас өмсөнө.
  몸에 밀착되는 작업복을 착용한다.
- Гоёл зүүлт , бөгж зэргийг авна. Урт үстэй бол төхөөрөмжинд ороолцолдохоос сэргийлж толгойны ард овоолж тогтооно.
  장신구와 반지 등은 빼고, 머리카락이 긴 경우에는 짧게 고정시켜서 장비에 끼이지 않도록 한다.
- Ажлын хувцасаа бүрэн гүйцэд өмсөж, модны үртэс, тоос шорооноос биеэ хамгаална.
  작업복을 단정하게 입어서 목재 분진과 파편으로부터 신체를 보호한다.
- Арьс зулгарах, шалбарах, буцаж түлхсэн модонд цохиулах зэргээс биеэ хамгаалахын тулд хамгаалалтын халхавч, зузаан арьсаар хийсэн энгэртэй хормогч, урт ханцуйвч, урт өмд өмсөнө.
  열상, 찰과상, 목재의 반발 및 기타 재료와의 부딪힘 으로부터 신체를 보호하기 위해서 보호 패드 또는 두꺼운 가죽으로 된 가슴 받이가 있는 앞치마, 긴소매, 긴바지를 착용한다.

### Нүд болон нүүр хамгаалах
눈과 안면 보호

- Нүд болон нүүрийг модны үртэс, хөрөөний хугарсан шүд, модны тооцонцор зэргээс хамгаалахын тулд бүрэн хаалттай хамгаалалтын шил болон нүүрний хамгаалах хэрэгсэл зүүх хэрэгтэй.
  눈 및 안면을 파편, 부러진 톱날, 목분진 등과 같은 위험 요소로부터 보호하기 위해서 측면 보호대가 있는 보안경(또는 고글형 보안경)과 안면 보호구를 착용해야 한다.

### Сонсгол хамгаалах
청력보호

- Сонсгол хамгаалахын тулд чихний бөглөө болон чихэвч хийнэ. Мод боловсруулах тоног төхөөрөмжөөс гардаг чимээнээс болж сонсгол муудах аюултай.
  청력을 보호하기 위해서 귀마개 또는 귀덮개를 착용한다. 목재가공용 기계·기구 등에서 발생하는 소음으로 인해서 청력이 손상될 수 있다.

### Хөл хамгаалах
발 보호

- Шагай, ул, хөлийн хуруут хамгаалахын тулд хальтрахаас хамгаалдаг урт түрийтэй хамгаалалтын гутал өмсөнө.
  발목, 발바닥, 발가락을 보호하기 위해서 미끄럼 방지 부츠형 안전화를 착용한다.

### Амьсгалын эрхтэн хамгаалах
호흡기 보호

- Ажил олгогч нь ажилчдыг амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгслийг зохих ёсоор нь зөв зүүж хэрэглэдэг болгох хэрэгтэй.
  사업주는 근로자들이 작업에 필요한 올바른 호흡용 보호구를 제대로 밀착시켜 착용하도록 해야 한다.




### Ажлын байран дахь хортой бодисын мэдээлэл
작업장소의 유해 물질 정보

- Ажлын байранд будаг, өнгөлөгч бодис, цавуу, уусгагч бодис хэрэглэдэг бол бодисын хор аюулын лавлах мэдээллийг(MSDS) нягтлан үзэж, шаардлагатай аюулгүй ажиллагааны тэмдгийг ажлын байранд болон тоног төхөөрөмж дээр нааж хадгалж буй саван дээр нь анхааруулах тэмдэг наах ёстой.
  작업장소에서 페인트, 마감재, 접착제, 솔벤트 등과 같은 유해 물질을 사용하는 경우에, 물질안전보건자료(MSDS)를 확인하고 이에 필요한 안전보건표지 등을 작업장소 및 시설에 부착하고 보관 용기에 경고표시를 해야 한다.

### Safety Tips

Мод боловсруулах тоног төхөөрөмжинд ороолцолдон татагдах эрсдэлтэй үед бээлий өмсөхгүй. Ажиллаж буй тоног төхөөрөмж рүү бээлий татагдан орохдоо гарыг ч мөн хамт татан оруулдаг.
목재가공용 기계·기구에 감길 위험이 있는 경우에는 장갑 을 착용하지 않는다. 동작 중인 기계·기구 등에 장갑 함께 손이 감길 수 있다.

OPEN 공공누리

산업재해예방 안전보건공단

# Нийтийн хоол болон үйлчилгээний газрын ажилтнуудад (эзэн, зөөгч, үйлчилгээний ажилтан) зориулсан

# Хувийн хамгаалах хэрэгсэл

음식서비스 종사자(사업주, 종업원, 안내원)를 위한 개인보호구

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 876

Mongolia

## Хамгаалах арга 보호 방법

### Хөлний хамгаалалт
발 보호

- Хамгаалалтын гутал нь гүйцэтгэж байгаа ажлын нь төрөлд тохирсон байх хэрэгтэй бөгөөд цэвэрхэн өмсөж хэрэглэнэ. 안전화는 수행하는 작업 종류에 적합해야 하고 양호 한 상태로 관리해야 한다.

- Асгарсан хоол болон ундаа, шатах тослох материал, тосонд бохирдсон шалан дээр хальтарч унах, хальт гишгэхээс хамгаалахын тулд хальтардаггүй резинэн ултай хамгаалалтын гутал өмсөх хэрэгтэй.
  음식물, 음료수, 윤활제, 오일 등으로 오염된 바닥에서 미끄러짐, 헛디딤, 떨어짐 등을 방지하기 위해 미끄럼 방지 밑창이 있는 안전화를 착용 해야 한다.
- Халуун, шингэн зүйлийг алдаж асгах үед нэхмэл эдлэлээс болж түлэгдэх магадлалтай. Нилон, плиэстр зэрэг нийлэг даавуу хайлж арьсанд наалддаг. Түлэгдэлтээс хамгаалахын тулд дээрээ нүхгүй, зузаан арьсан хамгаалалтын гутал өмсөх хэрэгтэй.
  뜨거운 액체를 쏟는 경우에 천을 통해서 화상을 입을 수 있다. 가령 나일론이나 폴리에스테르와 같은 합성 섬유 물질이 녹아서 피부에 달라붙을 수 있다. 화상을 방지하기 위해서는 안전화 상단이 구멍 문양이 없고 튼튼한 가죽으로 된 것으로 착용해야 한다.
- Хүнд хоол өргөх, зөөх, түрэх, татах үед хальрахаас хамгаалсан гутал өмсөх хэрэгтэй.
  무거운 음식 등을 들거나, 운반하거나, 밀거나, 당길 때는, 미끄럼 방지 안전화를 착용해야 한다.
- Намхан өсгийтэй гутал өмсвөл удаан зогсох, алхаж явах, шал болон налуу газраар явахад төвөггүй.
  굽이 낮은 안전화를 착용하면 서있거나, 걷거나, 계단이나 경사로를 오를 때 편안하다.

Халуун зүйлд хүрэх буюу зөөхдөө хуурай алчуураар гараа түлэгдэхээс хамгаал.
마른 천을 사용해서 화상으로부터 손을 보호한다.





Ул нь том хээтэй гутал хальтардаггүй.
뚜렷한 패턴(형태)의 밑창은 미끄러짐을 방지한다.



### Гарны хамгаалалт
손 보호

- Халуун аяга, таваг, цар зөөхдөө хуурай алчуур, бариул зэрэг гар хамгаалах хэрэгсэл ашиглан гараа хамгаална.
  뜨거운 그릇, 접시, 쟁반을 나를 때, 마른 천, 집게 등의 손 보호구를 사용하여 손을 보호 한다.

### Хамгаалалтын хувцас
보호복

- Гадаа ажиллах тохиолдолд ажлын нөхцөл байдалд тохирсон ажлын хувцас болон гутал өмсөнө. (Жишээ: Гадаа талбайд хоол зөөх болон үйлчилгээ үзүүлэх)
  외부에서 작업하는 경우, 근무 환경에 맞는 작업복과 안전화를 착용한다.
  (예 : 실외에서 식음료 운반을 하거나 안내를 하는 등)

OPEN 공공누리

산업재해예방 안전보건공단

# Ойн аж ахуйн ажилчинд зориулсан хувийн хамгаалах хэрэгсэл

임업 관련 종사자를 위한 개인보호구

조심조심 코리아
작업전 안전점검 당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 875

Mongolia

## Хамгаалах арга 보호 방법

### Хувцас
복장

- Бөгж зэрэг гоёл чимэглэлийн зүйлийг тайлна.
  장비나 나뭇가지에 장신구와 반지 등이 걸리지 않도록 벗는다.
- Чөлөөтэй хөдөлж болохоор биед таарсан, эвтэйхэн хувцас өмсөнө.
  자유롭게 움직일 수 있도록 몸에 맞는 편안한 작업복을 착용한다.

### Тод харагдах(холоос сайн харагдах) хувцас өмсөнө.
시인성(먼 거리에서도 잘 보이는 정도)이 높은 작업복

- Ажиллаж буй орчны өнгөнөөс өөр, тод өнгөтэй, холоос ч гэсэн сайн харагдах хувцас өмсөнө.
  작업 환경과 대비되는 색상의 시인성이 높은 작업복을 착용해서 멀리서도 보일 수 있도록 한다.
- Дараах тохиолдолд тод харагдах хувцас өмсөнө.
  다음과 같은 경우, 시인성이 높은 작업복을 착용한다.

  - Машины орчим, зөөврийн машин механизмын орчим, ойд ажиллахдаа
    자동차 주변, 이동식 장비 주변, 숲속에서 작업할 때
  - Ганцаараа ажиллах юм уу бусад хүмүүсээс хол ажиллахдаа
    단독 작업 또는 다른 사람들과 떨어져서 작업할 때
  - Шөнийн цагаар мод бэлтгэхдээ
    야간에 벌목 작업을 할 때
  - Ажлын бүсийн хажуугаар машин өнгөрч явдаг бол, эсвэл ямар нэг зүйл унадагаас болж хориг тавьсан үед
    작업 지역을 지나는 차량이 있거나 떨어지는 물체가 있어 통제를 할 때




### Хөлний хамгаалалт
다리 보호

- Гинжин хөрөөгөөр ажиллах үедээ хамгаалалтын өмд, савхин хормогч, зүсэгддэггүй даавуугаар хийсэн хормогч зэрэг хөл хамгаалах хувцас өмсөнө. 기계톱으로 작업할 때, 안전 바지, 가죽 덧바지, 또는 베임 방지 재질의 앞치마와 같은 다리 보호구를 착용한다. ('가죽 덧바지'와 '앞치마'는 종종 같은 의미로 사용된다.)

  - Зүсэгддэггүй даавуугаар хийсэн хамгаалах хэрэгсэл нь өмдний салтаанаас доош, шагайнаас дээш 7,5 см хүртэл урттай, хөлний урд болон хажуу талыг бүхэлд нь халхалсан байх ёстой.
    베임 방지 재질의 다리 보호구가 바지 가랑이 부위 부터 발목 위 7.5cm까지의 다리 전면과 옆면을 보호 할 수 있는지 확인한다.
  - Зүсэгддэггүй даавуугаар хийсэн хамгаалах хэрэгсэл нь холхогнож хөдөлдөггүй байх ёстой.
    베임 방지 재질의 다리 보호구가 다리를 제대로 보호할 수 있도록 작업 중에 보호구가 헐렁하게 움직이지 않아야 한다.
    - Хамгаалалтын өмд бараг хөдөлдөггүй тул хамгийн тохиромжтой.
      안전 바지는 많이 움직이지 않으므로 안전 바지 착용을 고려한다.
    - Савхин хормогч хөлөнд орооцолдох магадлалтай. Оосрыг чанга татаж, ойр ойрхон чангалж тохируулж байх хэрэгтэй. 가죽 덧바지는 다리 둘레에 꼬일 수 있다. 고정끈을 단단히 조이고, 수시로 조절해서 고정되도록 한다.
  - Хөлний хамгаалалт нь хөдлөхөд эвтэйхэн чөлөөтэй байх ёстой боловч хэтэрхий элбэг том, аюул учруулахаар байж болохгүй. 다리 보호구는 작업 활동이 자유롭도록 충분히 편안해야 하지만 너무 느슨하여 안전에 위험이 되어서는 안된다.
  - Ойн түймэр унтраах ажлын үеэр хөлний шатдаггүй хамгаалалт хэрэглэх хэрэгтэй.
    산불을 진화하는 경우에, 다리 보호구는 방염 재질로 되어있어야 한다.

산업재해예방 안전보건공단

## Хөлний хамгаалалт

발 보호

- Хөлийн шагай, ул, хөлийн хурууг хамгаалахын тулд хамгаалалтын гутал өмсөнө. 20 см-ээс урт түрийтэй хамгаалалтын гутал өмсвөл шагайг хангалттай хамгаалж чадна.
  발목, 발바닥, 발가락을 보호하기 위해서 안전화를 착용한다. 최소한 20cm 이상 높이의 부츠형 안전화를 착용하면 발목을 잘 보호할 수 있다.

> - Гинжин хөрөөгөөр ажиллахдаа гинжин хөрөөнөөс хамгаалах зориулалтын гутал өмсөнө.
>   기계톱으로 작업할 때는 기계톱 보호용 안전화를 착용한다.
> - Дүнз, багана, шонгийн мод зэрэг дугуй хэлбэртэй модон материал дээгүүр явахдаа доргилтоос хамгаалдаг, хальтрах, хурц үзүүртэй зүйлд хатгуулахаас хамгаалдаг хамгаалалтын гутал өмсөнө.
>   통나무, 기둥, 말뚝, 또는 기타 둥근 목재 위를 걸을 때 방진 기능과 미끄러짐, 찔림 등의 위험으로부터 효과적으로 보호할 수 있는 안전화를 착용한다.




## Толгойн хамгаалалт

머리 보호

- Толгой дээр мөчир унахаас сэргийлж хамгаалах дуулага өмсөх хэрэгтэй. Хамгаалах дуулгыг тайлагдахгүй болтол нь эрүүний оосрыг сайтар чангалж өмсөнө.
  떨어지거나 날아오는 나뭇가지, 나무줄기 등의 위험으로부터 보호하기 위해서 안전모를 착용해야 하며, 착용 시에는 턱끈을 조여 벗겨지지 않도록 한다.
- Чихэвчтэй, нүүрний хамгаалалттай хамгаалах дуулга өмсөхийг зөвлөж байна.(Чихэвч, нүүрний хамгаалалт нь салдаг байж болно)
  안전모는 귀덮개와 안면 보호기능이 있는 것을 권장 한다. (기능이 분리된 각각의 보호구 착용 가능)
- Ажиллаж байгаа орчныхоо өнгөнөөс өөр өнгөтэй хамгаалах дуулга өмсөнө. 작업 환경과 대비되는 색상의 안전모를 착용한다.

## Нүд болон нүүрний хамгаалалт

눈 및 안면 보호

- Гадны биет нүд, нүүр лүү үсэрч орохоос сэргийлж хамгаалалтын шил, нүүрний хамгаалалт зүүдэг.
  날아오는 파편으로부터 눈 및 안면을 보호하기 위해서 보안경과 안면 보호구를 착용한다.

## Сонсгол хамгаалах

청력 보호

- Гинжин хөрөөгөөр ажиллах юм уу орчин тойронд их дуу чимээтэй төхөөрөмж ажиллаж байгаа үед сонсголоо хамгаалах зорилгоор чихэвч болон чихний бөглөөс хийнэ.
  기계톱을 사용하거나 주변에 소음이 심한 장비가 있어서 강렬한 소음에 노출되는 경우에 귀덮개 또는 귀마개를 착용한다.

## Гарны хамгаалалт

손 보호

- Гарын арьс шалбарах, юманд цохигдох, доргих, даарах, норох, хортой ургамалд хатгуулах зэргээс гараа хамгаалахын тулд хамгаалалтын бээлий өмсдөг. Өнгөлгөөний ажил гүйцэтгэх, гинжин хөрөөгөөр ажиллах, тороос болон төмөр зүйлтэй харьцахдаа мөн өмсөж хэрэглэнэ. Хамгаалалтын бээлий нь гарт эвтэйхэн, ажиллахад төвөггүй байх хэрэгтэй. 자상, 찰과상, 파편 조각, 진동, 추위, 습기, 독성 식물로부터 손을 보호하거나, 연마 작업 및 기계톱을 다루거나, 와이어 로프 또는 금속 물체를 다루는 경우에 손을 보호하기 위해서 착용감과 사용감이 좋은 안전 장갑을 착용해야 한다.
- Доргилтоос хамгаалдаг байх ёстой. 진동 보호 기능이 있어야 한다.

## Амьсгал хамгаалах хэрэгсэл

호흡기 보호

- Ой модыг арчлан хамгаалахын тулд химийн бодис цацдаг. Ингэхдээ амьсгалын эрхтэнг хорт бодисноос хамгаалах маск зүүх хэрэгтэй. Хэрвээ маск зүүх шаардлагатай бол ажил олгогч тухайн ажилд тохирсон маскыг сонгож ажилчинд олгоно. Ажилчин, маскыг зүүх, цэвэрлэх, байнгын бэлэн байдлыг хангах, засах, хадгалах аргад суралцаж, зөв ашиглах хэрэгтэй.
  수목 관리를 위해서 화학 물질을 분사할 때는 호흡 유해인자로부터 호흡기를 보호하기 위해서 호흡용 보호구를 착용해야 한다. 만일 호흡용 보호구를 착용할 필요가 있다면, 사업주는 작업 내용에 적합한 것으로 선정하여 근로자에게 지급해야 한다. 근로자는 호흡용 보호구 착용 방법, 세척 방법, 유지·보수, 보관 방법 등을 포함해서 올바른 사용법을 교육받고 착용해야 한다.

Загасны аж ахуйн ажилчинд зориулсан хувийн хамгаалах хэрэгсэл
어업 관련 종사자를 위한 개인보호구

# Толгой, нүд, нүүр, гар болон хөл

머리, 눈, 안면, 손과 발

조심조심 코리아
작업 전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 874

Mongolia

## Толгой, нүд, нүүр

머리, 눈, 안면

### Хамгаалах арга 보호 방법

#### Толгойн хамгаалалт

머리 보호

- Үсээ богиносгох юм уу ардаа боох. Ингэснээр дамар, хүрд зэргийг орооход хэрэглэдэг ороогчинд орооцолдохгүй.
  머리카락을 짧게 하거나 뒤로 묶어서 구동 풀리(pully), 권양기, 양망 등을 감을 때 사용하는 캡스턴(capstan) 등에 감기지 않도록 한다.

#### Нүд болон нүүрний хамгаалалт

눈 및 안면 보호

- Хийж буй ажилдаа тохирсон хамгаалалтын шил зүүнэ.
  작업 종류에 적합한 보안경을 착용한다.
  - Ямар нэгэн зүйлийг өнгөлөх болон хурц иртэй зүйлтэй ажиллахдаа нүүрний хамгаалалттай нүдний шил, мөн хамгаалалтын шил зүүнэ. 연마 작업, 고정되지 않았거나 날카로운 물체를 다룰 때에는 측면 보호대가 있는 보안경 또는 고글형 보안경을 착용한다.
- Хортой, аюултай бодистой ажиллахдаа, Бодисын хор, аюулын лавлах мэдээлэл(MSDS) болон анхааруулах тэмдгийг уншиж, нүд болон нүүрээ хамгаалах шаардлагатай эсэхийг мэдэж авна.
  유해·위험 물질을 다룰 때에는, 물질 안전 보건 자료(MSDS: Material Safety Data Sheet) 또는 경고표시를 확인해서 눈과 얼굴 보호가 필요한지 확인한다.



### Аюулгүй ажиллагааны талаарх товчхон мэдээлэл 안전에 관한 간단한 정보

- Наранд нүд гялбахыг бууруулахын тулд бууралттай шил, нарны шил зүүнэ.
  직사 광선에 의한 눈부심을 감소시키기 위해서 착색 보안경 또는 선글라스 착용을 고려한다.
- Хурц нартай өдөр, мөн бүрхэг өдөр ч гэсэн нүүрээ хамгаалахын тулд малгай(бэйсболын малгай, хамгаалалтын малгай, өргөн хүрээтэй малгай) өмсөнө. 직사 광선 또는 흐린 날씨에도 얼굴 보호를 위해서 모자(야구 모자, 안전모 또는 챙이 넓은 모자)를 착용한다.
- Нарны тос түрхэнэ.
  자외선 차단제를 바른다.
  - Нартай болон бүрхэг өдөр
    여름 및 흐린날 포함
  - Наранд удаан ил байвал арьсны хавдартай болох магадлалтай.
    직사 광선에 장기간 노출되면 피부암이 발생할 수 있다.

# Гар болон хөл
손과 발

## Хамгаалах арга 보호 방법

### Гарны хамгаалалт
손 보호

- Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, загас зэргээс болж арьсаа гэмтээж болох дараах тохиолдолд, бээлий болон ханцуйвч өмсөх хэрэгтэй.
  아래와 같이 장비, 장치, 또는 생선 등에 의해서 피부가 손상을 입을 수 있는 경우, 장갑과 보호용 토시를 착용해야 한다.
  - Хөдөлж буй олстой ажиллахдаа
    로프와 같이 움직이는 줄을 다룰 때
    - Бүх төрлийн олс түлэх аюултай
      모든 종류의 로프는 화상을 입힐 수 있다.
    - Сэртийсэн буюу тасарсан тороосны утас арьс руу шигдэн орох буюу зүсэх аюултай.
      와이어 로프에는 앞으로 삐져나온 끊어진 와이어가 있어서 피부에 박히거나 베일 수 있다.
  - Загасны уургыг хөдөлгөх, уурганы дэгээ болон загасыг барихдаа, өгөөш шидэхдээ
    낚시대를 다룰 때(낚시 할 때), 낚시 바늘이나 물고기를 다룰 때, 또는 미끼를 다질 때
  - Резинэн хоолойгоор хөлгийн тавцанг цэвэрлэхдээ
    호스로 갑판을 청소할 때
  - Тортой ажиллахдаа, агнуурын газар усан онгоцыг бэхлэн зогсоохдоо, хаягдсан хясааны хавтас гэрийг цэвэрлэхдээ
    그물을 다룰 때, 부두에 배를 고정시킬 때, 따개비(barnacle) 제거 작업시 베이지 않도록 할 때
- Ажилд тохирсон бээлий хэрэглэнэ.
  작업 내용에 적합한 장갑을 선택한다.
  - Ус, загасны яс, хүйтэн ус, тор, олс зэрэг зүйлтэй ажиллахдаа дээд зэргийн чанартай хамгаалалтын резенин бээлий өмсөнө. 물기, 생선의 뼈, 차가운 냉기, 그리고 그물이나 줄 같은 장비를 사용할 때는 (고품질의) 보호용 고무 장갑을 착용한다.
  - Даавуун дотортой резенин бээлий өмсөхөд гарт эвтэйхэн байдаг.
    고무 장갑 안쪽에 천으로 된 장갑을 착용하면 착용감도 좋아진다.



### Хөлний хамгаалалт
발 보호

- Хөлгийн тавцан хальтаргаатай үед ус болон хальтаргаанаас хамгаалсан хамгаалалтын гутал(хальтардаггүй резинэн ултай) өмсөнө.
  갑판 표면이 미끄러운 경우, 방수 및 미끄럼 방지 처리된 안전화(흡착식 밑창이 달린 고무장화 등)를 착용한다.



OPEN 공공누리

# Сонсгол
청력

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 873

Mongolia

## Загасны аж ахуйн ажилчны дуу чимээнээс болсон дүлийрэл 어업 관련 종사자의 소음성 난청

### Загас агнуурын завин дээр байнга их дуу чимээ гарч байдаг бөгөөд удаан хугацааны нөлөөлөл нь дүлийрэхэд хүргэдэг.

어선에서는 큰 소음이 항상 발생하고 있으며 장시간 노출되면 소음성 난청이 발생할 수 있다.

- Удаан хугацаагаар их дуу чимээтэй газар байх тохиолдолд чихэвч болон чихний бөглөө зэрэг сонсгол хамгаалах хэрэгсэл хэрэглэх хэрэгтэй.
  장시간 소음에 노출되는 경우에는 귀덮개나 귀마개와 같은 청력 보호구를 착용해야 한다. 일반적인 귀덮개나 귀마개는 적합하지 않을 수 있다. 이런 종류의 것들은 소리를 너무 차단해서 다른 선원들과 대화를 제대로 나누지 못할 수 있다. 소음을 줄이면서도 장비와 사람들 소리를 들을 수 있도록 제작된 귀덮개와 귀마개를 사용한다.
- Хөгжим сонсох зориулттай чихэвчийг сонсгол хамгаалах хэрэгсэл болгон ашиглах нь тохиромжгүй. Учир нь анхааруулах дохио болон хамт ажилладаг хүмүүсийнхээ яриаг сонсож чадахгүй. Мөн чихэвчээр хөгжим сонсох нь сонсголыг муутгадаг.
  (음악 감상용) 이어폰(이어 버드)은 청력 보호구로 적절하지 않으며 긴급 경고 신호나 동료들의 대화를 들을 수 없다. 또한 이어폰을 통해서 음악을 큰 소리로 들으면 청력이 손상된다.

## Агнуурын завины дуу чимээний түвшин 대표적인 어선의 소음수준

- 85dBA-с их хэмжээтэй дуу чимээнд удаан хугацаагаар байхад дуу чимээнээс шалтгаалсан дүлийрэл үүснэ.
  85dBA 이상의 소음에 장시간 노출되는 경우에 소음성 난청이 발생할 수 있다.

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Компрессор 압축기 | 90 ~ 105 dBA | Тавцан 갑판 | 88 ~ 100 dBA | Дамарт эргүүлэг 권양기 | 90 ~ 100 dBA | Завийг засах үед 선박 수리시 | 70 ~ 100 dBA |
| Хөдөлгүүрийн хэсэг 엔진실 | 90 ~ 114 dBA | Гудам 통로 | 75 ~ 80 dBA | Залуурчийн бүхээг 조타실 | 80 ~ 90 dBA | Унтлагын секц 잠자는 장소 | 50 ~ 80 dBA |

※ Дуу чимээтэй ажил: 1 өдрийн 8 цагийн турш 85dBA-с дээш хэмжээтэй дуу чимээ үүсдэг ажлыг “дуу чимээтэй ажил” гэж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулинд заасан байдаг.
소음작업 : 산업안전보건법에는 1일 8시간 작업을 기준으로 85dBA 이상의 소음이 발생하는 작업을 말한다.



OPEN 공공누리

산업재해예방 안전보건공단

Загасны аж ахуйн ажилчинд зориулсан хувийн хамгаалах хэрэгсэл
어업 관련 종사자를 위한 개인보호구

# Аврах хантааз-Ашиглалт ба хадгалалт

구명 조끼(구명 동의) – 관리

조심조심 코리아
작업전 안전점검 당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 872

Mongolia

## Аврах хантаазыг зохистой ашиглалт ба хадгалалт 구명 조끼(구명 동의) 관리를 위해서 해야할 일

- Аврах хантаазыг ашиглах болон хадгалахдаа(тусгай зүйлийн талаар) үйлдвэрлэгчийн зааварчилгаа дагана.
  특별한 관리 사항에 대해서는 제조사의 지침을 따른다.
- Аврах хантаазыг өмсөхийн өмнө бүрэн бүтэн эсэхийг шалгана.
  구명 조끼(구명 동의)를 착용하기 전에 양호한 상태인지 점검 한다.

  - Төмөр болон хуванцар эдүүд нь хугарах юм уу хэлбэрээ алдсан эсэх, элэгдэж муудсан эсэхийг шалгана.
    금속 또는 플라스틱 부품이 부러지거나 변형되거나 또는 부식으로 약해졌는지 확인
  - Уяа бүч нь унасан, мөн урагдсан эсэх, залгасан хэсгээсээ салсан эсэхийг шалгана.
    고정끈 또는 띠가 뜯어지거나, 찢어지거나 또는 연결부에서 분리되었는지 확인
  - Уяа бүс болон бусад хэсгүүдийг хэдэн удаа татаж үзэн элэгдэж муудсан эсэх, хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгана. 부속품을 여러 번 당겨보았을 때 부식되었거나 기능을 제대로 못하는지 확인
  - Даавуу болон бүрсэн гадаргуу нь онги татагдаж, урагдаж, залгаас хэсэгт завсар гарах зэргээр хөвөх чадвар нь аладагдсан эсэхийг шалгана.
    천이나 코팅면이 뜯어지거나, 찢어지거나, 이음매가 벌어져서 부력이 없는지 확인
  - Хөвөх чадвар бүхий материал нь хатсан, хэлбэр нь өөрчлөгдсөн, тос болсон, хөгцөрсөн эсэхийг шалгана.
    부력재가 경화, 영구변형, 기름 흡수 또는 세균이나 곰팡이의 흔적 등이 있는지 확인
  - Хөвөх чадвар бүхий материал байх ёстой газраа байгаа эсэхийг шалгана.
    부력재가 소실되거나 원래 위치에 고정되어 있는지 확인

- Хэрвээ аврах хантааз урагдаж гэмтсэн бол аюулгүй ажиллагааны байцаагч(хөлгийн ахмад) болон хөлгийн эзэнд мэдэгдэнэ. Урагдаж, гэмтсэн хантаазыг өмсөж болохгүй.
  손상된 구명 조끼(구명 동의)에 대해서 관리 감독자(선장) 또는 선주에게 보고한다. 손상된 구명 조끼(구명 동의)를 착용 해서는 안된다.
- Аврах хантаазыг зохих ёсоор цэвэрлэж хадгална. 구명 조끼(구명 동의)를 적절하게 세척, 보관한다.

  - Аврах хантаазыг зөөлөн савантай усаар угаана.
    순한 비눗물을 사용해서 구명 조끼(구명 동의)를 세척한다.
  - Аврах хантаазны хир толбыг арилгахын тулд хими цэвэрлэгээнд өгөх, хүчтэй угаалгын бодисоор угаах, бензин болон органик уусгагч хэрэглэж болохгүй.
    구명 조끼(구명 동의)의 얼룩을 제거하기 위해서 드라이 클리닝, 강한 세제, 휘발유, 또는 유기 용제를 사용하지 않는다.
  - Аврах хантаазыг нойтон хэвээр нь хадгалж болохгүй. Хадгалахын өмнө нарны илч болон халуун газраас хол, агаар сайн нэвтэрдэг газар хатаана.
    구명 조끼(구명 동의)는 젖어있는 상태로 보관하지 않는다. 먼저 직사 광선이나 뜨거운 열원을 피해서 자연 건조 시킨다.
  - Аврах хантаазыг хэрэглээгүй байхдаа, усан онгоцны хуурай, агаар сайн нэвтэрдэг, хурдан гаргаж ирэх боломжтой газар хадгална.
    구명 조끼(구명 동의)를 사용하지 않을 때는, 어선내 건조하고 환기가 잘되며 쉽게 사용할 수 있는 곳에 보관한다.




- Аврах хантааз автоматаар хийлэгдэж байгаа эсэх, хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгасан тухай, мөн хэрхэн ашиглаж, хадгалж байгаа тухай бичиж тэмдэглэнэ.
  구명 조끼(구명 동의)가 자동으로 부풀어올라 정상 기능을 할 수 있는지에 대한 점검 및 유지·관리 내용을 기록해 놓는다.

OPEN 공공누리

산업재해예방 안전보건공단

Загасны аж ахуйн ажилчинд зориулсан хувийн хамгаалах хэрэгсэл
어업 관련 종사자를 위한 개인보호구

# Аврах хантааз-Сонгох

구명 조끼(구명 동의) – 선정

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 871

Mongolia

## Хөвөх чадварын түвшин 부력 등급

- Аврах хантаазны хөвөх чадвар нь хамгийн багадаа 75N(Newton)-аас дээш байх ёстой. Хөвөх чадварын түвшин гэдэг нь аврах хантааз усны мандал дээр хөвүүлэх боломжтой жинг хэлнэ. Аврах хантаазны хөвөх чадварын түвшин нь ажилчны биеийн жин, хамгаалах хэрэгслийн жинтэй таарч байх ёстой.
구명 조끼(구명 동의)의 부력은 최소한 75N(Newton) 이상이어야 한다. 부력 등급은 구명 조끼(구명 동의)가 물 위에서 자연 스럽게 유지할 수 있는 중량을 의미한다. 구명 조끼(구명 동의)의 부력 등급은 작업자의 체중과 의복, 그리고 보호구를 모두 포함한 중량에 적합해야 한다.
- Ганцаараа ажиллаж байх тохиолдолд хөмөрдөггүй, автомат хийлэгчтэй 93N(Newton)-ээс дээш хөвөх чадвартай хувийн хөвөх хэрэгсэл(PFD) болон аврах хантаазыг хэрэглэ.
단독으로 작업하는 경우, 전복되지 않고 자동 복원력이 있는 93N(Newton) 이상의 부력을 가진 개인 부양 기구(PFD) 또는 구명 조끼를 착용을 권장한다.

※ “Ганцаараа ажиллах” гэдэг нь усанд унасан тохиолдолд тэр даруй тусламж авах боломжгүй газар ажиллахыг хэлнэ.
'단독으로 작업한다'는 의미는 물에 빠졌을 때 즉시 도움을 받을 수 없는 장소에서 작업함을 말한다.

## Хэмжээ 크기

- Аврах хантааз нь биеийн хэмжээнд таарсан байх ёстой. Хэт том бол усанд ороход амархан сугардаг. Цээжний өргөн болон биеийн жиндээ тааруулан хэмжээг нь сонгоорой.
구명 조끼(구명 동의)는 신체 크기에 맞아야 한다. 너무 크면 물에 들어갔을 때 미끄러져 벗겨질 수 있다. 가슴 크기와 체중을 기준으로 적정 크기를 선택한다.

### » Биедээ таарсан аврах хантааз сонгох арга 몸 맞는 구명 조끼(구명 동의) 선택방법

- Өмссөнийхөө дараа биед сайн таарч байгаа эсэхийг шалгана.
착용 후, 몸에 잘 맞는 지 확인해 본다.
  1. Үйлдвэрлэгчийн зааврын дагуу өмсөж, оосор, даруулга зэргийг бэхэлнэ. Өмсөхөд биед эвтэйхэн бие барьсан байх хэрэгтэй.
  제조사의 설명에 따라서 착용하고 조임끈이나 기타 고정 장치를 사용한다. 불편하지 않을 정도로 몸에 밀착되어야 한다.
  2. Өөр хүнээр мөрнөөсөө татуулж үзнэ. Хэрвээ аврах хантааз хамар болон нүүрэн дээгүүр хурдан тайлагдаж байвал даруулга оосрыг илүү чангална. Хэрвээ чангалсан ч мултарч байвал хантааз томдсон гэсэн үг. 다른 사람이 어깨 위로 당겨보도록 한다. 만일 구명 조끼(구명 동의)가 코나 얼굴 부위로 빠르게 벗겨진다면, 조임끈을 더 강하게 조인다. 만일 계속 벗겨진다면 크기가 너무 큰 것이다.
- Биед эвтэйхэн байлгахын тулд ердийн үед ажиллахдаа өмсдөг хувцастайгаа аврах хантаазыг өмсөж үзнэ.
최상의 착용감을 위해서는, 평소 작업 시 착용했던 복장 상태로 구명 조끼(구명 동의)를 착용해 본다.
- Боломжтой бол усан сан юм уу гүехэн устай голд аврах хантаазаа өмсөн орж, аврах хантааз ямар үүрэг гүйцэтгэдэг болохыг туршиж үзнэ. Урьдчилан туршиж үзсэн бол гэнэтийн осол гарсан үед хэрэгтэй арга хэмжээг сандралгүй авч чаддаг.
가능하다면, 수영장이나 얕은 물에서 구명 조끼(구명 동의)가 어떤 역할을 하는지 시험해 본다. 구명 조끼(구명 동의)가 어떤 역할을 하는지 미리 체험해보면, 실제 응급 상황에서 잘 대처할 수 있다.

## Шинэ аврах хантаазыг ашиглахын өмнө 새로운 구명 조끼(구명 동의)를 사용하기 전에

- Үйлдвэрлэгчийн зүгээс өгсөн ашиглах зааврыг(зөв зохистой ашиглах арга, ашигласны дараа хийг гаргах арга, эвхэх болон дэлгэх арга, тусгайлсан заавар, цэвэрлэх болон хадгалах арга) уншина.
제조사의 사용 설명서(올바른 사용법, 사용 후 공기 배출 방법, 접고 펴는 방법, 특정한 관리법, 세척 및 보관 방법 등)를 읽어본다.
- Хэрэглэгчийн биеийг хөвүүлж чадах, өмсөөд ажиллахад биед эвтэйхэн , зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүнийг сонгоно.
사용자의 신체를 부양할 수 있고, 착용 후 작업이 용이한 형식 승인된 제품을 선택한다.

OPEN 공공누리

산업재해예방 안전보건공단

Загасны аж ахуйн ажилчинд зориулсан хувийн хамгаалах хэрэгсэл
어업 관련 종사자를 위한 개인보호구

# Аврах хантааз-Өмсөх
구명 조끼(구명 동의) – 착용

조심조심 코리아
작업전 안전점검 당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 870

Mongolia

## Агнуурын завин дээр өмсөх аврах хантааз 어선 구명 조끼(구명 동의) 착용

- Аврах хантаазны хөвөх чадвар нь хамгийн багадаа 75N(Newton)-аас дээш байх ёстой. Хамгийн багадаа 24 цагаас дээш хугацаагаар усан дээр хөвөр чадвартай байх бөгөөд шүгэл зүүсэн байна. (Далай болон загас агнуурын яамнаас гаргасан загас агнуурын завины тоног хэрэгслийн жагсаалтыг үзнэ үү.)
  구명 조끼(구명 동의)의 부력은 최소한 75N(Newton) 이상이고 최소 24시간이상 물위에서 부력이 확보 되어야 하며 호각이 부착되어 있어야 한다.
  (해양수산부 고시 어선용품의 형식승인 시험 및 검정 등에 관한 기준 참조)
- Ганцаараа ажиллаж байх тохиолдолд хөмөрдөггүй, автомат хийлэгчтэй 93N(Newton)-ээс дээш хөвөх чадвартай хувийн хөвөх хэрэгсэл(PFD) болон аврах хантаазыг хэрэглэ.
  단독으로 작업할 경우, 전복되지 않고 자동 복원력이 있는 93N(Newton) 이상의 부력을 가진 구명 조끼(구명 동의)착용을 권장한다.

  ※"Ганцаараа ажиллах" гэдэг нь усанд унасан тохиолдолд тэр даруй тусламж авах боломжгүй газар ажиллахыг хэлнэ.
  '단독으로 작업한다'는 의미는 물에 빠졌을 때 즉시 도움을 받을 수 없는 장소에서 작업함을 말한다.
- Усанд унасан тохиолдолд олоход амархан болгохын тулд аврах хантаазны уснаас ил гарсан хэсэгт цагаан болон мөнгөлөг өнгөтэй гэрэл ойлгогч туузыг бэхэлсэн байх хэрэгтэй.
  물속에 빠졌을 때 쉽게 발견될 수 있도록, 구명 조끼의 수면 윗부분에 역반사재(흰색 또는 은색 반사체 등)가 부착되어 있어야 한다.
- Аврах хантааз нь хийлээгүй буюу хөвөгчгүй, эвхээстэй байгаа бол усанд орох үед автоматаар хийлэгдэх, эсвэл нэг удаагийн хөдөлгөөнөөр хийлэгддэг төхөөрөмжтэй, эсвэл амаар үлээн хийлэх боломжтой байх ёстой.
  구명 조끼(구명 동의)가 부력이 없는 상태로 접혀진 형태라면, 침수 시 자동적으로 팽창하고, 한 번의 수동 동작으로 팽창될 수 있는 장치를 가지고 있어야 하며, 입으로 불어 팽창시킬 수 있어야 한다.
- Автоматаар хийлэгддэг аврах хантаазыг хувцсан дээрээ өмсөнө. Хийлэх явцад саад болох ямар нэгэн зүйлийг зүүж, өмсөж болохгүй. 의복 위에 자동 팽창식 구명 조끼를 착용한다. 필요시 팽창을 방해할 수 있는 어떠한 것도 부착하지 않는다.

## Аврах хантаазны хөвөх чадварын түвшингийн талаарх тайлбар
상황마다 구명 조끼(구명 동의) 부력 등급이 다른 이유

- 75N(Newton) хөвөх чадварын түвшинтэй аврах хантааз нь толгойг усан дээр хөвүүлж, ухаан алдуулахгүй байлгах зорилготой. 부력 등급이 75N(Newton)인 구명 조끼는 수면 위로 머리를 부양해서 의식을 유지하기 위한 목적이다.
- 93N(Newton) хөвөх чадварын түвшинтэй аврах хантааз нь ухаангүй байгаа ажилчны толгой, хүзүү, цээжийг усан дээр хөвүүлж байх зорилготой. 부력 등급이 93N(Newton)인 구명 조끼는 의식을 잃은 작업자의 머리, 목, 가슴을 수면 위로 유지하기 위한 목적이다.(단독으로 작업할 때 필요)

## Аврах хантааз өмсөх шаардлагатай тохиолдол 구명 조끼 상시 착용해야 하는 사례



- Жижиг загасчны завинд сууж загачлах тохиолдолд
  소형어선에 혼자 승선하여 어로에 종사하는 경우
- 12-оос доош настай хүүхэд жижиг усан онгоцонд сууж явах тохиолдолд
  12세 미만의 소아가 소형선박에 승선하여 항해하는 경우



- Цаг агаарын байдал муудан, аюулгүй байдлыг хангах шаардлагатай болсон тохиолдолд
  기상 및 해상상태가 악화되어, 안전확보를 위해 필요한 경우
- Жижиг усан онгоцны урд тавцан дээр зогсож явах тохиолдолд 소형선박의 폭로갑판에 승선하고 있는 경우

OPEN 공공누리 공공저작물 자유이용허락

산업재해예방 안전보건공단

# Хортой бодист өртөх магадлалтай ажилчны хувийн хамгаалах хэрэгсэл
유해물질 노출 근로자를 위한 개인 보호구

# Шүүлтүүртэй маск нүүрэнд сайн наалдсан эсэхийг шалгах
안면부 여과식 호흡용 보호구 – 밀착도 점검

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 869

Mongolia

## Маск нүүрэнд сайн наалдсан эсэхийг хэзээ шалгах вэ 밀착도 점검을 해야하는 시기

- Маскыг зүүх болон тохируулах болгондоо шалгана.
  매번 호흡용 보호구를 착용하거나 조절할 때마다 점검 실시

## Шалгах арга 밀착도 점검 방법

1. Масканд амьсгаа авах болон гаргах хавхлага байгаа эсэхийг шалгана.
   호흡용 보호구에 흡기구와 배기 밸브가 모두 있는지 확인한다.
2. Маскны амьсгаа авах болон гаргах хавхлага хэвийн эсэх, зөв угсрагдсан байгаа эсэхийг шалгана.
   흡기구와 배기 밸브가 양호한 상태이고 제대로 부착되어 있는지 확인한다.
3. Маск зүүнэ.
   호흡용 보호구를 착용한다.
4. Маск нүүрэнд эвтэйхэн наалдтал нь толгойн оосрыг татаж чангална.
   호흡용 보호구가 편안하게 밀착될 때까지 머리 고정끈을 조인다.
5. Маск нүүрэнд наалдсан эсэхийг шалгах дараах хоёр аргын нэгээр нь шалгана.
   아래의 두 종류 중 한 가지 밀착도 점검을 한다.

### Сөрөг даралтаар шалгах 음압 밀착도 점검

Амьсгал авах үед маскны дотор сөрөг дарал үүсдэг.
숨을 들이쉴 때(흡입할 때) 안면부 내부에 음압이 발생한다.



1. Гарын алгаар болон хуванцарын хэсэг, мөн тусгайлан хийсэн нэмэлт хэрэгслээр цэвэршүүлэгч болон шүүлтүүрийн амьсгал гаргах хэсгийг таглана. 손바닥, 플라스틱 조각, 또는 특별히 제작된 보조기구를 사용해서 정화통 또는 여과재의 흡기구를 가볍게 덮어서 막는다.
2. Маск дотор вакуум орчин үүсгэхийн тулд амьсгалаа зөөлөн аваад 10 секунд орчим амьсгалаа барина.
   진공 상태를 만들기 위해서 숨을 가볍게 들이킨 후 10초 정도 그대로 있는다.
3. Хэрвээ маск нүүрэнд сайн наалдсан бол дотогшоо бага зэрэг хонхийн тогтоно. Хоёр тал, дээд болон доод талаар нь агаар орохгүй бөмбийх ёстой.
   밀착성이 양호한 경우에는, 안면부가 얼굴 방향으로 약간 접힌 상태를 유지하게 된다. 양 옆, 상단, 또는 하단으로 공기가 새지 않아야 한다.
4. Хэрвээ маск дотогш хонхийн тогтохгүй бол агаар орж байна гэсэн үг. Амьсгал гаргах хавхлагыг шалгаж, маскны байрлалыг өөрчилсний дараа толгойн оосрыг тохируулна. Тэгээд дахин шалгана.
   만일 안면부가 접힌 상태를 유지하지 않는다면, 공기가 새는 것이다. 배기 밸브를 점검하고, 호흡용 보호구 위치를 변경한 후 머리 고정끈을 조절한다. 그리고 밀착도 점검을 다시 실시한다.

### Эерэг даралтаар шалгах 양압 밀착도 점검

Амьсгал гаргах үед маскны дотор эерэг дарал үүсдэг.
숨을 내쉴 때(배출할 때) 안면부 내부에 양압이 발생한다.



1. Гарын алгаар амьсгал гаргах хавхлагыг дарах юм уу таглаагаар таглана.
   손바닥으로 배기 밸브를 덮거나 마개를 부착하여 막는다.
2. Маск дотор вакуум орчин үүсгэхийн тулд амьсгалаа зөөлөн гаргаад 10 секунд орчим амьсгалаа барина.
   진공상태를 만들기 위해서 숨을 가볍게 내쉰 후 10초 정도 그대로 있는다.
3. Хэрвээ маск нүүрэнд сайн наалдсан бол маск бага зэрэг пөмбийн тогтоно. Хоёр тал, дээд болон доод талаар нь агаар алдагдахгүй бөмбийх ёстой.
   밀착성이 양호한 경우에는, 안면부가 불룩해진 상태를 유지하게 된다. 양 옆, 상단, 또는 하단으로 공기가 새지 않아야 한다.
4. Хэрвээ агаар алдагдаж байвал амьсгал авах хавхлагыг шалгаж, маскны байрлалыг өөрчилсний дараа толгойн оосрыг тохируулна. Тэгээд дахин шалгана.
   만일 공기가 샌다면, 흡기구를 확인하고, 호흡용 보호구 위치를 변경한 후 머리 고정끈을 조절한다. 그리고 밀착도 점검을 다시 실시한다.

– Хэд хэдэн удаа давтан шалгасны дараа ч гэсэн маск нүүрэнд сайн наалдахгүй бол, үүний тухай аюулгүй ажиллагааны байцаагчдаа юм уу ажил олгогчдоо мэдэгдэх хэрэгтэй.
밀착도 점검을 몇 차례 한 후에도 밀착이 되지 않는다면, 문제점을 즉시 관리 감독자 또는 사업주에게 보고해야 한다.

OPEN 공공누리

산업재해예방 안전보건공단

Хортой бодист өртөх магадлалтай ажилчны хувийн хамгаалах хэрэгсэл
유해물질 노출 근로자를 위한 개인 보호구

# Шүүлтүүртэй маск - Цэвэрлэх
안면부 여과식 호흡용 보호구 – 세척

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 868

Mongolia

## Ажлын дундуур цэвэрлэх 작업 중 세척하기

- Заримдаа ажлын цагаар маскаа цэвэрлэх шаардлага гардаг. Түр амрах юм уу хоол идсэний дараа, маскаа дахин зүүхийн өмнө маскны нүүрэнд наалддаг хэсэг, маскны дотор талыг чийгтэй алчуулаар арчина.
  작업시간 중에 종종 호흡용 보호구를 간단하게 세척해야 하는 경우가 있다. 잠시 쉬거나 식사 시간 후, 호흡용 보호구를 다시 착용하기 전에 젖은 헝겊을 사용해서 안면 밀착부와 안면부 내부를 닦는다.



## Тогтмол цэвэрлэгээний зааварчилгаа 정기 세척 지침

### 01 Шүүлтүүр болон цэвэршүүлэгчийг салгана.
여과재 또는 정화통을 분리한다.

1. Шүүлтүүр болон цэвэршүүлэгч чийгтэй юм уу норсон байж болохгүй.
   여과재 또는 정화통은 습기가 차거나 젖어 있으면 안된다.
2. Норгосон даавуугаар цэвэршүүлэгчийн гадна талыг арчина. 젖은 천으로 정화통 외관을 닦는다.
3. Цэвэршүүлэгчийн дотор талыг цэвэрлэж болохгүй.
   정화통 내부는 세척하지 않는다.
4. Шүүлтүүр болон цэвэршүүлэгчид будаг болон бусад зүйл наалдсан бол сольж хэрэглэнэ.
   여과재 또는 정화통에 페인트나 이물질이 많이 묻어있는 경우에는 교체한다.

### 02 Толгойн оосор, жийргэвч, амьсгал гаргагч хавхлагыг салгана.
머리 고정끈, 개스킷(gasket), 배기밸브를 분리한다.

### 03 Маскыг бүлээн усанд болгоомжтой угаана. Хэт халуун усанд угаавал маскны хэлбэр алдагдаж магадгүй.
안면부를 따뜻한 물에 넣어 조심히 씻는다.
너무 뜨거운 물을 사용하면 안면부가 변형될 수 있다.

1. Зөөлөн саван хэрэглэнэ.
   순한 비누를 사용한다.
2. Сайн арилахгүй байгаа бохирыг зөөлөн үстэй багсаар үрж арилгана. 잘 제거되지 않는 이물질을 제거할 때는 부드러운 솔을 사용한다.
3. Турпентин, бензин зэрэг органик уусгагчийг огт хэрэглэж болохгүй.
   테레빈유 또는 휘발유와 같은 유기 용제는 절대로 사용하지 않는다.

### 04 Цэвэрхэн, бүлээн усаар маскны саван, ариутгагч бодисыг угааж арилгана.
깨끗하고 따뜻한 물을 사용해서 안면부의 비누 잔유물이나 소독액을 씻어낸다.

### 05 Маскыг цэвэрхэн газар тавих буюу хэцнээс өлгөж хатаана.
안면부를 표면이 깨끗한 장소에 두거나 줄에 일렬로 걸어서 건조시킨다.

1. Маскны хэлбэрийг нь аль болох алдагдуулахгүй хатаах хэрэгтэй.
   안면부가 변형되지 않도록 한다.
2. Усыг нь даавуугаар арчихдаа, зөөлөн, даавуу хэрэглэнэ.
   천을 사용해서 물기를 닦는 경우에, 부드럽고 보푸라기가 없는 천을 사용한다.

### 06 Амьсгал гаргах хавхлага болон жийргэвчийг болгоомжтой угаана.
배기밸브와 개스킷(gasket)을 주의해서 씻는다.

1. Хуурай газар амьсгал гаргах хавхлага хэлбэрээ алдахгүй байхаар хатаана.
   건조한 공기 중에서 말리며, 배기밸브가 원래 모양을 유지하도록 건조한다.
2. Хэлбэрээ алдсан, гэмтсэн хавхлагыг шинээр солино.
   휘어지거나 손상된 배기밸브는 새 것으로 교체한다.

### 07 Маскны бүх эд ангийг үйлдвэрлэгч нь баталгаажуулсан эсэхийг шалгаж, зөв угсрана.
호흡용 보호구의 모든 부품이 제조사 인증을 받은 것인지 확인하고 정확한 위치에 재조립한다.

### 08 Шүүлтүүр болон цэвэршүүлэгчийг дахин угсарна.
여과재 또는 정화통을 다시 부착한다.

Маск цэвэрлэх болон ариутгах энэхүү зааварчилгаа нь бүтээгдэхүүнээс хамаарч харилцан адилгүй байж болох тул үйлдвэрлэгчийн зааварчилгааг дагах хэрэгтэй.
위 호흡용 보호구의 세척 및 소독 지침은 제품별 상이할 수 있으므로 제조사의 지침을 따라야 함

OPEN 공공누리

# Хортой бодист өртөх магадлалтай ажилчны хувийн хамгаалах хэрэгсэл

유해물질 노출 근로자를 위한 개인 보호구

# Маск хадгалах

호흡용 보호구 – 보관

조심조심 코리아

작업전 안전점검 당신의 생명을 지킵니다

2016 - 교육미디어 - 867

Mongolia

## » Маск 호흡용 보호구

Маскыг дахин битүүмжлэх боломжтой цүнхэнд маш цэвэрхэн хадгална.

호흡용 보호구를 재 밀봉 가능한 비닐백에 보관하여 깨끗하게 관리한다.



## Хадгалах заавар 보관 방법

- Маскийг битүүмжлэх боломжтой гялгар уутанд хадгалснаар гадны тоосноос хамгаалж цэвэр байлгана.
  재밀봉 가능한 비닐백에 호흡용 보호구를 보관한다. 이는 호흡용 보호구를 분진으로부터 보호하고 깨끗하게 관리할 수 있다.
  - Битүүмжлэх боломжтой гялгар уутаа цэвэр байлгана.
    재밀봉 가능한 비닐백은 깨끗하게 관리해야 한다.
  - Гялгар уутныхаа бүрэн бүтэн байдлыг шалгана.
    비닐백은 재밀봉이 가능한지, 손상되지 않았는지 확인한다.
  - Шаардлагатай тохиолдолд гялгар уутаа шинээр солино.
    필요한 경우에는 비닐백을 교체한다.
- Маск болон оосорыг сунаж үрчийхгүй байхаар хадгална.
  안면부와 고정끈이 구부러지거나 늘어나지 않도록 보관한다.
- Маскыг кабинет юмуу хайрцганд хийж аюулгүй газар хадгална.
  캐비넷이나 사물함 등과 같은 안전한 장소에 보관한다.
- Маскыг гэмтээж болзошгүй тул бусад ажлын хэрэгслүүдтэй хамт хадгалж болохгүй.
  다른 작업 공구들과 함께 보관하지 않는다. 작업 공구들이 호흡용 보호구를 손상시킬 수 있다.
- Маскыг машин техник болон темпратурын өөрчлөлт ихтэй газар(хэт халуун, хэт хүйтэн) хадгалах шаардлагатай болвол, уутны амсрыг бага зэрэг нээж чийг татахаас хамгаална.
  자동차 또는 온도 변화가 심한 곳(너무 덥거나 너무 추운 곳)에 두는 경우에는, 재밀봉 가능한 백을 약간 열어 두어 습기가 차는 것을 방지한다.

OPEN 공공누리

# Нэг удаагийн маскны бүрэн бүтэн байдлыг хангах
일회용 호흡용 보호구 – 관리



## Амьсгал хамгаалах нэг удаагийн хэрэгсэл 일회용 호흡용 보호구

Нэг удаагийн маск нь аяган, эвхдэг, амьсгал гаргах хавхлагатай болон хавхлагагүй гэсэн олон хэлбэртэй байдаг.
일회용 호흡용 보호구에는 일반적으로 컵식, 접이식, 배기밸브 부착형 및 미부착형 등 다양한 형태가 있다.



Аяган маск
컵식



Амьсгал гаргах хавхлагатай маск
배기밸브 부착형



Эвхдэг маск
접이식

## Бүрэн бүтэн байдлыг хангах 관리 방법

- Маскыг нүүрэнд сайтар наалдуулан татдаг хоёр ширхэг оосор бий. Хоёр талд нь оосор заавал байх шаардлагтай.
  얼굴에 제대로 밀착하기 위해서 호흡용 보호구에는 두 개의 고정끈이 있다. 양쪽 고정끈 모두가 있어야 한다.
- Бэхлэгч оосрыг хамгаалах дуулга, малгай, чихэвчны дотуур уяж бэхэлнэ. Хэрвээ оосрыг буруу хийвэл маскны нүүрэн хэсэг тахийх юм уу, оосор сунах бөгөөд нүүрэнд сайн наалдахгүй.
  고정끈은 안전모, 모자, 또는 귀덮개 안쪽으로 착용한다. 만일 고정끈을 잘못 착용하면 안면부가 휘어지거나, 고정끈이 늘어나거나, 또는 밀착이 안 될 수 있다.
- Аяган хэлбэртэй маскыг хэлбэрийг нь алдагдуулахгүй хадгална. Хэрэв нугалах юм бол шүүлтүүрэнд нугалаас гарч нүүрэнд сайн наалдахгүй болдог.(Эвхдэг масканд хамаарахгүй)
  컵식 호흡용 보호구는 원래 형태 그대로 보관한다. 만일 접어서 보관하면 필터에 주름이 생기고 얼굴에 제대로 밀착되지 않을 수 있다.(접이식 호흡용 보호구는 해당되지 않는다.)

## Шалгах арга 점검 방법

- Хэрвээ масканд дор дурдсан асуудлын аль нэг нь үүссэн бол маскыг устгаж шинэ маск зүүн бохирдсон агаараас өөрийгөө хамгаална. Маскыг хаяхдаа бэхлэгч оосрыг ашиглана.
  호흡용 보호구에서 아래의 문제점들 중 한 가지라도 발견될 경우에는, 폐기하고 새 것으로 교체해서 공기 중 오염물질으로부터 호흡기를 보호할 수 있도록 한다. 고정끈을 사용해서 호흡용 보호구를 폐기한다.

| | | | |
|---|---|---|---|
| Маскны нүүрэн тал 안면부 | ☐ Бөглөрөөд амьсгалахад хэцүү байна уу? 막혀서 호흡이 어려운가<br>☐ Норох буюу бохирдсон байна уу? 젖거나 오염되었는가<br>☐ Нүүрэн хэсэг болон шүүлтүүр нь цоорсон байна уу? 안면부 또는 필터에 구멍이 나있는가<br>☐ Нугаларах юм уу хэлбэр нь өөрчлөгдсөн байна уу? 구겨지거나 변형되었는가 | Оосор 고정끈 | ☐ Урагдсан, сунасан, орооцолдсон, зангилагдсан байна уу? 찢어지거나, 늘어나거나, 꼬이거나, 매듭이 있는가<br>☐ Оосор нь унасан байна уу? 고정끈이 빠져있는가 |
| | | Амьсгал гаргах хавхлагатай маск 밸브 부착형 호흡용 보호구 | ☐ Амьсгал гаргах хавхлага нь унах юм уу тахийсан байна уу? 배기밸브가 빠지거나 휘어져 있는가 |

Хортой бодист өртөх магадлалтай ажилчны хувийн хамгаалах хэрэгсэл
유해물질 노출 근로자를 위한 개인 보호구

# Нэг удаагийн маск хэрэглэх
일회용 호흡용 보호구 – 사용

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 865

Mongolia

## Зүүх арга 착용 방법




**01** Маскны хамран хэсэг нь хурууны үзүүр хавьд байхаар гартаа барина.
코받침 부분이 손가락 끝에 오도록 손으로 호흡용 보호구를 잡는다.

**02** Оосрыг нь гарынхаа ар луу унжуулна.
고정끈을 손 아래 쪽으로 자연스럽게 늘어 뜨린다.

**03** Маскны доод хэсгийг эрүүндээ барьж, хамран хэсгийг дээш нь өргөнө.
호흡용 보호구의 하단부를 턱 아래에 대고 코받침 부분을 위로 향한다.

**04** Дээд талын оосрыг толгой дээгүүрээ давуулан тогтоож, нөгөө оосрыг нь чихний доогуур хоолойн хэсгээр татна.
상단 고정끈을 머리 뒷쪽에 걸치고 다른 한 끈은 귀 아래쪽 목 주위에 걸친다.

**05** Хамран хэсгийг хамарныхаа хэлбэрт тааруулан хурууны үзүүрээр дарж наалдуулна.
양 손가락 끝을 사용해서, 코 부위가 자신의 코 모양에 맞도록 코 받침면을 아래로 눌러 가볍게 밀착시킨다.

## Нүүрэнд сайн наалдсан эсэхийг шалгах арга 밀착도 점검 방법

1. Маскыг хоёр гараараа бүрхэж дарах юм уу бүрхэж шалгадаг тусгай зориулалтын хуванцар аяга(үйлдвэрлэгчээс өгдөг) ашиглана.
양손으로 안면부 전체를 감싸거나 안면부를 감쌀 수 있는 점검용 플라스틱 컵(제조사에서 제공함)을 사용한다.

2. Амьсгал гаргагч хавхлагатай маск бол хавхлагыг гарын алгаар дарна.
배기밸브가 있는 호흡용 보호구인 경우에는, 손바닥으로 배기밸브를 감싸서 막는다.

3. Маск зүүгээд хөдөлгөөнгүй байхдаа амьсгалаа авч гаргана. Хэрэв маск нүүрэнд сайн наалдсан бол амьсгал авах үед маск нүүрэнд шигдэж, амьсгалаа гаргахад агаар гарахгүй байх ёстой.
호흡용 보호구를 착용한 상태에서는 움직이지 않도록 주의하면서 숨을 들이 마시고 내쉰다.
만일 밀착 상태가 양호하다면, 숨을 들이마실 때 안면부가 얼굴 방향으로 약간 들어가게 되고 숨을 내쉴 때는 공기가 빠져나가지 않아야 한다.

4. Хамрын хэсгээр агаар гарч байвал хамартаа улам сайн наалдуулна. Хэрэв маскны амьсгалах хэсгээр агаар алдагдаж байвал оосрыг чангална.
코 부위 주변으로 공기가 새어 나간다면, 코에 좀 더 밀착시키고, 호흡용 보호구 모서리 주변으로 공기가 새어 나가면, 고정끈을 조절한다.

5. Маск нүүрэнд сайн наалдахгүй байгаа тохиолдолд агаар нь бохирдсон бүсэд ороглгүй хариуцсан байцаагчид мэдэгдэнэ.
밀착 상태가 양호하지 않다면, 오염 지역에 출입하지 말고 관리 감독자에게 알린다.

OPEN 공공누리

Хортой бодист өртөх магадлалтай ажилчны хувийн хамгаалах хэрэгсэл
유해물질 노출 근로자를 위한 개인 보호구

# Нэг удаагийн маск хэрэглэх

일회용 호흡용 보호구 – 탈착

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 864

Mongolia

## Зүүх арга 착용 방법




01 Маскны даруулга төмөртэй хэсэг хурууны үзүүр хавьд байхаар гартаа барина.
코받침 부분이 손가락 끝에 오도록 손으로 호흡용 보호구를 감싸 쥔다.




02 Нэг гараараа маскыг барьж хамар, ам, эрүүгээ бүрхэнэ.
한 손으로 호흡용 보호구를 잡고 코, 입, 턱을 덮는다.




03 Нөгөө гараараа дээд талын оосрыг толгой дээгүүрээ давуулан чихний дээгүүр татна.
다른 손을 사용해서 상단 고정끈을 머리 뒤로 넘겨 귀 윗부분에 걸친다.




04 Доод оосрыг толгойн ард, чихний доогуур татна. Түгжээтэй оосор бол хүзүүнийхээ ард аваачин түгжинэ.
하단 고정끈을 머리 뒤의 귀 아래부분에 걸친다.
고정끈이 클립 형태인 경우에는, 목 뒤에서 클립을 체결한다.




05 Даруулга төмрийг хамрынхаа хэлбэрт тааруулан хурууныхаа үзүүрээр дарна.
양손 손가락 끝을 사용해서, 코 부위가 자신의 코 모양에 맞도록 코 받침면을 부드럽게 아래로 누른다.




06 Маскыг хоёр гараараа таглан нүүрэнд сайн наалдсан эсэхийг шалгана. Амьсгал авах үед маск дотогш хонхойж, амьсгал гаргахад агаар гадагш гарахгүй байх ёстой.
양손으로 호흡용 보호구를 덮어서 밀착도 점검을 실시한다. 호흡용 보호구를 통해서 공기를 들이마실 때 호흡용 보호구가 약간 들어가게 된다.
숨을 내쉴 때는 공기가 빠져나가지 않아야 한다.

## Тайлах 벗는 방법



01 Хоёр гараараа доод талын оосрыг толгойн дээгүүрээ давуулан татна. Түгжээтэй оосор бол түгжээг нь тайлна.
양손을 사용해서, 하단 고정끈을 잡고 머리 위로 당긴다.
고정끈이 클립 형태인 경우에는, 클립을 해제한다.



02 Дээд талын оосрыг толгой дээгүүрээ давуулан татна.
상단 고정끈을 머리 위로 당긴다.



03 Дараах тохиолдолд маскыг хаяна.
다음과 같은 경우에는 호흡용 보호구를 폐기한다.

- Гэмтсэн юм уу бохирдсон үед
손상되거나 오염된 경우
- Амьсгалахад хэцүү болсон үед
호흡이 어려워진 경우
- Нян, вирус зэрэг биологийн аюултай биетээс хамгаалахын тулд хэрэглэсэн бол
세균 또는 바이러스와 같은 생물학적 유해인자로부터 보호하기 위해 사용한 경우

Хаяхдаа бэхлэх оосрыг ашиглан заасан дэс дараалын дагуу хаяна.
폐기하는 경우에는, 고정끈을 사용해서 작업 안전 절차에 따라 처리한다.



04 Дараах тохиолдолд хадгалсан маскыг дахин ашиглах боломжтой.
다음과 같은 경우에는 호흡용 보호구를 보관 후 재사용을 고려한다.

- Гэмтээгүй буюу бөглөрөөгүй маск.
손상되지 않거나 막히지 않은 경우
- Чөлөөтэй амьсгалж болж байвал
호흡용 보호구를 통한 호흡이 양호한 경우
- Нян, вирус зэрэг биологийн аюултай биетээс хамгаалахын тулд хэрэглээгүй бол.
세균 또는 바이러스와 같은 생물학적 유해요인으로부터 보호하기 위해 사용하지 않은 경우

Маскыг дахин битүүмжлэх боломжтой цүнхэнд хийж, дарах юм уу нугалахгүйгээр хадгална.
호흡용 보호구는 재밀봉 가능한 백에 넣어서 눌리거나 접히지 않도록 보관한다.

Хортой бодист өртөх магадлалтай ажилчны хувийн хамгаалах хэрэгсэл
유해물질 노출 근로자를 위한 개인 보호구

# Шүүлтүүртэй хагас маск Маскаа хэрхэн зүүх вэ
반면형 호흡용 보호구(안면부 여과식) – 착용

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 863

Mongolia

## Зүүх арга 착용 방법




01 Маскаар эрүү болон хамраа бүрхэнэ. Толгойн оосрыг зулай болон чихний дээд хэсгээр давуулж тохируулна.
마스크로 코와 턱을 덮는다. 머리 고정끈을 머리 정수리와 귀 윗부분에 걸치고 조절한다.

02 Хоолойн оосрыг чихний доод, хоолойн хэсгээр тойруулна.
목 고정끈을 귀 아래 목 주위로 두른다.

03 Хоолойн оосорны түгжээг оруулна.
목 고정끈의 잠금 고리를 고정한다.

04 Хоолойн оосрыг тохируулна.
목 고정끈을 조절한다.

## Амьсгалын маскыг нүүрэнд наалдуулан тохируулах арга
호흡용 보호구의 밀착도 조절 방법

- Амьсгалын замыг хордуулах эрсдэл бүхий газар луу орохдоо хортой агаар амьсгалын маскны завсар зайгаар орохоос хамгаалж бэхлэх оосрыг чангалж тохируулдаг.
  호흡용 보호구 안으로 오염된 공기가 유입되는 것을 방지하기 위해서, 호흡 유해인자가 있는 지역에 들어가기 전에 고정끈을 조절한다.
  - Амьсгалын маск нь нүүрэнд маш сайн наалдсан байх ёстой. Гэхдээ хэт хүчтэй дарах юм уу арьсыг улайлган ором гаргаж болохгүй.
    호흡용 보호구는 안면부에 편안하게 밀착되어야 한다. 안면부에 너무 강하게 밀착되거나 피부에 붉은 자국이 남으면 안된다.
- Амьсгалын маскыг тохируулах шаардлага гарсан үед бохирдсон агаартай газар тохируулж болохгүй. Бохирдсон агаар маск руу орох аюултай тул тухайн газраас хол очиж тохируулах хэрэгтэй.
  호흡용 보호구를 조절할 필요가 있을 때는, 오염된 공기가 마스크 안쪽으로 침투될 수 있기 때문에 오염된 지역을 벗어 나서 조절해야 한다.
  - Оосрыг тохируулах болгондоо нүүрэнд наадлаж байгаа эсэхийг шалгана.
    고정끈을 조절할 때마다 밀착도 점검을 한다.

OPEN 공공누리

산업재해예방 안전보건공단

Ажилчны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
일하는 사람의 안전보건

# Газар тариалан болон ойн аж ахуйн ATV (4 дугуйт мотоцикл) жолооч

농업 및 임업 ATV(4륜 구동 오토바이) 운전자

조심조심 코리아
작업전 안전점검
당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 862

Mongolia

## Спортын ATV

스포츠 형태의 ATV



- Шороон замаар явдаг, бага хийтэй 4 дугуйтай, мотороор хөдөлдөг. 비포장 도로면에서 낮은 타이어 공기압을 사용하는 4개의 타이어가 장착됨, 모터로 구동
- Жолооч нь мордон суух зориулалт бүхий суудалтай. 운전자가 다리를 벌리고 올라 앉도록 좌석이 제작
- Мотоциклийн жолоо шиг хэлбэртэй жолоог ашиглан чиглэлээ өөрчилдөг. 오토바이 핸들바처럼 생긴 핸들을 사용해서 방향 전환
- Зорчигч суулгахгүй, жолооч ганцаараа суух зориулалттай хийгдсэн, хөдөө тосгонд “сабал” гэж нэрлэдэг. 승객을 태우지 않고 운전자 혼자서만 탑승하도록 제작되며 농촌에서는 ‘사발’이라고도 불림

## Олон зориулалттай ATV

다목적 형태의 ATV



- Энгийн автомашинтай адил жолооч болон зорчигч урд суудал дээр нь зэрэгцэн сууж болно. Ихэнх олон зориулалттай ATV нь 2 хүний суудалтай байдаг. 일반 승용차처럼 운전자와 승객이 옆으로 나란히 좌석에 앉을 수 있는 소형 다목적 형태(대부분의 다목적 형태의 ATV 차량은 이런 방식으로 2명이 탑승할 수 있음)
- Ихэнх олон зориултай ATV нь 4 дугуйтай бөгөөд 6 дугуйтай мотоцикл ч бас бий. 대부분의 다목적 형태의 ATV 차량은 4개의 바퀴를 가지고 있으며, 일부는 6개의 바퀴를 장착한 차량도 있음
- 2 дугуй хөтлөгчтэй горим болон 4 дугуй хөтлөгчтэй горим хооронд шилжих боломжтой. 상시 2륜 구동과 4륜 구동 전환이 가능

## ATV осол гарах хүчин зүйл, шалтгаан ATV 사고의 잠재적인 위험 요소 및 원인

1. Албан ёсны жолооны үнэмлэхгүй юм уу жолоодох туршлага дутмагаас
정식적으로 운전 면허가 없거나 운전 경험이 부족한 경우

※ 50cc-ээс дээш хөдөлгүүрийн багтаамжтай ATV-ыг мотоциклд хамруулдаг. 125cc-тэй ATV жолоодохын тулд мотоциклын жолооны үнэмлэх юм уу 2-р зэрэглэлийн жижиг оврын автомашины жолооны үнэмлэхтэй байх ёстой. Эдгээр үнэмлэхгүй хүн жолоодвол дүрэм зөрчсөн гэж үзнэ. (ATV явах зориулалттай уралдааны замаар явахыг тооцохгүй.)
ATV 중 50cc 이상인 경우에는 이륜자동차에 해당된다. 125cc를 기준으로 원동기장치면허 또는 제2종 소형면허가 있어야 운행가능하며 해당 운전면허가 없을 경우 무면허 운전이다. (단, ATV전용 경주로를 다니는 경우 제외)

2. Хувийн хамгаалах хэрэгсэл өмсөж зүүгээгүй юм уу буруу хэрэглэх 개인 보호구를 착용하지 않았거나 잘못 착용한 경우
3. Хурд хэтрүүлсэн бол. 과속을 하는 경우
4. Спортын ATV-д зорчигч суулгах 스포츠 형태의 ATV에 승객을 태우는 경우
5. Нэг талд нь хэт их ачаа ачсан буюу даац хэтрүүлэх 화물을 한쪽으로 치우쳐 싣거나 과적한 경우
6. Далан, усны хоолой, дугуйн ором зэрэгт тээглэж онхолдох 둑, 배수로, 바퀴자국 등에 걸려 넘어지는 경우
7. Зам болон ачсан ачаанаас болоод өгсүүр газар арааны хүч алдагдах
노면 또는 적재 화물의 상태 등과 같은 요인들과 결합되어 가파른 경사로에서 제어력을 상실한 경우
8. Тоормосны төхөөрөмжгүй хүнд тоног төхөөрөмжийг хэт хүч гарган чирэх
제동 장치가 없는 무거운 장비를 무리하게 견인하는 경우
9. Засвар үйлчилгээ сайн хийхгээгүйгээс тоормосны төхөөрөмж эвдрэх, дугуйн хий хэвийн бус байх
제동 장치 고장, 타이어 공기압 이상 등과 같이 유지 관리를 제대로 하지 않은 경우

# Спортын ATV ашиглах 스포츠 형태의 ATV 관리

## Хувийн хамгаалах хэрэгсэл
개인 보호구



- ATV нь дээвэр болон бүхээгний хаалт төмөр(онхолдох үед зорчигчийг хамгаалах хаалт төмөр) байхгүй тул зөвхөн өмссөн хувцас л хамгаалалт болно. Амь насыг хамгаалдаг гол хамгаалалт нь толгойн хамгаалалт юм. Хамгаалалтын дуулга өмссөн тохиолдолд бүх ослоос биш ч гэсэн томоохон хэмжээний ослуудаас хамгаалах боломжтой.
천장이나 롤 바(전복 시 운전자 및 탑승자 보호를 위해 장치한 자동차의 보강용 막대)가 없기 때문에, 전적으로 입고 있는 복장으로 신체를 보호해야 함. 그러므로 머리 보호는 생명과 직결된다. 헬멧을 착용하면, 모든 경우는 아니지만, 많은 대형 사고를 예방할 수 있음
- Гар болон хөл халхлах бат бөх хувцас өмсөнө. Бээлий нь гарыг хамгаалах бөгөөд жолооны угладаг бээлий нь хүйтэн өвлийн улиралд гарыг дулаахан байлгадаг. Устай нойтон газар өмсөхөд тохиромжтой, тулхтай, шагайнаас дээгүүр татсан урт түрийтэй гутал юм уу велингтон гутал шиг гутал өмсөнө.
팔과 다리를 덮을 수 있는 튼튼한 복장을 착용. 장갑은 손을 보호하며 핸들 방한 토시는 추운 겨울에 손을 따뜻하게 유지할 수 있어서 ATV 운전이 용이. 질기고 지지력이 좋으며 젖은 곳에서도 착용감이 좋은 장화나 웰링턴 부츠처럼 발목까지 덮는 튼튼한 재질의 안전화를 착용
- Хамгаалалтын шил зүүж модны мөчир, үсэрсэн чулуу зэргээс нүдээ хамгаална. 고글 등을 착용해서 나뭇가지, 날아오는 돌조각 등으로 부터 눈을 보호

## Аюулгүй жолоодох арга
안전 운전 방법

- Аюулгүй жолоодоход жолоочийн байрлал чухал үүрэгтэй. ATV жолоочийн байрлал газрын төлөв байдал, жолоодох хөдөлгөөнөөс хамаарч өөрчлөгдөж болно.
운전자의 위치는 올바르게 운전하기 위해서 매우 중요함. ATV에서 운전자의 위치는 지형과 운전 동작에 따라서 바뀔 수 있음
  - Ихэнх ATV нь дефференциал төхөөрөмж(хөдөлгүүрийн хүчийг машины эргэлтээс хамаарч баруун зүүн тийш хуваарилдаг төхөөрөмж)-гүй байдаг тул энгийн машин унаж байгаа мэт жолоодож болохгүй. ATV эргэхдээ ч гэсэн буцаад чигээрээ явах гээд байдаг.
대부분의 ATV는 차동 장치(differential : 추진축의 동력을 차량의 선회상태에 따라 좌우로 배분하는 장치)가 없으며 일반 차량처럼 다루면 안됨. 이것은, 회전을 할 때, ATV는 직진으로 곧장 전진하려는 성질을 가지고 있음을 의미함
  - Тэгш сууж, булангийн гадна тал руу биеийн жин дарах үед дотор талын гишгүүрт биеийн жингээ шилжүүлэн мотоциклийн жинтэй тэнцүүлнэ. Ингэхэд дотор талын дугуй бага зэрэг гулсан, буланг аюулгүй тойрч гарч чадна. 자세를 바르게 해서 코너의 바깥쪽으로 체중이 쏠릴 때는 안쪽 발판으로 체중을 이동 시켜서 차체와 균형을 유지. 이렇게 하면 안쪽 휠이 약간 미끄러지면서 ATV가 코너를 안전하게 주행할 수 있음
  - Налуу газраар хөндлөн явж гарахдаа биеийн жингээ ATV-гийн налуу талын дээд хэсэгт төвлөрүүлнэ.
경사지를 가로질러서 주행할 때, 체중을 ATV의 경사로 위쪽으로 쏠리도록 함
  - Уруу газар луу буухдаа биеийн жингээ хойд хэсэгт төвлөрүүлж, хүнд араа болон моторын тоормос ашиглавал тоормосны төхөөрөмжийн ачааллыг багасгана.
내리막길을 주행할 때, 체중을 뒤쪽으로 싣고, 저속 기어와 엔진 브레이크를 사용하면 제동 장치를 사용할 필요가 줄어듦
  - Өгсүүр газар явахдаа хөдлөхийн өмнө замаа дахин нэг удаа шалгах хэрэгтэй. Биеийн жингээ урагш нь төвлөрүүлж, тогтмол хурдтай явна. Аль болох урд хэсэгт биеийн жингээ төвлөрүүлэх нь чухал. Шаардлагатай бол хурдаа нэмэхийн тулд хоёр талын дөрөөн дээрээ гишгэж зогсоод урагш бөхийнө.
오르막길을 주행할 때, 출발하기 전에 경로를 다시 한번 확인하는 것이 중요함. 체중을 앞쪽으로 싣고 속도를 일정하게 유지. 체중이 가능한 앞쪽으로 쏠리도록 하는 것이 중요함. 필요하다면, 가속력 유지를 위해 발판에 양쪽 발을 모두 붙인 채 일어서서 몸을 앞으로 기울임
  - Хурдаа гэнэт нэмж болохгүй. Хойшоо онхолдож унах нь ихэнхдээ гэнэт хурдаа нэмснээс болдог. Хэдий тэгш газраас аюулгүй хөдөлдөг ч гэсэн зогсоо байдлаас хөдлөх юм бол онхолдох аюултай.
속도를 갑자기 높이지 않음. 뒤로 전복되는 사고의 공통된 원인이 급가속이며, 평지에서 안전하게 출발하더라도 일어선 자세로 출발하면 전복 사고가 발생할 수 있음
  - Явж байхдаа ATV-г тэнцвэртэй болгохын тулд хөлөө газар хүргэж болохгүй. Харин оронд нь биеийн жингээ шилжүүлэх замаар тэнвэржүүлээрэй.
주행 중에 ATV 자세를 바로 잡기 위해서 절대로 발을 땅에 대지 말고 체중을 옮겨서 ATV의 균형을 잡도록 함

## Аюулгүй байдлыг шалгах, сахих
안전 점검 및 유지 관리

### Дугуйн хий
타이어 공기압

- ATV-н дугуй ерөнхийдөө 2~7psi-ээр бага байдаг тул хий нь 1psi (0.07kg/cm2)-гээр ялгаатай байх тохиолдолд жолоодож явахад асуудал үүснэ.
  ATV타이어 공기압은 보통 2~7psi로 낮기 때문에, 공기압이 1psi (0.07kg/cm2)라도 차이가 있으면 운행에 문제가 발생할 수 있음

### Тоормосны төхөөрөмж ба хурдны төхөөрөмж
제동 장치와 가속 장치

- Тоормосны төхөөрөмж аюулгүй, тогтвортой ажиллаж байгаа эсэх, жолоог эргүүлж байхад хурдны төхөөрөмж зөөлөн ажиллаж байгаа эсэхийг шалга.
  제동 장치가 안전하고 균형있게 작동 하는지와 핸들 조작 중에도 가속 장치가 부드럽게 작동하는지 확인
- Газар тариалан болон ойн аж ахуйн ажилд ашигладаг ATV-гийн тоормосны төхөөрөмж харьцангүй хурдан элэгддэг бөгөөд байнга цэвэрлэж, тохируулгыг нь тогтмол хийж байх хэрэгтэй.
  농업 또는 임업 환경에서는 제동 장치 수명이 상대적으로 짧아질 수 있으며 자주 청소하고, 정기적으로 조정해서 적절하게 유지 관리 실시

## Ачаа ачих болон чиргүүл чирэх
견인 화물 및 적재물

### Жолооч үйлдвэрлэгчээс заасан ачаа чирэх даац, холбогчийн даацын хязгаарыг мэдэж байх ёстой. Үргэлж тухайн заасан хэмжээнд ашиглах ёстой. Ачаа ачих юм уу чиргүүл чирэх үед ATV жолоодоход их хүнд болдог.
운전자는 제조사가 권장하는 견인 하중과 연결봉의 제한 하중을 알고 있어야 함. 항상 이 한도 내에서 사용해야 하며, 짐을 싣거나 트레일러를 견인할 때는 ATV를 제어하기가 훨씬 힘들어 짐

- ATV даац болон чиргүүлийн даацын харьцааг шалга. Чиргүүл холбох юм уу ачаа ачих бүртээ шалга.
  ATV 하중과 견인하는 화물의 하중 비율을 확인하며, 트레일러를 연결할 때 또는 화물을 적재할 때마다 확인
  - Ер нь бол ATV нь тэгш газар, ачаагүй үеийн жингээсээ дээд тал нь 4 дахин хүнд тоормосны төхөөрөмжэй чиргүүл чирч чадна
    일반적으로, (평지 기준) 제동 장치가 있는 트레일러의 경우에는 ATV 공차 중량의 최대 4배까지의 화물을 견인할 수 있음
  - ATV нь ачаагүй үеийн жингээсээ дээд тал нь 2 дахин хүнд тоормосны төхөөрөмжгүй чиргүүлийг чирч чадна. Налуу зам, шороон зам, донсолгоотой замаар эдгээр хэмжээнээс бага хэмжээтэй ачааг чирнэ.( ATV загвараас хамаарч үйлдвэрлэгчийн зааврыг дагана.)
    제동 장치가 없는 트레일러의 경우에는 공차 중량의 최대 2배까지의 화물을 견인할 수 있음. 경사로, 비포장 도로, 또는 노면 상태가 고르지 않을 때는 이 하중 기준보다 적은 중량의 화물을 견인(ATV 모델에 따라서 제조사의 권고 사항을 따름)
- Даацын хуваарилалт бас чухал
  하중 분배도 중요
  - Ачааны зарим хэсгийг ATV-гийн холбогч тал руу ачвал илүү тогтворжиж, холбогч “V” хэлбэртэй болж нугаларахаас хамгаална.
    화물의 일부를 ATV의 연결봉쪽으로 옮기면 안정성이 높아지고 연결봉 부위가 V자로 접히는 현상을 방지할 수 있음
  - Чирч буй ачааны 10%-ийг холбогч тал руу зөөж ачихыг зааварладаг боловч үйлдвэрлэгчийн заасан холбогчийн хамгийн дээд даацыг хэтрүүлж болохгүй. Өгсүүр болон уруу замд хөдөлж явах үед даацын хуваариалалт өөрчлөгдөнө гэдгийг анхаар.
    연결된 화물 총 중량의 약10%를 연결봉쪽으로 분배시키는 것을 권장하지만, 제조사가 권장하는 연결봉 최대 하중을 초과해서는 안됨. 오르막 또는 내리막 경사로에서 출발할 때 하중 분배가 현격하게 변할 수 있다는 점을 명심



화물의 하중 비율을 확인

- Тэвшинд ачаа ачиж тээвэрлэхдээ
  짐받이에 화물을 실어 운반할 때
  - Ачааны татлага ашиглан сайтар дарж бооно. Урд хойд талыг тэнцвэржүүлнэ. Тээвэрлэх боломжтой ачааны дээд хэмжээг жолоочийн гарын авлага болон ATV дээр тэмдэглэсэн байдаг ба тухайн хэмжээнээс хэзээ ч хэтрүүлж болохгүй.
    조임줄(래치 밴드) 등을 사용해서 튼튼히 고정시키고, 앞뒤 균형을 유지. 운반할 수 있는 최대 하중은 사용자 설명서와 ATV에 표시되어 있으며 절대 초과하면 안됨

## Олон зориулалттай ATV ашиглах 다목적 형태의 ATV 관리

- Олон зориулалттай ATV нь тракторын зориулалтаар ихэнхдээ ашиглагддаг. Бартаатай, замгүй газар явахад зориулан үйлдвэрлэсэн. Тус ATV нь ердийн автомашинтай адил суудалтай, жолоо болон дөрөөгөөр удирддаг.
  다목적 형태의 ATV는 트랙터와 같은 목적으로 자주사용되며 험난한 지형의 오프로드 주행과 같은 비슷한 작업 활동을 목적으로 제작. 이 ATV에는 일반 승용차와 비슷한 좌석이 있으며, 핸들과 페달로 조작함
- Жолооч нь машины чиглэлийг өөрчлөх юм уу тэнцвэржүүлэх зорилгоор биеийн жинг шилжүүлэх шаардлагагүй. Гэхдээ машинд суухдаа биеийн жинг тодорхой хэмжээнд хуваарилан суух хэрэгтэй. Ялангуяа ачаа ачиж явах буюу шороон замаар явахад энэ их чухал.
  운전자는 차량의 방향을 전환하거나 안정성을 제어하기 위해서 체중을 이동시킬 필요가 없음. 하지만, 탑승 시 체중의 적절한 분배가 중요하며, 특히 화물을 적재하거나 비포장 노면을 주행할 때는 더욱 중요함
- Ачааны тээшинд ачих ачааны хэмжээг заасан хэмжээнээс хэтрүүлж болохгүй. Мөн бат бөх дарж баглах хэрэгтэй. 짐칸에 적재되는 화물의 중량은 최대 하중을 초과해서는 안되며 단단하게 고정시켜야 함



### Онхолдохоос хамгаалах тоноглол, суудлын бүс
전복 방지 구조물 및 안전띠

- Олон зориулалттай ATV-д тавигдах шаардлага нь спортын ATV-гээс нэлээн өөр.
  다목적 형태 ATV의 요구 사항은 스포츠 형태의 ATV와 매우 다름
  - Онхолдох болон бусад осол гарах үед гэмтлийг аль болох бууруулахын тулд тус ATV машины суудлын эргэн тойронд хамгаалалтын бүтцээр тоноглосон байхаас гадна суудлын бүстэй байх ёстой.
    전복 또는 기타 사고 발생 시 부상 위험을 줄이기 위해서, 다목적 형태의 ATV 차량에는 좌석 주변을 둘러싸는 형태의 보호 구조물 뿐만 아니라 안전띠가 있어야 함. 이 구조물은 대개 개방된 형태로 되어 있으나, 일부 차량의경우에는 바람막이 창 또는 옆 문이 장착된 것도 있음
  - Жолооч болон зорчигч онхолдохоос хамгаалах тоноглолын тусламжтай хамгаалагдах ёстой. Мөн суудлын бүсээ хийх ёстой. 운전자와 탑승자가 전복 방지 구조물에 의해 보호될 수 있어야 하고 안전띠를 매야 함

### Зогсоох
주차

- Налуу газар зогсоох шаардлагатай үед хэрэв хэт их налуу биш бол налуутай хөндлөн чиглэлд зогсооно. Тоормосны төхөөрөмжийг найдвартай ажиллуулаагүй юм уу ачаа ачсан бол жингээсээ болоод машин налуу газар луу өнхөрч магадгүй. Ачаа ачсан үед ATV-гийн тогтвортой байдал алдагддаг.
  경사지에 주차해야 하는 경우에는, 경사가 심하지 않다면 경사 방향과 수직으로 주차. 제동 장치를 확실히 작동 시키지 않았거나 짐이 실려 있는 경우에는 하중으로 인해서 차량이 경사지를 굴러 내려가는 사고가 발생할 수 있음. 짐을 실으면 ATV의 안정성이 떨어짐

# Газар тариалангийн ажилчин Жимсний талбайн зөөврийн шат ашиглалт

농업 종사자 | 과수원용 삼각사다리 사용 |

조심조심 코리아
작업전 안전점검 당신의 생명을 지킵니다
2016 - 교육미디어 - 861
Mongolia

Зөөврийн шат нь эвхэж дэлгэх, зөөвөрлөхөд тохиромжтой, жимсний талбай болон мод бут заслын талбайд жимс түүх, мөчир хайчлах зэрэг ажилд хэрэглэгддэг.

과수원용 삼각 사다리는 휴대가 용이한 자주식 사다리이며 과수원과 조경 작업장에서 가지를 치거나 과실을 수확할 때 주로 사용

- Хөл хэсэг нь конус хэлбэртэй, бамбалзуур болон тэгш биш газар ашиглах боломжийг бүрдүүлсэн тулгууртай.
  받침부가 나팔모양으로 생겼으며 부드럽고 불균일한 지면에서 사용할 수 있는 삼각 지주대가 있음
- Ихэнх зөөврийн шатанд тулгуур шон болон цоож байдаггүй. (зарим шатанд бий.)
  버팀목 또는 잠금 장치가 대부분 없음(보유한 것도 있음)




## Шатнаас унахаас урьдчилан сэргийлэх 떨어짐 예방

- Шатан дээр гарч ажиллаж байх үед хамгийн их гардаг осол бол шатнаас унах. Шатны дунд болон доод хэсгээс илүү дээд талаас унах нь элбэг.
  사다리에서 작업할 때, 가장 많이 발생하는 사고는 떨어짐. 사다리의 중간 또는 하단보다는 상단에서 떨어짐사고가 많이 발생
- Ихэнхдээ шатан дээр хальтарснаас, шат сайн бэхлэгдээгүйгээс, шатнаас зөв барилгүй ажилласнаас болж унадаг. 대부분의 떨어짐 사고는 계단이 미끄럽거나, 사다리가 고정되지 않거나, 사다리를 바르게 잡지 않고 작업하는 경우에 발생

1. Зөөврийн шатыг эвхэгдэж, хальтирч, хөдөлж, унахгүйгээр газарт бат бөх суурилуулна. Хэт бамбалзуур, хонхор газар зөөврийн шат тавихгүй.
   사다리를 지면에 튼튼하게 세워서 접히거나, 미끄러지거나, 움직이거나, 쓰러지지 않도록 함. 지면이 너무 무르거나 움푹 파인 곳에 사다리를 세우지 않음
2. Налуу газар тавих шаардлагатай бол тулгуур шонг налуу газрын уруу хэсэгт чиглүүлж тавина.
   경사면에 사다리를 세울 경우에는 삼각 지주대가 경사면의 오르막으로 향하도록 함
3. Зөөврийн шатыг тогтмол шалгана. 사다리를 정기적으로 점검
4. Ажилчин шатны хоёр баганы дунд хэсэгт зогсож ажиллахыг зааварлах ба өгсөж буухдаа хоёр гараараа баганаас барина.
   작업자가 사다리 기둥(버팀대) 중앙부에서 작업하도록 하고 오르내릴 때 양손을 사용
5. Шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл(хамгаалалтын шил)-ийг сонгон ажилчинд олгоно.
   필요한 개인 보호구(보안경 등)를 선정해서 작업자에게 제공
6. Ажилчин нь хатуу ултай, хальтрахаас хамгаалсан хамгаалалтын гутал өмсөнө.
   작업자는 밑창이 딱딱하고 미끄럼 방지가 된 안전화를 착용
7. Жимсний сагсыг хэтэрхий их дүүргэхгүй.
   수확용 바구니를 너무 많이 채우지 않음
8. Зөөврийн шатны дээд хэсгээс доош 3 гишгүүр дээр зогсох буюу ажиллаж болохгүй.
   사다리 상단부에서 아래로 3개 발판(디딤대)까지는 서있거나 작업하지 않음
9. Зөөврийн шатнаас модны мөчир луу авирах, модны мөчир дээр гишгэж зогсох, тэнцвэрээ олохын тулд модны мөчрөөс зуугдэж болохгүй.
   사다리에서 나뭇가지로 이동하거나 나뭇가지를 밟고 서거나 몸의 균형을 잡기 위해서 나뭇가지를 붙잡지 않도록 함

산업재해예방 안전보건공단

## Сургалт 교육 훈련

- Ажил олгогч, бүх ажилчдыг(түр ажилчин бас хамаарна) аюултай хүчин зүйлийг таньж мэддэг болох сургалтанд хамруулж, аюултай нөхцөл байдал үүссэн үед аюулгүй ажиллагааны байцаагчид даруй мэдэгдэх боломжтой системийг боловсруулна.
사업주는 모든 작업자들이(비정규직 포함) 위험 요소를 인지할 수 있도록 교육하고 위험 상황을 관리 감독자에게 즉시 보고할 수 있는 절차를 수립
- Сургалтынхаа агуулгад зөөврийн шатыг ашиглах, хадгалах арга, шаттай холбоотой гэмтэл осол гарсан үед авах зохих арга хэмжээ зэргийг багтаана. 교육 내용에는 사다리 유지 관리 및 보관 방법과 사다리로 인한 부상 및 사고에 적절하게 대처하는 방법을 포함

### Сургалтын агуулга 교육내용

1. Ажил дууссаны дараа шатыг босгосон чигээр нь орхихгүй байх. 작업이 끝난 후에 사다리를 그대로 세워두지 않도록 함
2. Хүчтэй салхитай, ширүүн бороотой, аянга цахилгаан цахисан үед ажлыг зогсоох, ажлын хуваарийг өөрчлөх.
강풍, 폭우, 뇌우 시에는 작업을 제한하거나 작업 일정을 조정
3. Зөөврийн шатан дээр ажиллах үед эргэн тойронд нь “Ажил явагдаж байна” гэсэн тэмдэг тавих юм уу туслах ажилтан гаргаж, зөөврийн шатны доор юм уу эргэн тойронд өөр ажилчин ажиллахгүй, явахгүй байхаар зохицуулах.
사다리 작업 중에는 주변에 ‘작업 중’ 표시를 세우거나 보조 인력을 두어서 사다리 아래나 주변으로 근로자가 작업하거나 이동하지 않도록 함
4. Хатуу гадаргуутай газар зөөврийн шат ашиглахгүй байх. 바닥이 딱딱한 표면에서는 사다리를 사용하지 않도록 함
5. Шатан дээр ажиллаж байхдаа багаж хэрэгсэл зөөх юм уу ашиглах үедээ анхааралтай байх.
사다리에서 도구를 운반하거나 사용할 때는 안전에 유의
6. Ажилчин жимсний талбайн зөөврийн шатан дээр гарч ажиллахын өмнө зөөврийн шатан дээр аюулгүй ажиллах сургалтанд суусан байх.
작업자가 과수원용 삼각 사다리에 올라가기 전에 미리 사다리 안전 교육을 실시



## Зөөврийн шатыг шалгах, ашиглах, хадгалах 사다리 점검, 유지 관리 및 보관

- Зөөврийн шатыг ашиглахын өмнө шатны бүрэн бүтэн байдал, хэвийн ашиглаж болох эсэхийг шалгана.
사다리 사용 전, 사다리에 결함이 없고 정상적으로 사용이 가능한지 점검
- Дараах зүйлийг голлон шалгана.
다음 사항을 중점적으로 점검
  - Үйлдвэрлэгчийн гарын авлагын дагуу эд анги нь бүрэн бүтэн эсэхийг ажил эхлэхийн өмнө шалгана.
사다리 제조사의 지침에 따라서 부품들이 정상적인 상태인지 작업 전에 확인
  - Ажил эхлэхийн өмнө тав нь мултарч унасан эсэх, суларсан эсэх, гэмтсэн эсэх, гишгүүр нь хугарсан эсэх, шатны хоёр талын багана болон тулгуур шон гулзайсан эсэхийг шалгана.
작업 전에 이음매(rivets) 손실, 느슨함, 손상 여부, 계단이 부러졌는지, 사다리 기둥(버팀대) 또는 삼각 지주대(뒷 버팀대)가 휘어졌는지 점검
  - Хэрвээ шат онхолдож унасан бол дахин хэрэглэхийн өмнө дээрээс нь доош нь сайтар шалгана.
사다리가 넘어진 경우에는, 다시 사용하기 전에 사다리 상단부터 하단까지 점검
  - Доголдолтой, эвдэрсэн шатыг тэр даруй хэрэглэхээ больж “Хэрэглэж болохгүй” тэмдэг наасны дараа эвдрээгүй шатнаас тусад нь хадгална.
결함이 있거나 손상된 사다리는 사용을 즉시 중단하고 “사용 불가” 표시를 한 후, 정상적인 사다리와 구분해서 따로 보관
  - Ажилчин зөөврийн шатыг өөрөө засаж болохгүй.
작업자가 직접 사다리를 수리해서는 안됨
  - Зөөврийн шатыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хадгална. Хэт халуун юм уу хүйтэн газар хадгалж болохгүй. 제조사의 지침에 따라, 사다리를 보관하고 너무 뜨겁거나 차가운 장소를 피해서 보관

OPEN 공공누리

2016 - 교육미디어 - 860

# Ажил олгогч болон ажилчдын заавал мэдэж байх ёстой, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн 10 алтан дүрэм

사업주와 근로자가 꼭 알아야 할 **산업현장 안전보건수칙 10계명**

※ Ажилчин биедээ ямар нэгэн хэвийн бус шинж тэмдэг илэрвэл байцаагчид хэлж эмчид үзүүлэх бөгөөд Хөдөлмөрийн яаманд мэдээлнэ.
작업 근로자들은 신체에 이상 증상이 나타나면 관리자에게 보고, 의사 진료 및 고용노동부에 통보하여야 합니다.

## 1

**Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгаж,** ажлын байрыг үргэлж **эмх цэгцтэй** цэвэрхэн байлгах нь ажил олгогчийн үүрэг юм.

사업주는 **작업 전 안전점검**을 하도록 하고. 작업하는 장소를 항상 청결하게 **정리정돈** 해야 합니다.




## 2

Ажил олгогч нь ажлын байр луу ордог хаалга, ажлын байран дахь **зорчих замыг аюулгүй байлгах** ёстой.

사업주는 작업장으로 통하는 장소 또는 작업장 내에 **안전통로를 확보**해야 합니다.




## 3

Ажил олгогч нь ажилд тохирсон **хувийн хамгаалах хэрэгслээр** хангаж, ажилчин түүнийг заавал өмсөх ёстой.

사업주는 작업에 적합한 **개인 보호구를 지급**하고 근로자는 반드시 **착용**해야 합니다.




## 4

Ажил олгогч нь цахилгаан ашиглан ажил гүйцэтгэх тохиолдолд **газардуулга** хийж, ажилд тохирсон **цахилгаан тусгаарлагчтай хамгаалах хэрэгслийг** ажилчинд олгож хэрэглүүлнэ.

사업주는 전기작업 시 **접지**를 하고 각각의 사용목적에 적합한 **절연용 보호구**를 근로자에게 지급하여 착용하도록 해야 합니다.




## 5

Ажил олгогч нь **машин механизм, тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ** хийх үед **цоожлогч төхөөрөмжөөр** тоноглож, **анхааруулах тэмдэг** хадна.

사업주는 **기계·설비 정비시** 기동 장치에 **잠금장치**를 하고 **표지판**을 부착해야 합니다.




## 6

Ажил олгогч нь **хортой, аюултай бодистой** ажиллах үед бодисын саван дээр **анхааруулах тэмдэг** хадна.

사업주는 **유해·위험 화학물질**을 취급하는 경우 용기 등에 **경고 표지**를 부착해야 합니다.




## 7

Ажил олгогч нь шахагч машин, тайрагч, даралтат сав зэрэг **хортой, аюултай машин механизм, тоног төхөөрөмж ашиглах** үед тохирох хамгаалах төхөөрөмжийг суурилуулах хэрэгтэй.

사업주는 프레스, 전단기, 압력 용기 등 **유해 위험 기계·기구를 사용**할 때에는 적합한 방호장치를 설치해야 합니다.




## 8

Ажил олгогч нь ажилчныг өндрөөс унах, тээглэж унах аюултай газар, **хамгаалалтын хашлага, нээлхийн таглаа** зэргийг хийх ёстой.

사업주는 근로자가 **추락**하거나 넘어질 위험이 있는 장소에는 **안전 난간, 개구부 덮개** 등을 설치해야 합니다.




## 9

Ажил олгогч нь **гагнах, гагнуураар таслах** ажлын үед **шатамхай, тэсрэмхий бодисыг тусгаарлах хэрэгтэй**.

사업주는 금속의 **용접·용단** 등의 작업 시 **인화성·폭발성 물질을 격리**해야 합니다.




## 10

Ажил олгогч нь ажилчныг **битүү орчинд** ажил гүйцэтгэх байх тохиолдолд **ажил эхлэхийн өмнө болон ажлын дундуур хүчилтөрөгчийн нягтралыг** хэмжих ёстой.

사업주는 근로자가 **밀폐공간**에서 작업하는 경우 **작업 전·작업 중 산소농도** 등을 측정해야 합니다.




Тус зурагт хуудсыг ажлын талбарт, ажилчдад харагдах газар наахыг хүсье.
본 자료는 근로자들이 작업 현장에서 항상 볼 수 있는 장소에 부착하여 주시기 바랍니다.

고용노동부
산업재해예방 안전보건공단

# Химийн бодисын аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах 10 алтан дүрэм

## 화학물질 안전보건 관리 10계명

※ Метилийн спирт, бензин, шингэрүүлэгч зэрэг үйлдвэрлэлд хэрэглэдэг бодисыг химийн бодис гэдэг.
화학물질은 메틸알코올, 벤젠, 신나 등을 포함하여 사업장에서 사용하는 대부분의 물질을 말합니다.

※ Химийн бодисын хор аюултай холбоотой мэдээллийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн агентлагийн Химийн бодисын мэдээллийн цахим хуудаснаас(http://msds.kosha.or.kr) авахыг хүсье.
화학물질 관련정보는 안전보건공단의 화학물질정보 전용 홈페이지(http://msds.kosha.or.kr)를 활용하시기 바랍니다.

### 1

Ажил олгогч нь химийн бодистой ажиллахаас өмнө **ажилчинд Бодисын хор аюулын лавлах мэдээллийг(MSDS)** хүргэнэ.
사업주(관리자)는 화학물질을 취급하기 전에 반드시 **물질안전보건자료(MSDS)를 확보**하여 유해성 및 위험성을 인지하여야 합니다.




### 2

Ажилчинд сайн харагдах газар **Бодисын хор аюулын лавлах мэдээллийг байрлуулж, бодисын сав болон тасалж авсан жижиг саван дээр анхааруулах тэмдгийг заавал наана.**
근로자가 보기 쉬운 장소에 **MSDS를 게시 및 비치**하고, **용기 및 덜어 쓰는 용기 등에 반드시 경고 표지를 부착**하여야 합니다.



### 3

**Химийн бодистой харьцдаг ажилчинд** бодисын хүний биед үзүүлэх нөлөө, бодистой ажиллахдаа анхаарах зүйлийн талаар **сургалт хийнэ.**
**취급근로자**에게 반드시 인체에 미치는 영향, 취급시 주의사항 등에 대한 **교육을 실시**하여야 합니다.




### 4

Ажил гүйцэтгэх үеэр химийн бодисын голомтыг **битүүмжлэх юм уу агааржуулах төхөөрөмж(хэсэгчилсэн агааржуулагч, сэнс) ажиллуулж** химийн бодисонд өртөхөөс хамгаална. (Хэсэгчилсэн агааржуулалтын систем суурилуулах зэргээр ажлын орчинг сайжруулна.)
작업시에는 화학물질 발산원을 **밀폐하거나 환기설비(국소 배기장치, 환풍기 등)를 가동**하여 화학물질에 노출되지 않도록 하여야 합니다.




### 5

**Ажлын орчинг тогтмол хэмжиж үнэлэн,** сайжруулах ёстой.
**정기적으로 작업환경을 측정 및 평가**하고, 작업환경을 개선하여야 합니다.




### 6

Ажилчинд зориулсан нүүр гараа угааж, **усанд орох угаалгын систем суурилуулна.** Ажилчин **ажил дууссаны дараа ажлын хувцас болон бодисонд өртсөн биеийн хэсгээ** угааж цэвэрлэх ёстой.
근로자가 세면 및 목욕 등을 할 수 있도록 **세척시설을 설치**하고, 작업 후에는 **작업복과 노출된 신체부위**를 깨끗하게 세척하여야 합니다.




### 7

Химийн бодис ашигладаг байшин доторх ажлын байранд **тамхи татаж, юм идэж болохгүй.**
화학물질을 취급하는 실내작업장에서는 **담배를 피우거나 음식물을 먹어서는 안됩니다.**




### 8

Ажилчинд **зохих хувийн хамгаалах хэрэгслийг(хорт хийнээс хамгаалах маск, хамгаалалтын хувцас) олгож** хэрэглүүлнэ.
근로자에게 적합한 **개인보호구(방독마스크, 보호복 등)를 지급 및 착용**하도록 관리하여야 합니다.




### 9

Ажилчны эрүүл мэндэд хяналт тавихын тулд **эрүүл мэндийн тусгай үзлэгийг тогтмол** хийж байх ёстой.
근로자 건강관리를 위하여 **정기적으로 특수건강진단을 실시**하여야 합니다.




### 10

Химийн бодистой ажилласнаас болж **биед ямар нэгэн хэвийн бус шинж тэмдэг(бөөлжих, амьсгал боогдох, арьсан дээр юм туурах) илэрвэл байцаагчид заавал мэдэгдэж** эмчид үзүүлэн эмчлүүлнэ.
화학물질 취급으로 **신체에 이상(구토, 호흡곤란, 피부발진 등)이 발생되면 반드시 관리자에게 보고**하고 의사의 적절한 진료를 받아야 합니다.



Тус зурагт хуудсыг ажлын талбарт, ажилчдад харагдах газар наахыг хүсье.
본 자료는 근로자들이 작업 현장에서 항상 볼 수 있는 장소에 부착하여 주시기 바랍니다.

고용노동부
산업재해예방 안전보건공단

2016 - 교육미디어 - 858

# Аж үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ: Ослын хэлбэр болон ажил тус бүрээр

제조업 재해 유형별·작업별 재해 예방대책

## 5 төрлийн гол осол
5대 재해 유형

### 1 Хавчуулагдах 끼임



- Машин механизмын аюултай хэсэгт мэдрэгч, хаалт зэрэг хамгаалах төхөөрөмж суурилуулах хэрэгтэй.
  기계설비의 위험한 부분에는 센서, 덮개 등 방호장치를 설치해야 합니다.
- Засвар үйлчилгээг машин механизмыг заавал зогсоосны дараа хийх бөгөөд асаах хэсэгт цоожлох төхөөрөмж суурилуулах буюу “Засвар хийж байна” гэсэн бичигтэй тэмдэг наана. 정비·수리 등의 작업 시에는 반드시 기계를 정지한 후 작업을 실시하고, 조작부에는 잠금장치 및 ‘수리 중’ 표지판을 설치해야 합니다.

### 2 Гал түймэр / Тэсрэх, хагарах 화재 / 폭발·파열



- Шатамхай бодисоор ажилладаг тоног төхөөрөмж, цистернээс бодис алдагдахгүй байх арга хэмжээ авна.
  인화성 물질 등을 취급하는 설비, 탱크 등은 누출이 없도록 조치해야 합니다.
- Гагнуур хийхдээ гагнуурын оч үсрэхээс хамгаалсан хамгаалалтын бүтээлэг ашиглаж гал унтраагч байрлуулна.
  용접작업 시 불받이포 등 불티 비산을 방지하기 위한 덮개 등 조치를 취하고 소화기를 비치합니다.

### 3 Юманд цохиулах 물체에 맞음



- Сэрээт ачигчаар хүнд жинтэй ачааг зөөхдөө боож багласны дараа зориулалтын тавиур дээр тавьж зөөнө.
  지게차로 중량물을 운반할 때에는 전용 팔레트 등으로 포장하여 운반합니다.
- Краны тороос гэмтсэн бол ашиглахыг хориглоно. Дэгээнд түгжээ хийж, өргөх гэж буй ачаанд тохирсон зориулалтын тэнжээ, ачаа оосорлох хэрэгсэл хэрэглэх шаардлагатай. 크레인에는 손상된 와이어로프 사용을 금지하고 있으며 훅해지장치를 설치하고 인양물에 적합한 전용 줄걸이 용구를 사용해야 합니다.

### 4 Өндрөөс унах 떨어짐



- Ачааны машинаас ачааг буулгахдаа тэвштэй ижил өндөртэй зориулалтын тавцан дээр ажиллана. Ажиллаж байхдаа хамгаалалтын дуулга өмсөнө.
  트럭 하역은 적재함과 높이가 같은 전용 입·출하장에서 작업하고, 작업 시에는 안전모를 착용합니다.
- Том оврын машин механизм болон бүтээгдэхүүн дээр ажиллахдаа өндөрт ажиллах тавцан зэрэг зориулалтын өргөх төхөөрөмж ашиглан, ажлын тавцанг суурилуулна.
  대형설비나 제품 위에서의 작업 시에는 고소작업대 등 전용 승강설비를 사용 하고 작업발판을 설치합니다.

### 5 Мөргөлдөх 부딪힘



- Сэрээт ачигчинд ачаа ачихдаа жолоочийн үзэгдэх хүрээг хаахгүй байхаар ачина. Хурд хэтрүүлэхээс сэргийлж, хурдны хязгаарыг тогтооно.
  지게차 운행 시에는 운전자 시야를 확보할 수 있도록 적재하고, 제한속도를 지정하여 과속하지 않도록 조치해야 합니다.
- Кранаар хүнд жинтэй ачааг өргөхдөө ачааг хажуу тийш хазайлгалгүй нэг түвшинд өргөнө. Өргөсөн ачааг краны жолооч болон зэргэлдээ ажиллаж байгаа ажилчинд ойртуулж болохгүй.
  크레인으로 중량물을 인양할 때에는 물건이 기울지 않도록 수직으로 인양하고, 작동하는 사람이나 인근 근로자 근처로 이동시키지 않아야 합니다.

## 5 төрлийн ажил
5대 작업

### 1 Кран ашигладаг ажил 크레인 취급 작업



- Даац хязгаарлагч зэрэг ослоос хамгаалах хэрэгслээр тоноглож, хэвийн ажиллагааг нь хангана.
  과부하방지장치 등 크레인 방호장치를 설치하고 기능을 유지해야 합니다.
- Краны дээд дамнуургын шалгах шугамын аюулгүй байдлыг хангаж, хамгаалах бүс бэхлэх дэгээ суурилуулах болон хамгаалах бүс зүүх журмыг мөрдөнө. 크레인 상부레일의 점검통로를 확보하고, 안전대 걸이 설치 및 안전대 착용을 준수합니다.
- Ачаа өргөх буулгах бүсэд ажилчин орохыг хориглоно.
  인양물 운반 구간에는 근로자가 출입하지 않도록 해야 합니다.

### 2 Сэрээт ачигч ашигладаг ажил 지게차 취급 작업



- Сэрээт ачигч жолоодох эрхтэй ажилчин жолоодно. Ачааг тэнцвэртэй ачина. Зориулалтын тавиур хэрэглэнэ.
  지게차 운전자는 유자격자로 하고, 지게차 포크에 화물 적재시 기울어지지 않도록 하고 반드시 전용 팔레트를 사용 합니다.
- Налуу газар гэнэт эргэхийг хориглоно. Жолооч суудлын бүсээ заавал зүүнэ.
  경사면에서의 급선회를 금지하고, 지게차에 좌석 안전띠 설치 및 착용을 준수해야 합니다.

### 3 Зөөврийн шат ашигладаг ажил 사다리 취급 작업



- Шатны дээд тал, шатны түшүүлсэн цэгээс хамгийн багадаа 60 см илүү гарсан байхаар байрлуулна.
  사다리의 상단은 걸쳐 놓은 지점으로부터 60cm 이상 올라가도록 설치 합니다.
- Шатаар өгсөж буухдаа хоёр гараараа шатны хоёр талаас барьж байх ёстой. Үүний тулд гартаа ямар нэгэн зүйл барьж өгсөж, буухыг хориглоно.
  사다리 승·하강 시 두 손이 답단을 잡을 수 있도록 물건을 손에 든 채 오르내리는 것을 금지합니다.

### 4 Лифт ашигладаг ажил 리프트 취급 작업



- Лифтэнд даац хязгаарлагч, мушгиралт хязгаарлагч, ослын зогсоох товчлуур зэрэг хамгаалах төхөөрөмж суурилуулж, даацын дээд хязгаарыг тэмдэглэж, мөрдөнө.
  리프트에 과부하방지, 권과방지, 비상 정지장치 등 방호장치를 설치하고 정격 하중을 표시하여 준수합니다.
- Лифтэнд хаалга хийж, хаалга онгорхой үед лифт ажиллахгүй байхаар холбоос цоож хийх хэрэгтэй.
  리프트 출입문을 설치하고 개방 시에는 작동되지 않도록 연동장치를 설치해야 합니다.

### 5 Туузан дамжуурга ашигладаг ажил 컨베이어 취급 작업



- Туузан дамжуургад засвар үйлчилгээ хийх, шалгах зам хийж, унахаас сэргийлэх арга хэмжээ авна.
  컨베이어 보수·점검용 통로 설치 및 추락방지 조치를 실시합니다.
- Засвар үйлчилгээ хийхийн өмнө хяналтын хэсгийг цоожилно. Мөн “Засвар үйлчилгээ хийж байна” гэсэн тэмдэг хадна.
  정비, 수리작업 중 조작부에는 잠금장치 및 수리 중 표지판을 설치합니다.

Тус зурагт хуудсыг ажлын талбарт, ажилчдад харагдах газар наахыг хүсье.
본 자료는 근로자들이 작업 현장에서 항상 볼 수 있는 장소에 부착하여 주시기 바랍니다.

고용노동부
산업재해예방 안전보건공단

# Үйлдвэрлэлийн химийн ослоос урьдчилан сэргийлэх 10 алтан дүрэм

## 제조업 화학사고* 예방관리 10계명

※ Химийн бодис ашигладаг үйлдвэрлэлийн үеэр тоног төхөөрөмж доголдох, хяналт хамгаалалт сул байснаас гарсан гал түймэр, тэсрэлт, химийн бодист өртөх зэрэг ослуудыг химийн осол гэдэг.
화재·폭발·누출 등 화학물질을 취급하는 공정에서 설비결함 및 관리소홀로 발생할 수 있는 사고를 말합니다.

## 1

Химийн бодистой ажиллахын өмнө **Бодисын хор аюулын лавлах мэдээлэлд(MSDS) дурдсан хортой болон аюултай шинж чанарыг** мэдэж авах ёстой бөгөөд зохих **хамгаалах хэрэгслийг** хэрэглэнэ.

화학물질을 취급하기 전에 반드시 **물질안전보건자료(MSDS)의 유해성·위험성**을 숙지하고 적절한 **보호구**를 착용하여야 합니다.



## 2

**Химийн бодисыг** онцлог, шинж чанарын нь дагуу ангилж хадгална. Ажлын байранд аль болох хадгалахгүй байхыг хичээх бөгөөд **Бодисын хор аюулын лавлах мэдээлэл(MSDS), анхааруулах тэмдгийг** нааж, аюулгүй газар хадгалах хэрэгтэй.

**화학물질**은 물질의 특성에 따라 구분하여 작업**장 내 보관을 최소화하고 MSDS 게시·경고 표지를 부착**하여 안전한 장소에 보관하여야 합니다.




## 3

Химийн бодис ашигладаг **тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийхдээ аюулгүй ажиллагааны зөвшөөрөл олгож, хариуцсан ажилтанг томилох** зэргээр аюултай хүчин зүйлд тавих хяналтыг нэмэгдүүлнэ.

화학설비 **정비·보수 작업 시 안전작업 허가서 발행, 관리감독자 배치** 등 위험요인 관리를 강화 하여야 합니다.




## 4

**Хамгаалалтын хавхлага, тэсрэхээс хамгаалах хэрэгсэл, ослын хавхлага, дотроос тургих галнаас хамгаалах хэрэгслээр** тоноглон, хэвийн ажиллагааг нь тогтмол шалгах ёстой.

**안전밸브, 파열판, 역화방지기, 긴급차단밸브** 등 적절한 **안전 장치**를 설치하고 정상작동 여부를 정기적으로 확인하여야 합니다.




## 5

Аюултай бодис ашигладаг үйлдвэрлэлийн шат дамжлага дээр **гал, оч, статик цахилгаан, үрэлт, тамхидалт** зэрэг галын эх үүсвэр гарахаас хамгаалах хэрэгтэй.

위험물을 취급하는 공정에서는 **불꽃, 스파크, 정전기, 충격, 마찰, 흡연 등 화재** 원인이 발생하지 않도록 관리하여야 합니다.




## 6

**Гал ашиглан хийх** ажлын үеэр шатамхай хий, асамхай бодис зэрэг **аюултай бодисыг холдуулж, гагнуурын оч үсрэхээс хамгаалсан хаалт хийж, гал унтраагч байрлуулах** зэргээр аюулгүйн арга хэмжээ авах хэрэгтэй.

**화기작업** 시에는 인화성 가스, 가연성 물질 등 **위험물을 제거 (확인 포함)하고 용접불티 비산 방지 덮개 설치, 소화기 비치** 등 안전조치를 하여야 합니다.




## 7

**Шатамхай шингэн бодисын уур, хий, хатуу биетээс болж тэсрэх аюултай газар тэсрэхээс хамгаалсан бүтэцтэй цахилгаан тоног төхөөрөмж** суурилуулж, байнга **агааржуулж** байх хэрэгтэй.

**인화성 액체의 증기·가스 또는 고체**로 인해 **폭발 위험이 있는 장소에는 방폭구조의 전기 기계·기구를 설치**하고 **환기**를 자주 실시하여야 합니다.




## 8

**Химийн бодисыг холих, халаах үед хэт халах, задрах зэрэг хэвийн биш урвал явагдаж буй** эсэхийг мэдэхийн тулд **температур хэмжигч, даралт хэмжигч, урсгалын хэмжээ хэмжигч зэрэг тоноглолоор тоноглож**, гадны биет орохоос хамгаалах хэрэгтэй.

**화학물질 혼합·가열** 시에는 **발열·분해 등 이상반응**을 파악하기 위하여 **온도계·압력계·유량계 등의 계측장치**를 설치하고, **이물질이 혼입**되지 않도록 하여야 합니다.




## 9

Химийн бодис хадгалдаг, химийн бодисоор ажилладаг тоног төхөөрөмжийн хоолойн **холбоос хэсэг**, хавхлагаар **бодис алдагдахгүй байхад хяналт тавьж, тогтмол шалгах** хэрэгтэй.

화학물질 저장 및 취급설비의 **배관 연결부, 밸브** 등은 **새지 않도록 유지하고 수시로 누출여부 확인** 등 유지보수를 강화하여야 합니다.



## 10

Аюултай бодисыг **шингэн төлөвт хадгалах бол хамгаалалтын хана** босгож түүн дотор хадгалах хэрэгтэй. Ингэснээр сав гэмтэж бодис асгарсан үед **бодис гадагш тархахаас** хамгаална.

위험물질을 **액체상태로 저장**할 경우, 저장설비 파손에 의한 누출 시 **외부 확산을 방지**하기 위해 **방유제**를 설치하고 균열 등 누출 위험 요인이 없도록 하여야 합니다.




Тус зурагт хуудсыг ажлын талбарт, ажилчдад харагдах газар наахыг хүсье.
본 자료는 근로자들이 작업 현장에서 항상 볼 수 있는 장소에 부착하여 주시기 바랍니다.

고용노동부
산업재해예방 안전보건공단

2016 - 교육미디어 - 856

# Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны 10 алтан дүрэм

## 장비별 공통 안전수칙 10계명



1 **Ажил эхлэхийн өмнө тоног төхөөрөмж болон орчин тойрны аюулгүй байдлыг шалгана.**
작업시작 전 장비 및 주변 안전점검을 실시합니다.

2 **Тоног төхөөрөмжийн төрөл, хүчин чадал, ажиллах зам, ажиллуулах арга зэргийг тусгасан ажлын төлөвлөгөөг боловсруулан гаргана.**
기계의 종류 및 능력, 운행경로, 작업방법 등의 작업계획서를 작성합니다.

3 **Чиглүүлэгч болон дохиологчийг томилж, ижил аргаар дохио өгнө.**
유도자 또는 신호수를 배치하고 일정한 방법으로 신호를 주고받습니다.

4 **Унах, мөргөлдөхөөс хамгаалах арга хэмжээ авна.**
전도, 접촉 등의 방지를 위한 조치를 실시합니다.

5 **Тоног төхөөрөмжийг зориулалтаас бусад зүйлд хэрэглэхийг хориглоно.**
장비별 용도 외의 사용을 제한합니다.

6 **Даацын хязгаарлалтыг мөрдөнө.**
허용 하중 초과 등의 제한 내용을 준수해야 합니다.

7 **Засвар үйлчилгээ хийх үед аюулгүйн тээглүүр суурилуулж, ажлын дэс дарааг баримтлана.**
정비·수리 등의 작업 시 안전블록을 설치하고, 작업순서를 지켜야 합니다.

8 **Хурдны хязгаарын биелэлтэнд хяналт тавина.**
제한 운행속도 표지 및 준수에 대한 관리감독을 철저히 합니다.

9 **Тоног төхөөрөмжийг зөвхөн мэргэжлийн оператор ажиллуулна.**
유자격 운전원 배치를 반드시 확인합니다.

10 **Жолооч машинаас буухдаа моторыг унтрааж, тоормосоо татна.**
운전석 이탈 시 엔진을 정지하고 브레이크를 작동해야 합니다.

### Экскователор 굴삭기



- Шанага салахаас сэргийлсэн аюулгүйн тогтоогч хэрэглэнэ. 버켓 탈락방지용 안전핀 설치
- Налуу газар унахаас сэргийлж аюулгүй зорчих зам гаргана. 비탈면 전도방지 위한 작업경로 확보
- Ухрах дуут дохио хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгана. 후진 시 경보장치 작동상태 확인
- Малтлага хийхээс бусад зорилгоор ашиглахыг хориглоно. 양중작업 등 목적 외 사용금지
- Жолооч суудлын бүсээ заавал зүүнэ. Бүхээгт өөр хүн суулгахыг хориглоно. 운전원 안전벨트 착용 및 승차석 이외에 근로자 탑승 금지

### Зөөврийн кран 이동식크레인



- Аюулгүй байдлыг баталгаажуулсан KCs тэмдэгтэй эсэхийг шалгана(2009 оны 10 сарын 1-ний өдрөөс хойш үйлдвэрлэсэн) 안전인증(KCs) 여부 확인('09.10.1 이후 출고 제품)
- Тулгуурын доод хэсгийг цөмрөхөөс хамгаална. 아웃트리거 하부에는 침하 방지 조치
- Дэгээний түгжээ хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгана. 후크 해지장치 정상작동 확인
- Ачаа өргөх үед ажлын бүсэд хүн орохыг хориглоно. 물체 인양 시 작업반경 내 근로자 접근 통제 조치
- Өндөр хүчдэлийн шугам зэрэг орчин тойронд байх аюултай хүчин зүйлийг илрүүлнэ. 고압선 등 주변 장애물 위험요인 파악
- Оосорлох хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгана. 줄걸이 용구의 사용상태 확인
- Ачааны бэхэлгээг шалгана. 2 узүүртэй оосрыг шалгана. 인양자재 묶음상태 및 2줄 걸이 확인

### Өөрөө буулгагч 덤프트럭



- Газар цөмрөх зэрэг эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. 노견 붕괴, 지반 침하 등의 위험 사전 방지 조치
- Ухрах дуут дохио хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгана. 후진 시 경보장치 작동상태 확인
- Тоормосны хэвийн ажиллагаа шалгана. 브레이크 작동상태 확인 철저
- Жолооч машинаас буухдаа тоормосоо татна. 운전위치 이탈 시에는 브레이크 조치
- Дугуйн элэгдлийг шалгана. 타이어 마모상태 확인

### Өндөрт байрлах ажлын тавцан 고소작업대



- Аюулгүй байдлыг баталгаажуулсан KCs тэмдэгтэй эсэхийг шалгана(2009 оны 07 сарын 1-ний өдрөөс хойш үйлдвэрлэсэн) 안전인증(KCs) 여부 확인('09.7.1 이후 출고 제품)
- Суурилуулах гэж буй газрын гадарга тогтвортой, тэгш эсэхийг шалгана. 설치장소의 지반 다짐 및 수평상태 확인
- Тулгуур болон ивээс тохиромжтой эсэхийг шалгана. 아웃트리거 및 받침대 적정여부 확인
- Ажилчин, ажлын тавцанд суухдаа хамгаалах бүс хэрэглэнэ. 작업대에 근로자 탑승 시 안전대 사용
- Ажлын бүсэд хүн орохыг хориглоно. 작업반경 내 근로자 출입통제 실시
- Ажлын тавцангийн даацыг хэтрүүлж болохгүй. 작업대는 정격하중을 초과하지 않도록 조치
- Ажлын тавцангийн бэхэлгээ, холболтыг урьдчилан шалгана. 작업대 고정 및 연결상태 사전점검

### Сэрээт ачигч 지게차



- Жолоочийн үзэгдэх орчинг чөлөөлнө. 운전자의 시야 확보
- Сэрээт ачигчийн даацыг хэтрүүлэхгүй ажиллана. 지게차의 허용 하중을 초과하지 않도록 운행 실시
- Ухрах дуут дохиогоор тоноглож хэвийн ажиллагаар шалгана. 후진 경보장치를 설치하고 후진 시 작동상태 확인
- Сэрээн дээр хүн суулгахыг хориглоно. 포크리프트 위에 탑승 금지
- Анхааруулах гэрлэн дохиогоор тоноглож хэрэглэнэ. 경광등 설치 사용

**Тус зурагт хуудсыг ажлын талбарт, ажилчдад харагдах газар наахыг хүсье.**
본 자료는 근로자들이 작업 현장에서 항상 볼 수 있는 장소에 부착하여 주시기 바랍니다.

고용노동부 산업재해예방 안전보건공단

2016 - 교육미디어 - 855

# Барилгын үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах 10 алтан дүрэм

## 건설업 안전보건관리 10계명

## 1

**Ажил эхлэхийн өмнө аюулгүй байдлыг шалгаж, ажлын дундуур ажлын байрыг эмх цэгцтэй** байлган, гарч болох аюулыг урьдчилан зайлуулж, хориотой бүсийг тогтоон ажиллах явдлыг хэвшил болгох хэрэгтэй.

**작업 전 안전점검**과 **작업 중 정리 정돈** 상태를 확인하여 위험을 사전에 제거 또는 통제한 후 작업 하는 것을 습관화해야 합니다.




## 2

Ажил олгогч нь хортой аюултай хүчин зүйлээс ажилчныг хамгаалахын тулд хамгаалах дуулга, хамгаалалтын гутал, хамгаалах бүс зэрэг зохих **хувийн хамгаалах хэрэгслийг** олгож, хэрэглүүлнэ.

사업주는 근로자가 노출될 수 있는 유해 위험요인으로부터 보호가 되도록 안전모, 안전화, 안전대 등 적정 **개인보호구**를 지급하고 착용하도록 하여야 합니다.




## 3

Өндрөөс унах аюултай ажлын үед 40 см-ээс дээш өргөнтэй бат бөх ажлын тавцан суурилуулж, хажуу талд нь түүнд тохирсон **хамгаалалтын хашлага** хийж унах ослоос хамгаална.

떨어짐 위험 작업 시에는 폭 40cm 이상의 견고한 **작업발판**을 설치 하고, 측면에는 적합한 **안전난간**을 설치하여 떨어짐 재해를 예방 하여야 합니다.




## 4

Барилгын тоног төхөөрөмжийг хэрэглэхдээ тоног төхөөрөмжийн төрөл, хүчин чадал, ажиллуулах арга, явах зам зэргийг багтаасан **ажлын төлөвлөгөө** боловсруулан гаргаж мөрдөх бөгөөд, чиглүүлэгчийг томилон ажиллуулана.

건설장비는 장비종류 및 능력, 작업방법, 운행경로가 포함된 **작업계획서**를 반드시 작성하여 이행하고 **유도자**를 배치하여야 합니다.




## 5

Нээлхийг бат бөх **таглаагаар** унаж холбирохооргүй сайтар таглаж, харанхуй газар ч гэсэн ялгаж харахаар **тэмдэглэх** хэрэгтэй.

개구부에는 충분한 강도를 지닌 **덮개**를 뒤집히거나 떨어지지 않도록 설치하고, 어두운 장소에서도 식별이 가능하도록 **표시**를 하여야 합니다.




## 6

Тогонд цохиулах ослоос урьдчилан сэргийлэхийн тулд цахилгаан төхөөрөмжийн **газардуулагч, хүчдэл таслагч** хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгаж, шаардлагатай тохиолдолд тэжээлээс салгасны дараа ажлаа эхлэнэ.

감전재해를 예방하기 위해서는 가설전기의 **접지**상태 및 **누전 차단기** 작동여부 등을 확인하고필요 시 정전 후 작업을 실시하여야 합니다.




## 7

Өндрөөс унах аюултай газар ажлын тавцан суурилуулах боломжгүй тохиолдолд унахаас хамгаалдаг **хамгаалалтын торыг** ажлын гадаргуунд ойрхон байрлалд татах хэрэгтэй.

떨어짐 위험이 있는 장소에서 작업발판 설치가 곤란한 경우에는 추락방지용 **안전방망**을 작업 면에서 가까운 지점에 설치하여야 합니다.




## 8

Хэв хашмалын тулаасыг угсрах буюу тайлах үедээ тулаасны бүтцийг шалгасны дараа **угсралтын зургийг** гаргаж, тус зургийн дагуу ажлаа гүйцэтгэх ёстой.

거푸집 동바리 조립 및 해체 작업 시에는 거푸집 동바리 구조 검토 후 **조립도**를 작성하고, 이를 준수 하여 작업을 실시하여야 합니다.




## 9

Зөөврийн шат нь **бат бөх бүтэцтэй** байна. **Гишгүүр нь ижил зайтай,** түшүүлсэн хэсэг нь дээшээ **60 см-ээс илүү** байх ёстой. Шат дэлгэдэх, унахаас хамгаалах арга хэмжээ авна.

사다리 설치 시 **견고한 구조**, **일정 답단** 간격 유지, 걸침 부위 **60cm이상** 여장 확보, 벌어짐 및 전도방지 조치를 하여야 합니다.




## 10

Ажлын шат суурилуулахдаа стандартын дагуу хананд бэхэлж, **даацын хязгаарлалтыг** чанд мөрдөнө. Ажлын шатыг буулгахдаа ажлын дэс дараалыг тогтоож, **байцаагч ажлыг биечлэн удирдана**.

비계 작업 시에는 벽 연결을 규정 대로 설치하고 **최대 적재하중**을 준수하며 해체 시 작업순서를 정하여 **관리감독자가 지휘**하여야 합니다.




Тус зурагт хуудсыг ажлын талбарт, ажилчдад харагдах газар наахыг хүсье.

본 자료는 근로자들이 작업 현장에서 항상 볼 수 있는 장소에 부착하여 주시기 바랍니다.

고용노동부
산업재해예방 안전보건공단

2016 - 교육미디어 - 854

# Үйлчилгээний ажлын аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах 10 алтан дүрэм

## 서비스업 안전보건관리 10계명



### 1

Ус болон тос асгарсан газар ажиллахдаа **хальтардаггүй ултай гутал** өмсөх хэрэгтэй.

물이나 기름이 있는 장소에서 작업을 하는 경우에는 **미끄럼 방지 신발**을 착용하여야 합니다.



### 2

Өндөр газар ажиллах үед **хамгаалах дуулга болон хамгаалах бүс** зүүж, хоёулаа ажиллах хэрэгтэй.

높은 장소에서 작업을 하는 경우에는 **안전모와 안전대**를 착용하고 2인 1조로 작업하여야 합니다.



### 3

Хүнд зүйлийг **тэргэнцрээр зөөх** буюу **хоёулаа хамт** өргөж зөөх хэрэгтэй.

무거운 물건은 **이동대차 또는 2인 1조**로 운반하여야 합니다.



### 4

Мотоциклийн жолооч **зориулалтын дуулга өмсөж, замын хөдөлгөөний дүрмийг баримтлах** ёстой.

이륜차 운전자는 **승차용 안전모를 착용하고 교통법규를 준수** 하여야 합니다.



### 5

Халуун хоолыг **тэргэнцрээр** зөөнө. Мөн **түлэгдэхээс хамгаалж бээлий** өмсөх хэрэгтэй.

뜨거운 음식 등은 **이동대차**로 운반 하고 **화상방지 장갑**을 착용하여야 합니다.



### 6

Ил гал хэрэглэдэг газар байнга **гал унтраагч** байрлуулах хэрэгтэй.

화기를 사용하는 장소에는 반드시 **소화기**를 비치하여야 합니다.




### 7

Гадны хүнээр засвар үйлчилгээ хийлгэх бол ажил олгогч **аюулгүй ажиллагааны зөвшөөрөл** олгож, **хариуцсан ажилтанг** томилон ажилуулна.

외부인에 의한 수리 · 점검 작업을 하는 경우 원청사에서 **안전작업 허가서**를 발급하고, **작업관리자**를 배치하여야 합니다.



### 8

Шал угаах, зөөврийн шат ашиглан ажил гүйцэтгэх бол **аюулгүй бүсийг** тогтоох хэрэгтэй.

바닥 물청소, 사다리 등을 설치 하여 작업하는 경우에는 **안전 라인(Safety Line)**을 설치 하여야 합니다.




### 9

Шатны ирмэг болон налуу зам дээр хальтрахаас хамгаалсан наалт наана.

계단 끝단과 경사진 통로에는 **미끄럼 방지조치**를 하여야 합니다.



### 10

Шөнийн ээлжний ажилчин **эрүүл мэндийн тусгай үзлэгт** хамрагдах ёстой.

야간작업 근로자는 **특수건강 진단**을 받아야 합니다.



Тус зурагт хуудсыг ажлын талбарт, ажилчдад харагдах газар наахыг хүсье.

본 자료는 근로자들이 작업 현장에서 항상 볼 수 있는 장소에 부착하여 주시기 바랍니다.

고용노동부
산업재해예방 안전보건공단

2016 - 교육미디어 - 853

# Зөөврийн шат ашиглахад аюулгүй ажиллах 10 алтан дүрэм

## 사다리작업 안전보건관리 10계명



## 1

Эвдрэл гэмтэлгүй, бат бөх зөөврийн шат хэрэглэнэ.

사다리는 손상 · 부식 등이 없는 **견고한 구조**의 것을 사용하여야 합니다.




## 2

Зөөврийн шатыг тэгшхэн гадаргуун дээр хөдөлгөөнгүй суурилуулах хэрэгтэй.

사다리는 바닥이 **평평한 장소**에 흔들림이 없도록 설치하여야 합니다.



## 3

Зөөврийн шатаар өгсөхдөө хамгаалах дуулга, хамгаалах бүс өмсөж зүүх хэрэгтэй.

사다리에 오르는 작업을 하는 경우에는 **안전모와 안전대**를 착용하여야 합니다.



## 4

Зөөврийн шатыг хөл хөдөлгөөн ихтэй газар тавих тохиолдолд ажлын байрны эргэн тойронд ойртохыг хориглосон тэмдэг байрлуулж, чиглүүлэгчийг томилно.

사다리를 통행이 빈번한 장소에 설치할 경우에는 작업 장소 주변에 **접근금지 표지판**을 설치하고, **유도자**를 배치하여야 합니다.




## 5

Зөөврийн шат ашиглан ажиллахдаа заавал хоёулаа ажиллана.

사다리 작업은 반드시 **2인 1조**로 실시하여야 합니다.



## 6

Эвхдэг зөөврийн шатыг эвхэгдэх буюу дэлгэгдэхээс хамгаалж түгжээ хийх ба унахаас хамгаалж тулаас хийх хэрэгтэй.

접이식(A형) 사다리는 접히거나 펼쳐지지 않도록 **벌어짐 방지장치** (Locking)를 설치하고 넘어짐 방지를 위해 아웃트리거 등을 설치하여야 합니다.



## 7

Түшүүлж тавьсан шулуун шатны дээд хэсэг түшүүлсэн хэсгээс дээшээ наад зах нь 60 см илүү гарч байхаар тавина.

일자형 사다리의 상단은 걸쳐 놓은 부분으로부터 **60cm 이상** 올라가도록 설치하여야 합니다.




## 8

Зөөврийн шатыг зорчих зам болгон суурилуулахдаа налуур нь 70 градусаас хэтрүүлж болохгүй.

이동식 사다리를 통로로 설치하는 경우 기울기는 **70도 이하**로 유지 하여야 합니다.



## 9

7 метрээс өндөр хөдөлгөөнгүй шатыг суурилуулахдаа шалнаас дээш 2,5 метрийн цэгээс эхлэн арын хаалт хийнэ.

고정식 사다리의 높이가 7m 이상인 경우에는 바닥으로부터 높이가 2.5m 되는 지점부터 **등받이 울**을 설치하여야 합니다.




## 10

Зөөврийн шат ашиглан тавьсан зам 10 метрээс урт байх тохиолдолд 5 метр тутам шатны тавцан суурилуулна.

사다리식 통로의 길이가 10m 이상인 경우에는 **5m 이내 마다 계단참을 설치**하여야 합니다.




Тус зурагт хуудсыг ажлын талбарт, ажилчдад харагдах газар наахыг хүсье.

본 자료는 근로자들이 작업 현장에서 항상 볼 수 있는 장소에 부착하여 주시기 바랍니다.

고용노동부 | 안전보건공단